

ХҮЧИРХЭГЖИХ УХААН

БОЛОМЖ ДҮҮРЭН ЕРТӨНЦИЙГ ХАМТДАА БҮТЭЭ

Мэргэжилтнүүдэд зориулав

Токи Анмэ

*Empowerment
Sciences*



ХҮЧИРХЭГЖИХ УХААН

БОЛОМЖ ДҮҮРЭН ЕРТӨНЦИЙГ ХАМТДАА БҮТЭЭ

Мэргэжилтнүүдэд зориулав

Зохиогч: Профессор Токи Анмэ, PhD
Орчуулагч, IV бүлгийн зохиогч: Ган-Ядамын Амарсанаа, PhD

*Empowerment
Sciences*



ХҮЧИРХЭГЖИХ УХААН / EMPOWERMENT SCIENCES
БОЛОМЖ ДҮҮРЭН ЕРТӨНЦИЙГ ХАМТДАА БҮТЭЭЕ

Мэргэжилтнүүдэд зориулав

Хэвлэгдсэн огноо: 2018 / 3 / 26

Монгол хэлнээ хөрвүүлэн хэвлэсэн огноо: 2026 / 5 / 25

Зохиогч: Токи Анмэ, Ph.D.

Орчуулагч, IV бүлгийн зохиогч: Ган-Ядамын Амарсанаа, Ph.D.

Япон улсын Цүкүба Их Сургуулийн Анагаах ухааны факультетийн
Хүчирхэгжих ухаан, Олон улсын хүний хөгжил судлалын тэнхим

ISBN: 978-4-88924-257-7

ЗОХИОГЧИЙН ӨМНӨХ ҮГ

Хүчирхэгжих гэдэг нь хүн бүр өөрийн амьдралдаа эзэн байж, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, харилцан хүндэтгэх замаар хамтын оролцоонд тулгуурласан **“боломжоор дүүрэн ертөнц”**-ийг цогцлоох ухаан юм.

Хүчирхэгжүүлэх үйл явц нь хүмүүст итгэл найдвар, мөрөөдөл, урам зориг, амьдрах эрч хүчийг бэлэглэдэг. Энэ нь хүн бүрийн сэтгэл зүрхэнд зайлшгүй байх ёстой гайхамшигт чанар юм.

Хүн бүр өөрийн гэсэн гайхамшигт чадвартай бөгөөд амьдралынхаа туршид энэхүү чадвараа улам өнгөлж, тодоос тод харуулах боломжтой. Тасралтгүй ундрах рашаан адил бидний дотор нуугдан орших тэр их хүчийг ил гаргахад хүчирхэгжих үйл явц түлхэц болдог. Хүчирхэгжилт нь бидний дотор нуугдмал орших агуу их хүч, нөөц боломжийг сэргээж, дэвжин дэлгэрэх замыг нээдэг.

Эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний практикт хувь хүний дотоод нөөц боломжийг сэргээж, түүнийг үр дүнтэй ашиглахыг дэмжсэнээр тухайн хүн өөрийн болон бусдын амьдралыг сайжруулж, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах нөхцөл бүрдэнэ. Бүлэг, хамт олны хувьд, тухайлбал бизнесийн байгууллагад ажилтан бүрийн чадвар, эрч хүчийг зөв тодорхойлж, байгууллагын хөгжилтэй уялдуулан хөшүүрэг болгон ашиглавал ажилтны хөгжлийн түвшин ахиж, байгууллагын өсөлтөд бодит үр дүн гарна. Товчоор хэлбэл, хүчирхэгжилт нь хувь хүн, баг хамт олон, байгууллагын хөгжилд чухал ач холбогдолтой юм.

Өнөөгийн нөхцөлд **хүний хөгжил, эрүүл мэнд, нийгмийн тогтолцоо** асар их өөрчлөлтийн ирмэг дээр байна. Тиймээс мэргэжлийн хүмүүсийн ур чадварыг **Empowerment Sciences** буюу **Хүчирхэгжих Ухаанд** тулгуурлан нэмэгдүүлэх шаардлага урьд өмнөхөөс илүүтэйгээр чухал болж байна. Тогтолцоо хэрхэн өөрчлөгдсөнөөс үл хамааран, хүмүүсийг дэмжих эхлэл нь тэдэнд туслах, мөн насан туршдаа өсч хөгжих боломж, орон зайг бүрдүүлэх явдал юм.

Практик туршлагаас урган гарсан ойлголтууд нь мэргэжилтнүүдийн мэргэжлийн сэтгэлгээ, ур чадварыг хөгжүүлэхэд шаардлагатай механизмуудыг тогтмол тодорхойлж ирсэн бөгөөд энэ нь мэргэжлийн сэтгэлгээнд тулгуурлан, хүмүүсийн эрх ашгийг ямар ч үед хамгаалахын төлөө бүх хүчин чармайлтыг дайчлан хэрэгжүүлэх арга зүй болдог. Сүүлийн 30 жилийн турш хийгдсэн урт хугацааны судалгааны үр дүнд бид хувь хүн, хамт олон, нийгмийн чадавхийг хөгжүүлэхэд шаардлагатай нотолгоонд суурилсан мэргэжлийн ур чадваруудыг тодорхойлон гаргасан.

Энэхүү номын зорилго нь ажиглалт, туршилт, судалгааны бодит өгөгдөлд суурилсан эмпирик нотолгоо болон шинжлэх ухаанд тулгуурласан хүчирхэгжих ур чадварыг танилцуулж, олны хүртээл болгоход оршино. Нэмж дурдахад энэ ном нь эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний салбарт нэгэнт бий болсон сайн туршлагыг улам боловсронгуй болгох, дэмжих зорилготой.

Мэргэжилтнүүдэд зориулан боловсруулсан хүчирхэгжих ухаан нь дараах шалгуур үзүүлэлт, арга аргачлалыг ашиглан хүний хөгжил, эрүүл мэндийн чанарыг сайжруулах тогтолцоог хөгжүүлэх зорилгоор боловсруулагдсан болно:

- Хүүхдийн хөгжлийн шалгуур үзүүлэлт
- Нийгэмшихүйн ур чадварын үнэлгээ
- Онцгой анхаарал шаардлагатай хүүхдийг ажиглаж үнэлэх хуудас
- Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчны шалгуур үзүүлэлт
- Байгууллагад суурилсан хүүхэд асран хүмүүжүүлэх орчны индекс

Дээрх аргачлалууд нь эмпирик нотолгоо болон туршлагад суурилсан шинжлэх ухаанч тогтолцоо юм. Судалгааны нотолгоог олон цагийн судалгааны явцад цуглуулж, судалгааны үр дүнд үндэслэн баталгаажуулсан болно.

Номын эхний хэсэгт онолын үндсийг дэлгэрэнгүй тайлбарласан бол дараагийн хэсэгт уг онолыг амьдралд хэрхэн хэрэгжүүлэх талаар практик зөвлөмжүүдийг тусгасан. Тус ном нь мэдээллийн эрин үед шаардагдаж буй мэдээлэл ашиглах шинэ хэлбэрүүд, хувь хүний хүсэл тэмүүллийг дэмжих, мөн холбогдох талуудын хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн шинэлэг аргачлалуудыг багтаасан. Энэхүү бүтээл нь уншигчдад практик ур чадварыг дараах хоёр үе шаттайгаар эзэмших боломжийг олгоно:

1. Эхний хэсэгт нотолгоо, үр дүнд суурилсан практикт хэрэгжүүлж болох хүчирхэгжих онол, зарчим, загваруудыг тайлбарласан болно.
2. Хоёрдугаар үе шатанд нотолгоонд суурилсан практик арга барилыг тайлбарлан, хүчирхэгжих үйл явцыг дэмжих загвар болон хэрэгжүүлэх боломжтой аргачлалуудыг танилцуулсан.

Энэхүү ном нь таныг насан туршид өөрийгөө хүчирхэгжүүлэхэд хөтөлж, мэргэжлийн өсөлт, хөгжилд дэмжлэг үзүүлэн, илүү өндөр түвшинд хүрэх хүсэл тэмүүллийг тань бадраана гэдэгт итгэлтэй байна.

СУДЛААЧ-ОРЧУУЛАГЧИЙН ОРШИЛ

Энэхүү ном нь хүн төвтэй хөгжлийг дэмжих, хувь хүний дотоод нөөц боломжийг нээн илрүүлэх, хамтдаа хөгжих арга ухааныг онол, арга зүй, практикийн түвшинд нэгтгэн цогцоор нь харуулсан бүтээл юм. Хүний хөгжил, ялангуяа хүүхдийн өсөлт хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр задлан шинжилж, нотолгоонд суурилсан үнэлгээ, дэмжлэгийн аргачлалуудыг системтэйгээр тусгасан нь уг бүтээлийн гол онцлог болно.

Хүчирхэгжих онол нь хүн бүр өөрийн амьдралын эзэн байж, бусдын ялгаатай байдлыг хүндэтгэн, хамтын оролцоонд тулгуурласан нийгмийг цогцлоох боломжийг илэрхийлдэг. Олон жилийн судалгаанд суурилсан уг онол, аргачлал нь Монголын өнөөгийн нийгэмд зөв төлөвшилтэй иргэнийг бэлтгэх, гэр бүлийн харилцааг сайжруулах, хүүхдийн нийгэмшихүйн ур чадварыг багаас нь хөгжүүлэх, байгууллагад суурилсан хөгжлийн дэмжлэг үзүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Мөн хүүхдийн хөгжлийн хоцрогдлыг эрт илрүүлэх, онцлог хэрэгцээтэй хүүхдийг ойлгон дэмжих, хөгжүүлэхэд шаардлагатай шалгуур үзүүлэлтүүдийг хэрэглээнд ойр байдлаар тусгасан нь энэ бүтээлийн нэгэн давуу тал юм.

Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл явцад эцэг эх, багш, мэргэжилтнүүдийн хандлага, мэдлэг, ур чадвар шийдвэрлэх үүрэгтэй. Иймээс уг бүтээл нь хүний төлөөх үнэт зүйлсийг эрхэмлэдэг хүн бүрт, тухайлбал боловсрол, эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүд, удирдлагууд, мөн нийгмийн сайн сайхны төлөө ажилладаг төрийн бус байгууллагуудад зориулагдсан болно.

Номыг зохиогчийн албан ёсны зөвшөөрөлтэйгээр монгол хэлнээ хөрвүүлэхдээ эх зохиолын онолын үндэслэл, логик дарааллыг алдагдуулахгүйгээр үнэн зөв буулгахыг эрхэмлэв. Япон, Монгол хоёр орны соёл, амьдралын орчин харилцан адилгүй боловч хүнийг хөгжүүлэх эрмэлзэл нь ижил билээ. Судлаачийн хувьд уг үзэл баримтлалыг Монголын нөхцөл байдалтай уялдуулах зорилгоор 4 дүгээр бүлгийг нэмэлтээр боловсруулсан бөгөөд энд судалгааны тойм болон практик зөвлөмжийг багтаасан болно.

Номын зохиогч, профессор Токи Анмэ нь миний судалгааны удирдагч багш бөгөөд бид одоо ч судалгааны чиглэлээр хамтран ажиллаж байна. Түүний удирдлага дор урт хугацааны судалгааны багийн гишүүнээр ажилласан нь миний хувьд үнэтэй туршлага болсон. Иймд уг бүтээлийг орчуулах, түгээн дэлгэрүүлэх үйл хэрэгт оролцож буйдаа талархалтай байна.

Чадварлаг мэргэжилтнүүдийн дэмжлэгтэйгээр энэхүү арга зүйг хэрэгжүүлснээр бид ирээдүй хойч үедээ үнэлж баршгүй хөрөнгө оруулалт хийж, хүн бүр баяр баясгалантай, сэтгэл өөдрөг амьдрах боломжийг нээж чадна. Энэхүү бүтээл нь Монгол айл бүрийн хөгжил, хүүхэд бүрийн инээмсэглэлд хувь нэмрээ оруулах бодит алхам болно гэдэгт итгэж байна.

ГАРЧИГ

Зохиогчийн өмнөх үг	3
Судлаач-орчуулагчийн оршил	5

Бүлэг I: Онолын хэсэг

1. Хүчирхэгжих үйл явцын мөн чанар ба тодорхойлолт	9
2. Хүчирхэгжих зарчим	10
3. Хүчирхэгжих үйл явцын төрөл хэлбэр.....	10
4. “Dynamic Synergy Model” буюу Харилцан нөлөөлөл бүхий нэгдмэл загварыг ашиглан олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь	11
5. Хүчирхэгжих үйл явц бүрдэх урьдчилсан нөхцөл	12
6. Хүчирхэгжих үйл явцын уялдаа холбоо (хувь хүн, хамт олон, олон нийтийн түвшинд)	13
7. Дэмжин туслагчдын баримтлах гурван үзэл баримтлал.....	14
8. Хүчирхэгжих үйл явцыг хөгжүүлэх гурван үндсэн бүрэлдэхүүн хэсэг (элемент).....	15
9. Хүчирхэгжих үйл явцын динамик, уян хатан загвар	16
10. Хүчирхэгжих үйл явцыг дэмжих арга техникүүд	18
11. Хүчирхэгжих орчныг бүрдүүлэх найман бүрэлдэхүүн хэсэг	21
12. Хүчирхэгжих орчныг бүрдүүлэх долоон зөвлөмж.....	23

Бүлэг II: Хэрэгжүүлэх үе шат

1. Хүчирхэгжих үйл явцыг дэмжих нотолгоонд суурилсан практик үйл ажиллагаа	29
2. Хүчирхэгжих үйл явцаг дэмжих загвар	31
3. Хүүхдийн хөгжлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт	38
4. Нийгэмшихүйн ур чадварын үнэлгээ	40
5. Онцгой анхаарал шаардлагатай хүүхдийг ажиглаж үнэлэх хуудас	40
6. Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчны шалгуур үзүүлэлт	41
7. Байгууллагад суурилсан хүүхэд асран хүмүүжүүлэх орчны индекс.....	44

Бүлэг III: Дүгнэлт

Оролцоог нэмэгдүүлж боломжоор дүүрэн ертөнцийг бүтээх нь.....46

Бүлэг IV: Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчныг сайжруулснаар “хүчирхэг иргэн”-ийг төлөвшүүлнэ

1. Гэр бүлийн таатай орчин нь хүүхдийн хөгжлийн суурь хүчин зүйл юм.....48
2. Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчныг үнэлэх нь:
Онол ба практик ач холбогдол..... 48
3. Хүчирхэгжих онолын хүрээнд хүүхдийн өсөж торних орчныг сайжруулах нь.....50

ХАВСРАЛТ

- Хавсралт 1:
Хүүхдийн хөгжлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт..... 52
- Хавсралт 2:
Нийгэмшихүйн ур чадварын үнэлгээ..... 55
- Хавсралт 3:
Онцгой анхаарал шаардлагатай хүүхдийг ажиглаж үнэлэх хуудас.....56
- Хавсралт 4:
Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчны шалгуур үзүүлэлт 65
- Хавсралт 5:
Байгууллагад суурилсан хүүхэд асран хүмүүжүүлэх орчны индекс66
- Ном зүй..... 77
- Ном зүй (IV Бүлгийн нэмэлт)..... 79
- Зохиогч80
- Судалгааны багийн гишүүд80

Тус бүлэгт хүчирхэгжих үйл явцын талаарх хамгийн сүүлийн үеийн тодорхойлолт болон практик туршлагуудыг багтаасан болно. Та энэхүү хэсгээс: 1) хүчирхэгжих зарчим, 2) хүчирхэгжих үйл явцын мөн чанар, хувь хүн, найз нөхөд, хамт олон, байгууллагын хоорондын хамаарал, 3) хүчирхэгжих үйл явцыг бүрдүүлэх орчинг бий болгох арга зам, 4) хүчирхэгжих үйл явцыг амьдралд хэрэгжүүлэхэд шаардлагатай загвартай дэлгэрэнгүй танилцах боломжтой.

Амьдралын гэрэл гэгээг бий болгохын төлөө тэргүүн эгнээнд ажиллаж буй мэргэжилтнүүдийн туршлагад үндэслэсэн зөвлөгөөг уг бүтээлд мөн адил багтаасан болно.

1. Хүчирхэгжих үйл явцын мөн чанар ба тодорхойлолт

Empowerment гэх үг нь *power* буюу хүч чадал гэсэн үгийн өмнө *em* угтвар авч бүтсэн үг бөгөөд тус үгийн утга нь өөрт буй боломжит хүчин чадлаа дайчлах, харуулах, ил гаргах гэсэн утгыг илэрхийлдэг.

Энгийнээр хэлбэл, хүчирхэгжих үйл явц нь хүмүүст итгэл найдвар, хүсэл мөрөөдөл төрүүлж, нөөц боломжоо дайчлан, эрч хүчтэй амьдрах урам зоригийг өгдөг. Түүнчлэн хүн бүрийн дотор орших гайхамшигтай боломжийг сэрээж, нуугдмал хүчийг нь ил гарган, бусдыг ойлгож, хамтран ойлголцох сүлжээг бий болгодог. Ийнхүү хувь хүн, байгууллага, хамт олон, олон нийтийн доторх тэрхүү хүчийг олж мэдэн, ухамсарласнаар өөрсдийн давуу талаа хөгжүүлж, мэдрэмж, бодит байдлаа бусадтай хуваалцан, улмаар хамтран ажиллах шинэ арга зам, боломжуудыг нээдэг. Энэ нь хүчирхэгжих үйл явцын хамгийн бүтээлч илрэл юм. Хүчтэй байх нь хүсэл мөрөөдлийг өдөөж, хөгжүүлэн түгээх, шинийг эхлүүлэх түлхүүр болж, хувь хүн, хамт олон, байгууллагыг идэвхжүүлэх гол хөдөлгөгч хүч болдог.

Хүчирхэгжих гэдэг ойлголт нь нийгмийн хөгжлийн олон салбарт өргөн хэрэглэгддэг бөгөөд аль салбарт хэрэглэж байгаагаас хамааран өөр өөрөөр тайлбарлагддаг. Тухайлбал, боловсролын салбарт хүчирхэгжих нь дотоод сэдлийг нэмэгдүүлэх, амжилтаа бататгах, туршлага, ур чадвараа хөгжүүлэх, өөрийн мэдрэмж, давуу талаа ашиглах, өөрийгөө хүндэтгэх зэрэг үйлдлээр илэрдэг. Нийгмийн хөгжлийн салбарт энэ ойлголт нь хүнийг хүндэтгэн үзэх, хүн бүрийн боломжит чадамжид итгэх, дотоод нөөц, чадвараа ашиглан эрх тэгш нийгмийг бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа гэж тодорхойлогдоно. Бизнесийн салбарт хүчирхэгжилт нь эрх мэдлийг оновчтой хуваарилах, хариуцлагыг нэмэгдүүлэх замаар бүтээлч шийдвэр гаргах үйл явцаар илэрдэг. Харин нийгмийн халамжийн салбарт хүчирхэгжилт гэдэг нь тухайн хүн өөрийн сайн сайхан байдалд нөлөөлөх үйлдэл, шийдвэр гаргах үйл явцад илүү их хяналттай оролцох боломж, чадварыг илэрхийлдэг.

2. Хүчирхэгжих зарчим

Хүчирхэгжих үндсэн найман зарчим:

- (1) Хүн өөрийн зорилгыг бие даан тодорхойлох.
- (2) Өөрөө санаачилга гаргаж, шийдвэр гаргалтад идэвхтэй оролцох.
- (3) Өөрт тулгарсан асуудлыг тодорхойлж, түүнийг шийдвэрлэх боломжит арга замыг эрэлхийлэх.
- (4) Амжилт болон алдаанаасаа суралцаж, тэдгээрийг өсөж хөгжих боломж гэж харах.
- (5) Хүний дотоод нөөц, хүчин чадал болон тэдгээрийг дэмжих хүчин зүйлсийг нээн илрүүлж, эерэг зан үйлийг бэхжүүлэх.
- (6) Асуудлаа шийдвэрлэх оролдлогыг нь дэмжих замаар хариуцлагын мэдрэмжийг нэмэгдүүлэх.
- (7) Асуудал шийдвэрлэх болон нөөц бололцоогоо ашиглах үйл явцыг дэмжих замаар хамтын сүлжээг өргөжүүлэх.
- (8) Өөрийн нөхцөл байдлыг сайжруулах эрмэлзэлтэй байх (жишээлбэл, өмнөө тавьсан зорилгодоо хүрэх, сайн сайхан байдлаа дээшлүүлэх).


Өөрөөр хэлбэл, хүчирхэгжих зарчим нь **хувь хүнд тулгуурлан** хэрэгждэг. Иймээс дэмжигчид буюу мэргэжилтнүүд, ажлын удирдагчид болон хамт олны үүрэг нь хувь хүний дотоодоос урган гарах хүч чадлыг илрүүлж, түүнийг ашиглах боломжийг бүрдүүлсэн дэмжлэгтэй орчныг бий болгоход чиглэгдэх ёстой. Энэ хүрээнд “хувь хүн” гэх ойлголтоор олон нийт болон байгууллагын цөмийг бүрдүүлж буй хүмүүсийг, харин “дэмжигчид” гэх ойлголтоор хувь хүнд дэмжлэг үзүүлдэг хувь хүн болон байгууллагуудыг хамруулан авч үзнэ. Хүчирхэгжих зарчим нь зөвхөн хувь хүнд бус, хамт олон, байгууллагад мөн адил хамааралтай (Анмэ, 2007). Байгууллага, хамт олны түвшинд ажилтнуудын идэвх санаачлагыг дэмжих, өөрийн зорилгоо тодорхойлох, шийдвэр гаргах, асуудлыг шийдвэрлэхэд манлайлан оролцох нөхцөлийг бүрдүүлэх замаар хүчирхэгжих үйл явцыг дэмжих нь чухал юм.

3. Хүчирхэгжих үйл явцын төрөл хэлбэр

Хүчирхэгжих үйл явц нь дараах гурван үндсэн хэлбэрээс бүрдэнэ: хувь хүний, хамт олны болон олон нийтийн хүчирхэгжилт.

Хувь хүний хүчирхэгжилт гэдэг нь дотоод чадвараа нээн илрүүлж, түүнийгээ ашиглахтай холбоотой үйл явц юм. Жишээлбэл, хүн өөртөө сэдэл өгч, стрессийг даван туулахын тулд дуртай зүйлдээ төвлөрөх зэрэг үйлдэл нь хувь хүний хүчирхэгжилтийн илрэл байж болно. Хамт олны хүчирхэгжилт гэдэг нь гишүүдийн идэвхтэй оролцоонд тулгуурлан хувь хүний ур чадвар, чадавхийг хөгжүүлж, улмаар нийт багийн гүйцэтгэл, нэгдмэл байдлыг сайжруулах үйл явц юм. Тухайлбал, хамтдаа хооллох, энгийн байдлаар ярилцаж ойлголцох зэрэг өдөр тутмын харилцаа нь итгэлцэл, уялдаа холбоог бэхжүүлж, хүчирхэгжих суурийг бүрдүүлдэг. Олон нийтийн хүчирхэгжилт нь хамт олон, байгууллага, нийгмийн түвшинд хүмүүсийг идэвхжүүлж, оролцоог нэмэгдүүлэх хөшүүрэг болдог. Үүнд орон нутгийн иргэдийг хамарсан өдөрлөг, кампанит ажил зэрэг оролцоог дэмжсэн арга хэмжээнүүд багтана. Эдгээр үйл ажиллагаа нь олон нийтийн идэвх, харилцаа, харилцан ойлголцлыг сайжруулахад чухал нөлөө үзүүлдэг.

Дээрх гурван төрлийн хүчирхэгжилтийг уялдаа холбоотойгоор хамтад нь хэрэгжүүлэх нь чухал бөгөөд энэ нь илүү үр дүнтэй, тогтвортой нөлөөг бий болгож, “Хүчирхэгжилтийн нэгдмэл загвар”-ыг бүрдүүлдэг (Зураг 1).



Зураг 1. Хүчирхэгжилтийн нэгдмэл загвар (Анмэ 2008)

4. “Dynamic Synergy Model” буюу Харилцан нөлөөлөл бүхий нэгдмэл загварыг ашиглан олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь

Энэхүү динамик загвар нь дэлхий дээрх бүх зүйлсийг харилцан уялдаатай, харилцан нөхөх шинжтэй, харилцан хамааралтай нэгдмэл системийн нэг хэсэг хэмээн тайлбарладаг. Цаашилбал, хүмүүс бусадтайгаа харилцан холбогдсон үедээ бие биеийнхээ хөгжил, амжилтыг дэмжих боломж бүрддэг. Тус загвар нь хүний хөгжлийн явцыг олон талаас нь авч үзэж, практик ба судалгааны хүрээнд өргөжүүлэн хэрэглэхийг санал болгодог (Зураг 2). Хувь хүний онцлог шинж чанарыг үнэ цэнэтэй, орхигдуулж болохгүй гэж үзэхийн зэрэгцээ өөрчлөгдөх боломжтой хэмээн ханддаг тул энэхүү загвар нь “хэвийн” ба “хэвийн бус” гэсэн хөгжлийн хоёр туйлт ойлголтыг даван гарч, хөгжлийг илүү өргөн хүрээнд харах боломжийг бүрдүүлдэг.


Хувь хүний **хөгжлийн шинж чанарыг “энгийн” ба “онцгой” гэсэн хоёр төвт** зууван бүтэцтэйгээр харуулдгаараа энэхүү загвар онцлог юм. Хөгжлийн онцлог шинж нь тогтмол биш, харин хувь хүн болон орчны хүчин зүйлсээс хамааран ердийн байдлаас онцгой руу, эсвэл онцгойгоос ердийн байдал руу **хэлбэлзэн, динамик шинжтэйгээр өөрчлөгддөг.**

Өөрөөр хэлбэл, энэхүү загвар нь хүний хөгжлийн шинж байдлыг тогтмол, хатуу хүрээнд бус, уян хатан хүрээнд авч үздэг. Иймд тухайн шинж төлөв нь “энгийн” болон “онцгой” гэсэн утгуудын хооронд уян хатан байдлаар шилжиж, зарим тохиолдолд нэгдэн холилдож болно. Энэ шилжилт нь хувь хүний зан чанар, орчин, нөхцөл байдлын харилцан үйлчлэлээс шалтгаалдаг. Хувь хүний амьдралын нөхцөл байдлаас хамааран түүний хөгжлийн шинж чанарууд (эсвэл зан төлөв) нь “энгийн” байдлаас “онцгой” байдал руу, эсвэл эсрэгээр нь онцгойгоос энгийн байдал руу шилжин өөрчлөгдөж байдаг.

Зууван хэлбэрт тойргийг бүрдүүлэгч хоёр хэсэг нь адил тэнцүү бөгөөд хувь хүн тойргийн аль ч хэсэгт байрласан **ижил тэгш хүндлэлийг** хүртэх эрхтэй. Загварын суурь хэсэг нь хүрээлэн буй орчны хүчин зүйлсийг илэрхийлнэ. “АРГА” (цагаан өнгөөр тэмдэглэсэн) нь эмх цэгцийг бий болгох дэмжих орчныг, харин “БИЛГЭ” (саарал өнгөөр тэмдэглэсэн) нь өөрчлөлтийг дэмжих сорилт бүхий асуудалтай орчныг илэрхийлнэ. Эдгээр нь харилцан бие биеэ нөхөж, хүний хөгжил, өөрчлөлтийг дэмжих нэгдмэл орчныг цогцлоодог.

Бодит амьдралд хүнийг хүндэтгэн үзэхийн тулд “энгийн” болон “онцгой” шинж, түүнчлэн дэмжихийн зэрэгцээ асуудал үүсгэдэг орчныг хамтад нь авч үзэх уян хатан механизм шаардлагатай. Гэр бүлийн гишүүд, хөршүүд болон нийгмийг тогтмол, өөрчлөгдөшгүй гэж үзэхээс илүүтэй бие биедээ харилцан нөлөөлж, байнга өөрчлөгдөн хөгждөг тогтолцоо хэмээн ойлговол ялгаварлан гадуурхалт буурч, хамтдаа орших нийгмийн суурь бүрдэнэ. Мэргэжилтнүүд хүмүүсийн бодит хэрэгцээнд нийцүүлэн дэмжих болон сорилт бүхий орчныг зохистой ашигласнаар тэдний сайн сайхан байдлыг дэмжиж, уян хатан, хувьсан өөрчлөгдөх хөгжлийн суурийг бүрдүүлж чадна.

Дээрх загварт суурилсан практик болон судалгааны бодит жишээнүүдийг ашиглан оролцоог дэмжсэн нийгмийг хэрхэн бүрдүүлж болохыг номын дараагийн бүлэгт авч үзнэ.



Зураг 2. Харилцан нөлөөлөл бүхий нэгдмэл загвар

5. Хүчирхэгжих үйл явц бүрдэх урьдчилсан нөхцөл

Хувь хүн, хамт олон, олон нийт хүчирхэгжихэд дараах нийтлэг гурван урьдчилсан нөхцөл бий болсон байх хэрэгтэй:

- 1. Итгэл найдвар:** Ил тод, бодит зорилго нь итгэл найдварыг төрүүлдэг.
- 2. Итгэл үнэмшил:** Зорилгодоо хүрэх чадвар, нөөц бололцоо өөрт нь бий гэдэгт итгэлтэй байх. Өөртөө итгэх итгэл болон бүлэг, хамт олны итгэл үнэмшил нь чухал ач холбогдолтой. Өөрийн чадварт итгэх итгэл болон бүлгийн хамтын чадварт итгэх итгэл нь хувь хүн, бүлгийг хүрээлэн буй орчны асуудалд оролцон нөлөөлөх чадвартай гэсэн итгэл үнэмшлийг бүрдүүлдэг.
- 3. Утга учир:** Зорилгодоо хүрэхийн тулд хийж буй бүх үйлдлээсээ утга учир, ач холбогдол олж харах чадвар зэрэг болно.

Эдгээр урьдчилсан нөхцөлүүд бүрэлдэх нь нэн чухал (Анмэ, 2008). Тухайлбал, хэн нэгэн хүндээр өвдсөн гэж бодъё. Эхний үед тухайн хүн сэтгэл санаагаар унаж, “Яагаад заавал би өвдчихөв?” хэмээн өөрөөсөө асуух, өөрийгөө зэмлэх, нөхцөл байдалтайгаа эвлэрэхгүй байх зэрэг хандлага илэрч болно. Зарим тохиолдолд сэтгэл зүйн гүн дарамт, цочролд орж, бурханаас аврал эрэх зэрэг зан төлөв ажиглагдаж ч магадгүй. Гэвч цаг хугацааны явцад тухайн хүн бодит нөхцөл байдалтайгаа эвлэрч, өвчин зовлонгоосоо ангижрахын төлөө тэмцэж эхэлдэг. Энэ тэмцлийг эхлүүлэхэд хамгийн түрүүнд хэрэгтэй зүйл нь эдгэрнэ гэсэн итгэл найдвар юм. Үүний дараа эмчилгээний явцыг даван туулж, эдгэрнэ гэдэгтээ итгэл үнэмшилтэй байх шаардлагатай. Ийнхүү итгэл үнэмшил төлөвшсөнөөр тухайн хүн өөрийн хийж буй тэмцлийн үр дүн, утга учрыг ухамсарлан ойлгож, цааш тэмүүлэх урам зоригийг олж авдаг.

Олон нийт, хамт олны хүрээнд ч хүчирхэгжих үйл явц нь дээрх жишээтэй төстэй байдлаар явагддаг. Хүнд хэцүү нөхцөл байдал тулгарсан үед та бүхэн түүнийг хэрхэн даван туулах вэ? Магадгүй та бүхэн ирээдүйн зорилгоо тодорхойлж, өөрсдийн нөөц бололцоо, чадварт итгэж, хийж буй ажлынхаа алхам бүрт болон гарч буй үр дүнд ач холбогдол өгснөөр нөхцөл байдлыг сайжруулах, асуудлыг шийдвэрлэх оролдлого хийх болно.

Хүчирхэгжих үйл явц нь зөвхөн хямралын үеэр хязгаарлагддаггүй. Хүн өдөр тутмын амьдрал болон ажлын орчиндоо эдгээр гурван зарчмыг ойлгон хэрэгжүүлж, бүрдүүлж чадаагүй тохиолдолд өөрийгөө хүчгүй мэт мэдэрч эхэлдэг. Хүн хүчгүй болсон үед сөрөг бодол давамгайлж, юу ч хийх боломжгүй мэт санагдан, амьдрал утгагүй мэт мэдрэгддэг. Нийгмийн гадуурхал нь хүний итгэл найдвар болон бүтээлч байдлыг сэлэм мэт цавчин хаядаг. Эргэн тойрны дэмжлэг, оролцоог үл харгалзан, ганцаардалд орсон үед тухайн хүний бие махбодийн байдал эрс мууддаг. Мөн гэр бүлийн хүчирхийлэл, удаан хугацааны дарамт, шахалт зэрэг нь мэдрэлийн системд хүртэл гэмтэл учруулдаг болох нь судалгаагаар тогтоогдсон байдаг.

6. Хүчирхэгжих үйл явцын уялдаа холбоо (хувь хүн, хамт олон, олон нийтийн түвшинд)

Хувь хүн, хамт олон, олон нийтийг хамтад нь хүчирхэгжүүлэхийн тулд дараах гурван шалгуурыг чухалчлан авч үзэх шаардлагатай:

1. Өөрөөрөө бахархах мэдрэмж
2. Ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, түүнд сэтгэл хангалуун байх чадвар
3. Бүлэг, хамт олны чадамжид итгэх итгэл

Нэгдүгээрт, хүн өөртөө итгэж, өөрөөрөө бахархах мэдрэмжийг төлөвшүүлэх шаардлагатай. Өөртөө итгэлгүй хүн өөрөөрөө бахархах мэдрэмж сул байдаг. Харин өөрөөрөө бахархах мэдрэмж нь бусдыг таньж мэдэх, хүлээн зөвшөөрөх чадварыг нэмэгдүүлдэг.

Дараагийн чухал шаардлага бол хүмүүсийн хоорондын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, түүнд сэтгэл хангалуун байх чадвар юм. Ялгаатай байдал нь нийгмийн хөгжлийн суурь болдог. Эволюцийн онолд хувьслыг бүхэлдээ рациональ (учир шалтгаантай) үйл явц гэж үзэхээс илүүтэй анхандаа ирациональ (учир шалтгаант бус) шинж дээр суурилан, улмаар рациональ байдал аажмаар бүрэлдэн хөгждөг процесс хэмээн тайлбарладаг.

Ялгаатай байдал, мөн хоёрдмол утгатай нөхцөлөөс шинэ үнэ цэнэ, утга учир үүсдэг. Иймээс өнгөц харахад утгагүй мэт санагдах, эмх замбараагүй, хоёрдмол шинжтэй байдлыг үнэлж, тэдгээрээс утга учрыг олж харах нь чухал. Түүнчлэн энэ нь бүтээлч байдал, туршилт хийх болон өсөн хөгжих боломжтой салшгүй холбоотой.

Дараагийн үндсэн шалгуур нь хамт олон болон бүлгийн боломж, чадамжид итгэх явдал юм. Хамт олон, олон нийтийн дунд зайлшгүй байх ёстой итгэл найдвар нь зөвхөн хувь хүмүүсийн хоорондох итгэлцлээр хязгаарлагдахгүй. Энэ нь өөр хоорондоо ялгаатай хувь хүмүүсээс бүрдсэн хамт олонд итгэх, тэдний чадварт найдах, мөн ялгаатай байдлыг ойлгож, хүндэтгэх боломжийг бүрдүүлдэг.

Жишээлбэл, тусгай хэрэгцээтэй хүүхдийг энгийн хүүхдүүдтэй хамт тэгш хамруулан сургах сургалтад хамруулснаар бүх хүүхэд өөртөө итгэлтэй болж, ялгаатай байдлыг байгалийн, хэвийн зүйл мэт хүлээн зөвшөөрч, хамтдаа хөгждөг.

7. Дэмжин туслагчдын баримтлах гурван үзэл баримтлал

Хүчирхэгжих үйл явцыг дэмжигчид буюу мэргэжилтнүүдийн гүйцэтгэх үндсэн үүрэг нь холбогдох хүмүүсийн хэрэгцээ, үнэт зүйлсийг тодорхойлж, тэдний чадамжийг үнэлэн, хөгжих орчныг дэмжих зохицуулалт хийх явдал юм. Үнэт зүйлсэд тухайн хүн болон хамт олны эрхэмлэн, хүндэтгэдэг түүх, соёл, үзэл бодол, ухамсрыг хамруулан авч үздэг. Харин хэрэгцээ нь хувь хүн болон нийгэм, хамт олны хүсэж буй зүйлсийг илэрхийлнэ. Эдгээр хэрэгцээ, үнэт зүйлс нь мэргэжилтнүүдийн урьдчилан төсөөлснөөс ялгаатай байх нь элбэг тул ийм тохиолдолд харилцан ойлголцол нь хүчирхэгжүүлэх үйл явцын эхний алхам болдог. Хүмүүс юу хүсэж, юуг чухалчилж байгааг тэдний хэл яриа, биеийн хэлэмж, зан төлөвөөс ойлгож мэдэх боломжтой. Гэвч хүний хэлсэн үг нь түүний бодит хэрэгцээг бүрэн илэрхийлдэггүй. Иймээс тухайн хүний илэрхийлээгүй дотоод мэдрэмжийг таньж мэдэх чадвартай дэмжигч, мэргэжилтэн байх нь чухал юм.

Хоёрдугаар хэсэгт дурдсанчлан, хүчирхэгжих зарчмын гол цөм нь хүмүүс өөрсдөө юм. Иймд хүмүүс өөрийн хүчинд тулгуурлан тасралтгүй хөгжих боломжтой орчныг бүрдүүлэх шаардлагатай. Тухайлбал, бизнесийн салбарт хэрэглэгчид компанийн бүтээгдэхүүнийг ашиглах хүсэлтэй байх, эсвэл тухайн бүтээгдэхүүнийг өөрийн хэрэгцээнд нийцсэн гэж үзэх нь түүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлэх боломжийг нэмэгдүүлдэг. Иймээс дэмжигчдээс шаардагдах гурван үндсэн үзэл баримтлал байдаг:

1. Хүчирхэгжих үйл явцад холбогдох хүмүүсийн үнэт зүйлс ба үнэ цэнийн мэдрэмж
2. Тэдний хэрэгцээ, шаардлага
3. Холбогдох хүмүүсийн чадамж болон боломжийн талаарх ойлголт (өөрийн болон хамтын чадамжид итгэх, боломжийг ойлгох байдал)

Бизнесийн орчинд компани болон хэрэглэгчид харилцан бие биеэ дэмжиж, хүчирхэгжих тогтолцоог бүрдүүлэх нь тогтвортой хөгжилд хүргэдэг. Компани нь хэрэглэгчдийн хэрэгцээ, үнэт зүйлс, ямар бүтээгдэхүүн тэдэнд тохиромжтойг ойлгож, тэднийг дэмжихийн тулд өндөр чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэдэг. Нөгөө талаас, хэрэглэгчид компанийн бүтээгдэхүүн,

үйлчилгээний үнэт зүйлс, онцлогийг өөрийнхөөрөө ойлгон хүлээн авч, брэндийн үнэ цэнийг өндөрөөр үнэлэхийн зэрэгцээ мэдээллийг нийгэмд идэвхтэй хуваалцсанаар компанийн үйл ажиллагааг улам бэхжүүлдэг. Ийнхүү харилцан бие биеэ хүчирхэгжүүлэх тогтолцоог хөгжүүлэх нь компанийн хөгжлийн үндэс болдог.

Өөр нэг жишээ дурдвал, шинэ ажилтан ажлын орчиндоо дасан зохицож чадахгүй байх нөхцөл байдал үүсэж болно. Ийм үед түүний эргэн тойрныхон тухайн хүний нөхцөл байдлыг ойлгон хүлээн авч, зохих дэмжлэг үзүүлэх нь чухал. Тухайн ажилтны нөөц бололцоог бүрэн нээхийн тулд хамт олон нь түүнтэй идэвхтэй харилцаж, компанид элсэхдээ тээж явсан мөрөөдөл, хүсэл тэмүүллийг нь сэргээж, давуу тал, урам зоригийг нь идэвхжүүлэх хэрэгтэй. Мөн түүнд сэтгэл ханамж, баяр баясал өгдөг үйл ажиллагаанд хамтдаа оролцох нь үр дүнтэй.

Эрүүл мэнд, халамжийн салбарын хүрээнд өөр нэг жишээг авч үзье. Гэртээ амьдрахыг хүсдэг боловч алхахад бэрхшээлтэй өндөр настай хүн байлаа гэж бодъё. Түүний гэртээ амьдрах хүсэлтийг харгалзан, гэрийн шалыг нь бүдрэх, унах эрсдэлгүйгээр тэгшилж засах боломжтой. Мөн биеийн жинд нь тохирсон, бат бөх, алхахад дэмжлэг үзүүлэх туслах хэрэгслийг тааруулан өгч, худалдаа хийх, гадаа салхинд гарах зэрэг өдөр тутмын үйл ажиллагааг нь дэмжиж болно. Түүнчлэн хоол хүргэлтийн үйлчилгээнд хамруулахын зэрэгцээ мэргэжлийн асрагчийг өдөрт нэг удаа гэрт нь ирүүлэн үйлчилгээ үзүүлэх боломжтой. Ийнхүү хүний бие даан амьдрах боломжийг дэмжсэнээр тухайн хүн өөртөө итгэх итгэл, бахархлыг мэдэрч, бусдаас хүндлэл хүртдэг.


8. Хүчирхэгжих үйл явцыг хөгжүүлэх гурван үндсэн бүрэлдэхүүн хэсэг (элемент)

Хүчирхэгжих үйл явц нь уян хатан чанар, ялгаатай байдал, нэгдмэл чанар гэсэн гурван үндсэн элементийн харилцан нөлөөллөөр бүрэлдэн хөгждөг гэж үздэг (Зураг 3, Анмэ, 2015).

- Уян хатан чанар:** Зорилго, аргачлал, хэрэгжилтэд нийцүүлэн уян хатан байдлаар хандах чадвар
- Ялгаатай байдал:** Ялгаатай, олон төрлийн боломжит хувилбаруудыг хамруулан авч үзэх хандлага
- Нэгдмэл чанар:** Урт хугацаанд тогтвортой, уялдаа холбоотой иж бүрэн байдлыг хангах чадвар

Уян хатан чанар гэдэг нь хүний зорилго, үйл ажиллагааны арга барил, хэрэгжилтийн явцад дасан зохицох, уян хатан байдлаа сайжруулах үйл явцыг хэлнэ. Энэ нь өөрчлөлтөд дасан зохицох боломжийг олгодгоороо давуу талтай. Уян хатан байснаар хүн аливаа бэрхшээл, сорилтод дасан зохицож, өгөгдсөн үүрэг, даалгаварт эерэг хандлагаар ханддаг. Иймээс уян хатан чанар нь хүчирхэгжих үйл явцын суурь элементүүдийн нэг юм.

Уян хатан байх үндсэн ойлголт нь асуудал тулгарсан үед тайван, оновчтой шийдвэр гаргах, мөн нөхцөл байдалд дасан зохицон өөрчлөгдөх чадварыг илэрхийлдэг. Энэхүү нэр томъёо нь молекулын түвшнээс эхлээд хатуу биет, хүрээлэн буй орчин, тэр ч байтугай орчлон ертөнц хүртэлх олон түвшинд өргөн хэрэглэгддэг ойлголт юм.



Зураг 3. Хүчирхэгжих үйл явцыг хөгжүүлэх гурван үндсэн бүрэлдэхүүн хэсэг (элемент)

Ялгаатай байдал гэдэг нь олон боломжийг хүлээн авч, хамтад нь нэгтгэн авч үзэх чадвар юм. Энэ нь хөгжлийн дараагийн шатанд зайлшгүй шаардлагатай үнэт нөөц бөгөөд эволюц, генетик, тархи судлал зэрэг олон салбарт үйлчилдэг зарчим юм.

Нэгдмэл чанар гэдэг нь юмс, үзэгдлийн уялдаа холбоог хадгалж, урт хугацаанд тогтвортой байдлыг хангах явдал юм. Хамт олон болон хүмүүс бие биеэсээ тусдаа хөгжиж, ажиллаж байгаа мэт харагдавч, тэднийг нэг бүхэл болгон уялдуулах тогтолцоо шаардлагатай. Зарим үед өсөлт удааширч, бүр буурах тохиолдол гарч болох ч урт хугацааны өнцгөөс харвал тэнцвэр хадгалагдсанаар хөгжил тасралтгүй үргэлжилдэг.

Ялгаатай байдал, уян хатан чанар, нэгдмэл байдал нь хүчирхэгжих үйл явцын гурван суурь элемент юм.

9. Хүчирхэгжих үйл явцын динамик, уян хатан загвар

Гуравдугаар хэсэгт бид хүчирхэгжих үйл явцын төрлүүд болох хувь хүний, хамт олны, олон нийтийн хүчирхэгжилт болон эдгээрийн хоорондын харилцан нөлөөллийг харуулсан нэгдмэл загварыг авч үзсэн (Зураг 1-ийг үзнэ үү).

Хүчирхэгжих үйл явцын гурван төрөл хэлбэрийн нэг болох олон нийтийн хүчирхэгжилт нь гурван түвшинд ангилагддаг. Олон нийтийн хүчирхэгжилт гэсэн нэр томъёог задлан авч үзвэл, зах зээл болон олон нийтийн хүрээнд хэрэгжих нийгмийн хүчирхэгжилт, мөн систем, бүтэц, тогтолцооны түвшинд хэрэгжих системийн хүчирхэгжилт гэж ангилж болно. Хувь хүн болон хамт олны хүчирхэгжилтийн төрлүүдийг хамтад нь авч үзвэл, хүчирхэгжих үйл явц нь таван гол элементээс бүрддэг бөгөөд эдгээр элементүүдийн динамик харилцан уялдааг “Хүчирхэгжих динамик загвар” буюу “Хүчирхэгжих уян хатан, хөдөлгөөнт загвар” гэж нэрлэдэг (Зураг 4).

Энэ загвар нь хүчирхэгжүүлэх үйл явцын таван түвшний харилцан хамаарлыг харуулдаг бөгөөд эдгээр түвшин нь зарим тохиолдолд бие биеэ харилцан дэмжих (sosho – дэмжих), харин зарим тохиолдолд хоорондоо зөрчилдөх, өрсөлдөх (sokoku – зөрчилдөх) шинжтэй байдаг. Дорнын гүн ухааны таван махбодийн онолтой адил, энэ загвар нь түвшин бүрийн хоорондын уялдаа холбоо, харилцан хамаарал, мөн зарим тохиолдолд үүсэх зөрчил, онцлог шинжийг харуулдагаараа онцлог юм. Sosho (харилцан дэмжих) нь дэргэдээ байрлах элементүүд бие биеэ дэмжиж, бэхжүүлэх харилцааг

илэрхийлдэг бол, Sokoku (харилцан зөрчилдөх) нь зайтай буюу хол байрлах элементүүдийн хооронд үүсэх зөрчилдөөнт харилцааг илэрхийлдэг.

Хувь хүн, хамт олон, олон нийт, нийгмийн болон системийн хүчирхэгжилтийн ялгаатай хэлбэрүүд нь нэгэн тойрогт орж бие биедээ нөлөөлдөг. Иймээс эдгээр нь Sosho буюу харилцан дэмжих хамаарал болон Sokoku буюу зөрчилдөөнт холбоонд орж, харилцан үйлчлэлийн динамик хөдөлгөөнийг бий болгодог.



Зураг 4. Хүчирхэгжих уян хатан, хөдөлгөөнт загвар

Энэхүү харилцааг дараах жишээгээр тайлбарлаж болно:

1. Хэт хүчтэй хувь хүн байгууллагыг сулруулах магадлалтай. Хувь хүний давамгайлал нь бүлгээр шийдвэр гаргахад хүндрэл үүсгэдэг.
2. Хэт давамгайлсан бүлгүүд нь систем, стандарт загварыг сулруулдаг. Хэлтэс болон бүлгийн хувьд өөрсдийн хүсэлтээ тулгах нь системийн логикийг бүхэлд нь гажуудуулах талтай.
3. Хэрэв систем нь хэт хүчтэй бол иргэдийг дүрэм журмаар хязгаарлаж тэдний чадамжийг сулруулдаг. Дарангуйлан захирах буюу тоталитари дэглэм нь бусад бүлгүүдийн оролцоог үгүйсгэж байдаг.
4. Хэрэв хамт олон хүчтэй байвал фракц үүсгэж нийгмээ сулруулдаг. Өөрсдийн ашиг сонирхлыг дээдлэгч бүлгүүд нийгмийн сайн сайхан байдалд хүрэх олны тэмүүллийг үл тоомсорлодог.
5. Хэрэв нийгэм нь хэт хүчтэй бол хувь хүнийг сулруулдаг.

Дээрх байдал нь нийгмийн хэм хэмжээг тулган хэрэгжүүлж, хувь хүний эрх чөлөөг хязгаарлаж болзошгүй. Хүчирхэгжих уян хатан, хөдөлгөөнт загварыг ашигласнаар аливаа зүйлийн мөн чанарыг илүү өргөн хүрээнд харж, нөхцөл байдлын өөрчлөлтөд уян хатан дасан зохицох боломжийг олгодог.

Жишээлбэл, эрүүл мэнд, халамжийн салбарт зөвхөн хувь хүний сайн сайхан байдалд анхаарахаас гадна, түүнийг хүрээлж буй гэр бүл, найз нөхөд, байгууллага, хамт олон, нийгмийн тогтолцоо, бүтэц, соёл, түүх зэрэг олон хүчин зүйлтэй уялдсан харилцаанд гарч буй цогц өөрчлөлтийг системтэйгээр

ойлгох шаардлагатай байдаг. Эдгээр хүчин зүйлс нь хувь хүний хөгжил болон насжилттай нягт холбоотой байж болно.

Компани, байгууллагын орчинд зах зээлийн хөгжилд анхаарахаас гадна, шинэ технологийг ашиглан хувь хэрэглэгч, тэдний эргэн тойрныхон болон нийгмийг хэрхэн дэмжиж, хүчирхэгжүүлэх боломж, арга замыг эрэлхийлэх хандлага нэмэгдэж байна. Тухайлбал, компаниуд хэрэглэгчдийг өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний идэвхтэй дэмжигч, хамтрагч болгох боломж, арга замыг түлхүү судалдаг болсон. Ялангуяа интернет болон нийгмийн сүлжээний хөгжил нь хамт олон, олон нийтээр дамжуулан хувь хүнд хүрч ажиллах боломж, арга барилыг нэмэгдүүлж байна.

Хүчирхэгжих уян хатан, хөдөлгөөнт загварыг ашигласнаар илүү өндөр үр дүнд хүрэх боломжийг бүрдүүлдэг.

10. Хүчирхэгжих үйл явцыг дэмжих арга техникүүд

(1) Хүчирхэгжих чиг хандлагыг ойлгох нь

Хүчирхэгжүүлэхийн тулд одоогийн түвшнээ тодорхойлж байх явцдаа байнга урагш тэмүүлэх шаардлагатай бөгөөд энэ тохиолдолд **CASE** загвар (*Creation – Бүтээх, Adaptation – Дасан зохицох, Sustenance – Тогтворжуулах, Expansion – Хүрээгээ тэлэх*)-ыг хөгжлийн жишиг болгон ашиглах нь үр дүнтэй байх болно. (Anmé & McCall, 2008). Энэхүү загвар нь хувь хүнд өөрийн хөгжлийн түвшинг ойлгож, дараагийн шатанд шилжихдээ тохирох арга техникүүдийг зөв сонгоход тусалдаг (Зураг 5).


Бүтээх үе шат нь урьд өмнө байгаагүй шинэ санаа, харилцаа холбоог үүсгэн бий болгож, шинэ боломж, үйл ажиллагааг эхлүүлэхэд чиглэсэн үе шат юм. Энэ үе шатанд шинэ санаа дэвшүүлэх, шинэлэг үйл ажиллагаа эхлүүлэх, харилцаа холбоо тогтоох, бүтээлч байдлаар ажиллахад чиглэсэн арга техникүүд багтдаг.

Дасан зохицох үе шат нь нэгэнт бий болсон үйл ажиллагаа, харилцааг орчин нөхцөлд нь нийцүүлэн тогтвортой болгож, цааш хөгжүүлэх үе шат юм. Энэ үе шатанд нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх, багийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтран ажиллах, харилцааг бэхжүүлэхэд чиглэсэн арга техникүүдийг ашигладаг.

Тогтворжих үе шат нь үйл ажиллагаа болон харилцаа холбоог тогтвортой хадгалж, бэхжүүлэх үе шат юм. Энэ үе шатанд үйл ажиллагаа, харилцааг тогтвортой хадгалахад чиглэсэн, тухайлбал хэрэгжилтийг хангах, тасралтгүй үргэлжлүүлэх, хяналт тавих арга техникүүд онцгой ач холбогдолтой.

Хүрээгээ тэлэх үе шат нь үйл ажиллагаа, харилцааг өргөжүүлж, дараагийн шатны хөгжлийг бий болгох үе шат юм. Энэ шатанд төвөгтэй, эмх цэгцгүй талуудын өсөлт, хөгжлийг дэмжихийн тулд хэрэгжилтийг өргөжүүлэх, нөлөөллийг тэлэх, уялдаа холбоог хангах цогц арга техникүүдийг хослуулан ашиглаж болно.

Хүчирхэгжих үйл явцыг дэмжихийн тулд байнга өөрчлөгдөн хөгжиж буй нөхцөл байдлыг ойлгож, түүнд нийцсэн стратеги, төлөвлөгөөг оновчтой боловсруулах нь чухал.



Зураг 5. Хүчирхэгжих үйл явц хөгжих үе шат (Anne&McCall, 2008)

(2) Харилцан нөлөөлөл, уялдааг бий болгох алсын харааг тодорхойлох нь

Бодит амьдралд, тухайлбал байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд, ирээдүйн зорилго, хөгжлийн чиглэлийг тодорхойлж, түүнийг тасралтгүй боловсронгуй болгохын зэрэгцээ холбогдох талуудын идэвхтэй оролцоог хангах нь нэн чухал. Уолт Дисней “Хэрэв чи мөрөөдөж чадвал, түүнийгээ бас биелүүлж чадна” хэмээн хэлсэн байдаг. Мөрөөдөл болон хувь хүний тууштай шийдвэр нь амжилтад хүрэх чухал нөөц болдог.

Инноваци буюу шинэлэг санаачилгыг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд гурван үндсэн алхам шаардлагатай. Үүнд: (1) **алсын харааг тодорхойлох**; (2) **бодит хэрэгцээнд нийцүүлэх**; (3) **өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөх орчныг бүрдүүлэх** зэрэг орно. Эдгээр алхам нь байгууллагын үйл ажиллагаа, хэрэгжилтийн аль алинд нь адил ач холбогдолтой. Тухайлбал, үйл ажиллагааг жижиг бүлгийн түвшинд эхлүүлэх нь оролцогчдын санал, санаачилгыг тусгасан алсын харааг тодорхойлоход дэмжлэг болдог.

Эмпати буюу бусдыг ойлгож, харилцан ойлголцлыг хөгжүүлэхийн тулд бүлгийн гишүүд хамтдаа цагийг өнгөрүүлж, утга учиртай, үр дүнтэй харилцаа тогтоох, мөн хамтран ашиглахад тохиромжтой орон зайг бүрдүүлэх нь хамгийн үр дүнтэй эхний алхам юм. Энэхүү үйл явцыг тухайн орон зай, орчин, байрыг ашиглаж буй оршин суугчид, өвчтөнүүд зэрэг холбогдох талуудын идэвхтэй оролцоотойгоор хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Илүү ойлгомжтой болгох үүднээс “алсын хараа” гэдэг ойлголтыг хүмүүсийн амархан төсөөлж, ойлгохуйц “мөрөөдлийн цэцэг” гэх мэт дүрслэлээр илэрхийлж болно. “Мөрөөдлийн цэцэг” нь хүмүүст гэрэл гэгээ, итгэл найдвар төрүүлж, ирээдүй рүү тэмүүлэх, шинэ зүйлсийг турших хүсэл эрмэлзлийг сэргээдэг. Хүмүүс өөрсдийгөө нийгмийн нэг хэсэг гэдгээ ойлгож, бусадтай хамт байхдаа аз жаргалыг мэдэрч, улмаар тодорхой зорилго, итгэлтэйгээр урагшлах эрч хүчийг олж авдаг.

Хамгийн чухал нь бүх хүний **оролцоог хангаж**, хүн бүр хамтдаа байх боломжийг бүрдүүлэх; тэдний давуу тал, боломжид тулгуурлан хамгийн сайн үр дүнд хүргэхийн тулд **хүчирхэгжүүлэх**; мөн мөрөөдлөө биелүүлж урагшлахад чиглэсэн **шинэлэг санаа, инновацийг бий болгох** явдал юм.

Эдгээр гурван үндсэн зарчмыг эрхэмлэснээр аливаа бүлэг, байгууллага, хамт олон, олон нийт нь хамтын зорилгод тулгуурласан бат бөх суурийг бүрдүүлэх боломжтой. Иймээс энэхүү үйл явцыг дараах алхмуудын дагуу хэрэгжүүлнэ:

1. Гишүүдтэйгээ хамт үндсэн санаа, зарчмуудаа ярилцаж, хэлэлцэх. Тухайлбал, хамтдаа хэрхэн эрх тэгш оролцох, хүчирхэгжих, шинэлэг санаагаа солилцох, бие биеэ ойлгох талаар санал бодлоо солилцож болно. Ингэж үзэл бодол, зарчмуудаа солилцох замаар бүх гишүүд, хамт олон ирээдүйгээ эдгээр ойлголтод тулгуурлан нэгдсэн төсөөлөлтэй байгаа эсэхийг баталгаажуулан хэлэлцэх боломжтой. **[Үзэл бодол, зарчимаа хуваалцах]**
2. “Мөрөөдлийн цэцэг” хэлэлцүүлгийн хүрээнд шинэлэг санаа, санаачилгыг цуглуулах. Энэ тохиолдолд зорилгодоо хүрэх хугацааг тодорхой зааж өгөх хэрэгтэй. Иймээс том зорилгыг урт хугацаанд, ойр зорилгыг богино хугацаанд төлөвлөх нь зүйтэй. **[Зорилгоо тодорхойлох: алсын харааг бий болгох]**
3. “Мөрөөдлийн цэцэг”-ийг тэтгэгч “үндэс” болон “навч”-ийг төсөөлөн бодох. Үндэс нь хөрс болон навчнаас шим тэжээлийг шингээж авадагтай адил одоо байгаа нөөцийг илэрхийлдэг бол фотосинтезийн үр дүнд шим тэжээлийг бий болгодог навчнууд нь цаашид нэмэгдүүлэх шаардлагатай нөөц юм. **[Одоо бэлэн байгаа нөөц болон шаардлагатай нөөцийг нэмэгдүүлэх]**
4. Өөрийнхөө мөрөөдлийн цэцгийг дэмжих үндсийг бий болгох хэрэгтэй. Үндэс нь цэцгийг тэжээж өгдөг. Нахиалахаас нь эхлэн цэцэглэх хүртэлх ажлын төлөвлөгөөг жилээр нарийн төлөвлөн гаргах, хангалттай нөөц, дэмжлэгийг бүрдүүлэх нь нэн чухал юм. **[Үйл явцыг загварчлах: хэрэгцээнд тулгуурласан хариу үйлдэл үзүүлэх]**
5. Үр дүнгийн талаарх ойлголтыг хүн бүрт ойлгомжтой байдлаар цэгцтэй хүргэх. Таны мөрөөдлийн цэцэг бодит болж биелэсэн үед олон нийтэд сурталчилгаа байдлаар тусгай загварыг боловсруулан харуулах буюу дүрслэн үзүүлэх аргыг ашиглаж болно. **[Дүрслэн харуулах: өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдөх]**
6. Хүмүүсээс ирсэн санал хүсэлт, үнэлгээг тусгах нь чухал. Энэхүү ажлыг хийх үр дүнтэй аргуудын нэг бол бүх оролцогчдоос давуу болон сул талыг нь судлаж, дүгнэлт хийх явдал юм.
7. Дээрх бүх хүчин зүйлсийг нэгтгэж хүчирхэгжих үйл явцыг бий болгох загварыг бүтээх бөгөөд энэ талаар дараачийн хэсэгт дэлгэрэнгүй үзэх болно. Хүчирхэгжих үйл явц нь хоорондоо уялдаа бүхий логик загвар дээр тулгуурладаг бөгөөд энэ нь 1) Зорилго 2) Одоогийн нөхцөл байдал 3) Үндэслэл буюу суурь нөхцөл 4) Нөлөөлөх хүчин зүйлс 5) Дэмжих аргууд 6) Нөхцөл байдлын логик үндэслэл зэргээс бүрдэнэ.

(3) Хамтын ажиллагааг загварчлах нь

Хүчирхэгжих үйл явцад суурилсан загварчлалын аргыг хэрэглэх нь холбогдох талуудын хэрэгцээ, зорилгыг тусгасан шийдлүүдийг боловсруулахад оновчтой байдаг (Зураг 6). Энэхүү загварын гол онцлог нь тухайн төслийн зорилго болон дэмжлэгийн арга замууд амжилтад хүргэх эсэхийг тодорхойлох үйл явц, үндэслэлийг ил тод, ойлгомжтойгоор харуулдагт оршино. Түүнчлэн тус загвар нь төслийн үр дүн, амжилтыг үнэлэхээс гадна төслийн хэрэгжилтийн

үйл явц (яаж), мөн үндэслэл, учир шалтгааны холбоос (яагаад)-ыг логик дарааллаар тайлбарлах боломжийг олгодог (Anmé & McCall, 2008).



Зураг 6. Хүчирхэгжих үйл явцыг дэмжих загвар (Анмэ, 2005)

Эдгээр асуудлыг дараах зургаан алхмын дагуу логик дарааллаар уялдуулан авч үзнэ:

- Алхам 1: Хүрэхээр зорьж буй үр дүн юу вэ?
- Алхам 2: Одоогийн нөхцөл байдал ямар байна вэ?
- Алхам 3: Суурь нөхцөл, орчны ямар хүчин зүйлс нөлөөлж байна вэ?
- Алхам 4: Асуудал, гол сорилтууд болон суурь хүчин зүйлсэд нөлөөлж буй үндсэн шалтгаанууд юу вэ?
- Алхам 5: Дэмжлэгийн ямар арга хэмжээ, стратеги хэрэгжүүлэх боломжтой вэ?
- Алхам 6: Ямар үндэслэлд тулгуурлаж байна вэ?

Номын хоёрдугаар бүлэгт дээр дурдсан хүчирхэгжих үйл явцын загварыг төсөл, хөтөлбөрүүдэд хэрхэн хэрэгжүүлэх талаар нэмэлт тайлбар, мэдээллийг тусгасан. Холбогдох кейс судалгаануудаас энэ загварын практик хэрэглээг илүү дэлгэрүүлэн судлах боломжтой.

11. Хүчирхэгжих орчныг бүрдүүлэх найман бүрэлдэхүүн хэсэг

Хүчирхэгжих орчныг бүрдүүлэхийн тулд хүчирхэгжилтийн найман үнэт зүйлс гэж үзэж болох бүрэлдэхүүн хэсгүүдийг мэдэж байх шаардлагатай (Анмэ, 2008). Эдгээр нь хүчирхэгжих үйл явцыг дэмжихээс гадна үр дүнг үнэлэх гол шалгуур болдог.

(1) Эмпати (бусдыг ойлгож мэдрэх чадвар)

Эмпати чадвар нь хүчирхэгжих орчныг бүрдүүлэхэд салшгүй чухал хүчин зүйл болдог. Эмпати гэдэг нь хувь хүн өөрийн хүсэл, зорилгыг ухамсарлахын зэрэгцээ бусдын хүсэл, зорилго, байр суурийг хүлээн авч, сэтгэлдээ тусган ойлгох сэтгэлзүйн чадвар юм.

Эмпати нь зөвхөн хүмүүсийн хоорондын харилцаагаар хязгаарлагдахгүй. Байгууллага, төсөл, хөтөлбөрийн зорилго, үйл ажиллагааны агуулга,

хэрэгжилтийн явц, түүнчлэн гарч буй үр дүн, хувь нэмрийг харилцан ойлгож, бусадтай солилцох нь хүчирхэгжих үйл явцыг хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлдэг. Эмпати ур чадвар өндөр, багийн гишүүдийн хоорондын харилцаа сайтай хөтөлбөрүүд нь хүчирхэгжих үйл явцыг илүү үр дүнтэй, тогтвортой урагшлуулах нөхцөлийг бүрдүүлдэг.

(2) Өөрийгөө бүрэн дайчлах

Өөрийн боломжийг бүрэн дайчлах гэдэг нь хүн өөрийн хийж буй үйл ажиллагаагаар дамжуулан өөрийн үнэт зүйлийг танин мэдэх үйл явц юм. Хүүхэд, ахмад настан гэлтгүй хүн бүр өөрийн хийж буй үйлдлээсээ баяр баясал, утга учрыг мэдэрсэн үед илүү идэвхтэй болдог. Өөрийгөө бүрэн дайчлах боломжийг олгодог аливаа үйл ажиллагаа нь хүмүүсийн хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлж, тухайн үйл ажиллагаанд тогтвортой оролцох нөхцөлийг бүрдүүлдэг.

(3) Салбар хоорондын шинж чанар

Салбар хоорондын шинж чанар нь хүн бүр бусдын үйл хэрэг, асуудалд өөрийнх мэт хандаж, идэвхтэй оролцох байдлаар илэрхийлэгддэг. Хувь хүний оролцоо нь хамтын зорилгод хүрэхийн тулд өөрийн үүргийг тодорхой ойлгож, ухамсартайгаар хүлээн зөвшөөрсөн байдлыг илэрхийлнэ.

Хэрэв хүн өөрийн байр суурь, гүйцэтгэх үүргийг тодорхой ойлгохгүй бол тухайн асуудлыг өөрийнх мэт хүлээн авч ойлгоход хүндрэл үүсдэг. Ялангуяа олон хүн хамтран ажилладаг төсөл, байгууллагын орчинд хүмүүс заримдаа тодорхой зорилго, шалтгаангүйгээр үйл ажиллагаанд оролцох нь элбэг бөгөөд өөрсдийн оролцоог бодитоор мэдрэх, өөрийгөө тухайн үйл ажиллагааны нэг хэсэг гэж ойлгоход бэрхшээл тулгардаг.

Хүчирхэгжих үйл явцыг дэмжихийн тулд хүн бүр тодорхой үүрэгтэй байж, нийт үйл ажиллагаанд өөрийн хувь нэмрийг оруулах шаардлагатай. Тэрхүү хувь нэмэр нь бага байсан ч хамтын зорилгод хүрэхэд чухал ач холбогдолтой.

(4) Оролцоо

Оролцоо нь хүн бүр багийн үйл ажиллагаанд бодитоор нөлөөлж, хувь нэмэр оруулж байгаа эсэхийг үнэлэх шалгуур болдог. Энэ нь зөвхөн биеэр оролцохоор хязгаарлагдахгүй бөгөөд хувь хүн өөрийн оролцоог утга учиртай, ач холбогдолтой гэж хэрхэн мэдэрч байгааг илэрхийлдэг.

Салбар хоорондын шинж чанар ба оролцооны ялгаа нь оролцоо тодорхой үйлдэл, хэлбэрээр илэрч, хувь хүн болон бусдын хувьд ажиглагдах, танигдах боломжтой байдгаараа тодорхойлогдоно. Хүмүүс бусдын зүгээс хүлээн зөвшөөрөгдөх үед өөрсдийн оролцооны утга учир, ач холбогдлыг илүү тодорхой ойлгодог. Оролцооны бодит илрэл нь хувь хүний оролцоог баталгаажуулж, бусдаар хүлээн зөвшөөрөгдөх нөхцөлийг бүрдүүлдэг. Хамтын бүтээлч оролцоог дэмжсэн арга хэмжээ нь хувь хүний өдөр тутмын амьдралыг утга учиртай, үнэ цэнтэй болгодог.

Хүмүүсийн дотоод сэдэл, эрмэлзлийг хөгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх нь чухал. Үүний тулд тэднийг үнэ цэнтэй, утга учиртай үйл ажиллагаанд тогтмол оролцоход нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

(5) Тэгш байдал

Тэгш байдал, шударга ёс нь оролцогч талууд болон гишүүдийн хоорондын эв нэгдлийг дэмжихэд зайлшгүй чухал хүчин зүйл юм. Хэрэв төсөл, хөтөлбөр

шударгаар хэрэгжихгүй, хүмүүст өгч буй зөвлөмж, зөвлөгөө болон тэдэнд хандах хандлага нь шударга бус мэт санагдвал оролцогч талууд идэвхтэй, санаачилгатай ажиллахад хүндрэлтэй болдог. Мөн эрх тэгш байдлыг мэдрэхгүй тохиолдолд оролцогч талуудын урам зориг буурч, оролцоо нь сулрах хандлагатай байдаг. Иймээс бүх оролцогч талуудад тэгш боломж, шударга хандлагыг бий болгох нь чухал юм.

Бүх оролцогч талуудад ижил тэгш хандах боломжгүй нөхцөлд шударга ёсыг хангах нэг арга нь хүлээн зөвшөөрөхүйц үндэслэл, шалтгааныг ойлгомжтой тайлбарлаж, хүн бүр хүлээн зөвшөөрөхөд бэлэн байх орчныг бүрдүүлэх явдал юм.

(6) Стратегийн олон талт байдал

Стратегийн олон талт байдал нь хувь хүн, бүлэг, хүрээлэн буй орчны чадавхыг бэхжүүлэхийн зэрэгцээ төсөл, хөтөлбөрийн хөгжилд шаардлагатай төрөл бүрийн нөөцийг ашиглах нөхцөлийг бүрдүүлдэг. Түүнчлэн хүмүүсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ ашиглаж болох нөөцийн төрөл, олон талт байдлыг мөн анхаарч үзэх хэрэгтэй.

(7) Уян хатан байдал

Уян хатан байдал нь өөрчлөгдөж буй нөхцөл байдалд дасан зохицох чадварыг илэрхийлдэг бөгөөд хувь хүн болон байгууллагын хөгжлийг тодорхойлох чухал үзүүлэлт болдог. Гүйцэтгэлийн үнэлгээ хийхдээ өөрчлөгдөж буй нөхцөл байдал, оролцогчдын өөрчлөлтөнд уян хатан дасан зохицож, үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлэх чадавхыг харгалзан үзэх хэрэгтэй.

(8) Инноваци буюу шинэлэг санаа

Инноваци нь ирээдүйн хөгжил, тогтвортой байдлыг хангах чухал хүчин зүйл бөгөөд оролцогч талуудад итгэл найдвар, аюулгүй байдлын мэдрэмжийг төрүүлдэг. Ирээдүйг урьдчилан төсөөлөх нь зан үйлийн чиг хандлага, хэм хэмжээг тодорхойлохын зэрэгцээ үүрэг, хариуцлагыг стратегийн түвшинд оновчтой тодорхойлох боломжийг бүрдүүлдэг. Төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэлийн үнэлгээ хийхдээ өсөлт болон урт хугацааны тогтвортой хөгжлийг дэмжих инновацийн боломж, чадавх байгаа эсэхийг харгалзан үздэг.

12. Хүчирхэгжих орчныг бүрдүүлэх долоон зөвлөмж

Хүчирхэгжих үйл явцыг үр дүнтэй дэмжих зөвлөмжүүдийг тайлбарлан хүргэж байна (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Хүчирхэгжих үйл явцыг дэмжих долоон зөвлөмж (Anme, 2008)

1. Тодорхой зорилготой байх
2. Тааламжтай харилцааг бий болгох
3. Бусдыг ойлгох, ойлголцол дээр тулгуурласан сүлжээг бий болгох
4. Ая тухтай, тайван орчинг бүрдүүлэх
5. Оролцооны уян хатан хэлбэрийг бий болгох
6. Үргэлж хөгжил дэвшлийг зорих
7. Бодит үнэлэлт, дүгнэлт өгөх

(1) Тодорхой зорилготой байх

Юуны өмнө холбогдох бүх оролцогч талуудыг хамруулах нь чухал. Оролцогч талууд гэдэгт зөвхөн тухайн асуудалд шууд оролцож буй хүмүүсийг бус, харин холбоо хамаарал бүхий бүх хүмүүсийг хамруулна. Тухайлбал дэмжлэг шаардлагатай хүмүүс, ажил олгогчид, үр шим хүртэгч гэр бүлийн гишүүд, найз нөхөд, мөн тухайн төсөл хөтөлбөртэй холбоотой орон нутгийн иргэд орох боломжтой. Зорилгуудыг оролцогч талуудын хэрэгцээ, үнэт зүйлстэй уялдуулан тодорхойлох шаардлагатай. Эдгээр үнэт зүйлс нь зорилтот үр дүнд хүрэх үйл явцад мөрдөх стандарт, бодлогын үндсийг агуулсан байх ёстой. Бүх гишүүдийн үнэт зүйлсийг нэгтгэснээр бүлэг хамт олны нийтлэг сэтгэлгээ, хэв маяг, зарчим, үйл ажиллагааны чиглэлийг агуулсан нэгдсэн суурь бүрэлдэнэ.

Оролцогчдын үнэт зүйлстэй нийцсэн үр дүнг танилцуулах нь нэгдмэл байдлыг бэхжүүлж, тэдний идэвхтэй оролцоог дэмжих чухал нөлөөтэй. Харин тодорхой төсөл, үйл ажиллагаанд нийцүүлэх зорилгоор хамтын үнэт зүйлсийг энгийн байдлаар тусгаж оруулах нь гишүүдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх боломжийг бууруулдаг. Учир нь хүмүүс бусадтай болон нийгэмтэйгээ бодит харилцаа холбоо тогтоож, харилцан ойлголцлыг мэдэрч байх үедээ өөрийн оршин буй утга учир, хийж буй ажлынхаа үр дүнг илүү гүн гүнзгий ойлгодог. Иймээс хувь хүний үнэт зүйлсийг хүндэтгэхийн зэрэгцээ бүлэг, байгууллагын зорьж буй хамтын үнэт зүйлсийг тогтмол хүлээн зөвшөөрч, тодорхой байдлаар илэрхийлж хэлэлцэж байх нь хамгийн чухал юм.

Түүнчлэн **бусдыг ойлгож мэдрэх чадварт** суурилсан үнэт зүйлсийг төлөвшүүлэх хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Энэхүү үнэт зүйлс нь гишүүдэд мэдлэгээ солилцох, асуудал шийдвэрлэх, шинэ санаа дэвшүүлэх, цаашдын үйл ажиллагаанд оролцох замаар бодит хувь нэмэр оруулж чадна гэсэн ойлголт, итгэлийг төрүүлдэг. Үнэт зүйлс нь оролцогчдын хамтын оролцоо, харилцан ойлголцолд тулгуурлан бүрэлдэх ёстой.

Тухайн үнэт зүйлсийг тодорхойлохдоо бүлгийн гишүүдээс гадна дэмжлэг үзүүлэгчид болон гаднын мэргэжилтнүүдийн оролцоог хангах нь зүйтэй. Тухайн үнэт зүйлс, санал санаачилгатай холбоотой, нийгмийн ач холбогдол болон оролцогчдын чадавхыг хэрхэн илүү хөгжүүлэх боломжтой талаар мэргэжилтнүүдийн олон талт санал, зөвлөмжийг авах хэрэгтэй.

(2) Тааламжтай харилцааг бий болгох

Хүмүүс, олон нийтийн хоорондын харилцаа болон тодорхой зорилгын төлөө хамтран ажиллах үйл явцаар дамжин харилцан тааламжтай байдал бүрэлдэн бий болдог.

Бусадтай харилцахдаа сэтгэл ханамжтай байх нь хүчирхэгжих үйл явцын чухал зарчим бөгөөд энэ нь бусдыг ойлгож, мэдрэхийн тулд өөрийгөө дайчлах эрмэлзэл дээр суурилдаг. Хүмүүс хамтдаа баяр баясал, урам зоригийг мэдрэхэд харилцан уялдаа бүхий хэд хэдэн хүчин зүйл чухал нөлөө үзүүлдэг. Үүнд сайн дурын оролцоонд тулгуурлахаас гадна бусадтай харилцах явцдаа баяр баясал, урам зоригийг мэдэрч болох **нээлттэй уур амьсгал бүхий орчинг** бүрдүүлэх, мөн үр өгөөж нь шууд тодорхой харагдахгүй байсан ч тухайн хувь хүнд ямар нэгэн зүйлийг сурч мэдэж, олж авч байна гэсэн мэдрэмж төрүүлэхүйц **харилцан ашигтай** нөхцөлийг бий болгох нь чухал бөгөөд энэ бүхэн нь **итгэлцэл** дээр үндэслэдэг. Күнз “Мэдэх нэг хэрэг, дуртай

байх нь түүнээс илүү, харин жинхэнээсээ хүсэн тэмүүлж, баяр баясалтайгаар хичээх нь хамгийн эрхэм” хэмээн хэлсэн байдаг. Амжилтад хүрэх хамгийн үр дүнтэй арга бол хийж буй зүйлээсээ баяр баясал, утга учрыг мэдрэх явдал юм.

Хүчирхэгжилтийг харилцаанд суурилсан үйл явц гэж ойлгож болно. Иймээс хүмүүс болон олон нийтийн хоорондын харилцаа холбоог бэхжүүлж, эдгээр харилцаанаас баяр баясал, аз жаргал мэдрэх боломжтой орчныг бүрдүүлэх нь чухал юм.

(3) Эмпати сүлжээг бий болгох буюу бусдыг ойлгож мэдрэх боломжийг бүрдүүлэх

Эмпати сүлжээ нь хүмүүсийг хооронд нь холбож, ойр дотно байдал болон эерэг, бүтээлч идэвхийг мэдрүүлэхэд чиглэдэг. Ойр дотно байдал нь тайвшрал, аюулгүй мэдрэмжийг төрүүлдэг бол идэвхи чармайлт нь сэргэлт, эрч хүчийг бий болгодог. Эдгээр хоёр талыг хослуулснаар хүчирхэгжих үйл явц улам эрчимждэг.

Хүмүүсийн хоорондын харилцаа бат бөх, ойр дотно байх тусам олон нийтийн үйл ажиллагаа улам баяжиж, өргөжин тэлдэг. Мөн өдөр тутмын харилцаанд тулгуурласан итгэлцэл нь шинэ санаачилга, хамтын үйл ажиллагааны бат бөх суурь болдог.

Бусдыг ойлгож, мэдрэх боломж бүхий эмпати сүлжээг хөгжүүлэхийн тулд үйл ажиллагааг тогтмол зохион байгуулахын зэрэгцээ шинэ, сонирхолтой санаагаар баяжуулан хэрэгжүүлэх нь чухал юм. Мөн төрөл бүрийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулснаар харилцаа холбоо бэхжиж, оролцооны хүрээ өргөгддөг. Энэ нь шинэ хүмүүстэй харилцаа тогтоох, харилцан ойлголцлыг бэхжүүлэх, сонирхол татахуйц сэдвүүдийн хүрээнд үйл ажиллагааг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

(4) Тав тухтай мэдрэмжийг бий болгох

Хүний тархи, мэдрэл судлалын судалгаагаар хэмнэлд суурилсан өдөөлт нь тархинд тайвшрал, тайтгарлын мэдрэмж төрүүлдэг болох нь тогтоогдсон. Байгаль дахь бүх үзэгдэл тодорхой хэмнэлд оршин тогтнож, зохион байгуулагддаг. Ургамал, амьтны өсөлтийн мөчлөгөөс эхлээд орчлон ертөнцийн тэлэлт хүртэлх бүхий л үйл явц нь өсөлт ба түр зогсолт, давталт ба өөрчлөлтийн хэмнэлд тулгуурлан өсөж хөгжиж өөрчлөгдөж байдаг байна. Энэхүү зарчим нь хувь хүн, хамт олон болон нийгмийн хөгжилд ч мөн адил хамааралтай. Хүмүүс хоорондын харилцаа, түүнчлэн хувь хүн ба хамт олон, хувь хүн ба нийгмийн харилцаа холбоо гүнзгийрэн тэлэхийн хэрээр өсөлт хөгжил бий болдог.

Өсөлт, хөгжлийг дэмжихийн тулд хэмнэлийг зориудаар бий болгож, тогтвортой хадгалах нь чухал. Хувь хүн, хамт олон, байгууллагын аль ч түвшинд хэмнэл нь хөгжлийг урагшлуулах үндсэн хүчин зүйл болдог. Жишээлбэл, хүн бэрхшээлтэй тулгарч, хүлээлтийн байдалд байгаа мэт харагдсан ч урт хугацааны өнцгөөс харахад энэ үе шат нь дараагийн томоохон ахиц дэвшлийн өмнөх чухал бэлтгэл болдог. Хүн судлалын шинжлэх ухааны судалгаанууд нь хүний дотоод эмзэг байдал нь тэсвэр хатуужлыг төлөвшүүлж, бэрхшээлийг даван туулах чадварыг бэхжүүлэхийн зэрэгцээ бусдыг ойлгож, хүндэтгэн хандах эмпати чадварыг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлдгийг баримтаар нотолсон байдаг. Загас үржүүлгийн салбарт заримдаа жижиг загаснуудыг зориуд том загастай хамт байлгаж, ‘түгшүүртэй орчин’ бүрдүүлдэг. Энэхүү зохиомол дарамт нь жижиг

загасны идэвхийг нэмэгдүүлж, насжилтыг уртасгах төдийгүй үржил шимийг нь сайжруулахад эерэгээр нөлөөлдөг гэж үздэг байна.

Хэмнэл бол долгионлог шинж чанартай хөдөлгөөн юм. Хэмнэл нь хүний биед зүрхний цохилт, тархины долгион хэлбэрээр үйлчилж, энергийг бие махбодод түгээхэд тусалдаг. Түүнчлэн хэмнэл нь тодорхой нэг үзэл санаа, хүмүүс болон хамт олныг нэгтгэж, эрч хүчээр сэлбэн идэвхжүүлж байдаг.

Тав тухтай, тайван мэдрэмжийг бүрдүүлэхэд дараах арга хэмжээнүүд үр дүнтэй:

1. Хүний нийгмийн харилцаанд олон тооны хүмүүстэй харилцах нь сэтгэлзүйн өдөөлт, шинэ туршлага өгдөг бол гүнзгий, итгэлцэл дээр суурилсан ойр дотно харилцаа үүсгэх боломж нь сэтгэл зүйн тогтвортой байдал, дэмжлэгийг бий болгодог. Иймээс олон хүмүүстэй харилцах замаар авах өдөөлт болон ойр дотно харилцаа үүсгэх боломжийн хооронд тэнцвэрийг хадгалах нь чухал юм.
2. Шинэ санаа, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх хэлэлцүүлэг, мэтгэлцээн болон өмнө нь хуримтлагдсан мэдлэг, туршлагыг түгээх сургалтын үйл ажиллагааны хооронд тэнцвэрийг хадгалах.
3. Төрөл бүрийн хүмүүсийн ирж, буцах хөдөлгөөний урсгал болон олон талт үйл ажиллагааны уялдаа бүхий хэмнэлийг бий болгож, түүнийг эмх цэгцтэйгээр зохицуулах.
4. Хувь хүний харилцаа болон хөгжилд чиглэсэн дотоод хэмнэл, мэдрэмжийг ухамсарлан ойлгох.
5. Тухайн нөхцөл байдалд нийцсэн хэмнэлийг зорилготойгоор бий болгох.

Хүчирхэгжих үйл явцыг дэмжихийн тулд өөрчлөлтөд хариу үйлдэл үзүүлэх болон эмх цэгцийг хадгалах үе шатуудын хооронд зохистой хэмнэл бий болгох нь чухал юм. Өөрчлөлт гэдэг нь хувь хүн өөрийн орчны өөрчлөлтөд мэдрэг байж хариу үйлдэл үзүүлэх чадварыг илэрхийлдэг бол эмх цэгц нь дасан зохицох болон цаашид өргөжүүлэхэд шаардлагатай арга барилыг илүү үр дүнтэй, үр ашигтайгаар зохион байгуулах үйл явц юм. Хувь хүн болон хамт олон өөрсдөө тэр бүр ухамсарладаггүй боловч шийдвэр гаргахад чиглэл болдог үнэт зүйлсийн тогтолцоог шүүн тунгаах, системтэйгээр эргэн харах, дахин үнэлэхээс өөрчлөлтийг бий болгох үйл явц эхлэх нь зүйтэй. Үүний үндсэн дээр тэдгээр үнэт зүйлс нь хэр зэрэг зохимжтой болохыг магадлан, шаардлагатай бол засч сайжруулах замаар хэрэгцээ шаардлагад нийцүүлэн уян хатан байдлаар өөрчлөн зохицуулах учиртай. Энэхүү үйл явцын хамгийн гол зангилаа нь эдгээр суурь үндэслэлийг юун түрүүнд тодорхойлон нягталж, хянан үнэлэх явдал юм.

Өөрчлөлтийг бий болгохын тулд тогтсон үзэл баримтлал, арга барилаас давж гарах нь зайлшгүй шаардлагатай. Гэвч бодит байдал дээр хувь хүмүүс болон хамт олон уламжлалт ойлголтоо орхих чадвар сул бөгөөд ялангуяа өмнө нь амжилттай байсан арга барилдаа баригдмал байх хандлагатай байдаг. Иймээс шаардлагатай өөрчлөлтийг хэрэгжүүлэхийн оронд хэвшмэл үзэл баримтлал, арга барилыг илүү үр ашигтайгаар үргэлжлүүлэн ашиглахыг эрмэлздэг.

Өөрчлөлт хийх болон эмх цэгцийг хадгалах шаардлагатай нөхцөлүүдийг нарийвчлан ялган тодорхойлох нь чухал юм. Өөрчлөлт нь эмх цэгцийн эсрэг ойлголт бөгөөд тогтсон үзэл баримтлал, хэвшмэл төсөөллийг задлан шинжлэх үйл явцыг илэрхийлэхийн зэрэгцээ зарим нөхцөлд өөрөө ч энэ үйл явцын объект болж хувирч болдог.

Өөрчлөлтөд дасан зохицохын тулд хувь хүн болон хамт олны үзэл баримтлал, шийдвэр гаргалтад нөлөөлж буй суурь тогтолцоог үнэлж, шаардлагатай шинэчлэлийг хийх хэрэгтэй болдог. Харин эмх цэгцийг хадгалахын тулд нийтлэг үнэт зүйлсийг төлөвшүүлэх нь чухал. Энэхүү зохицол нь хувь хүн, хамт олныг нэгдмэл хэмнэлд нэгтгэж, тэдний чадамжийг бодитоор илэрхийлэн хүчирхэгжүүлэх суурь болдог.


(5) Оролцооны уян хатан хэлбэрийг санал болгох

Хүмүүсийн оролцооны хэлбэр, гүйцэтгэх үүргийг хэт хатуу тогтоохгүй байх нь чухал юм. Уян хатан байдлыг олгосноор цаг хугацааны явцад гарч буй хувьсал, өөрчлөлтийг таньж мэдэх, түүнд зохицох боломж бүрддэг. Оролцооны хэлбэрүүдийг дараах байдлаар ангилж болно (Зураг 7):

1. Зохицуулагч: Зохион байгуулалтын үйл явцыг удирдан чиглүүлж, ажлын төлөвлөгөө болон байгууллагын хүрээнд шаардлагатай зохицуулалт хийдэг хүн
2. Гол гишүүн: Төлөвлөлт болон хэрэгжилтийн үйл ажиллагаанд голлох үүрэгтэйгээр оролцдог хүн
3. Идэвхтэй гишүүн: Өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол, идэвхтэй оролцдог хүн
4. Хамтран оролцогч: Зөвхөн өөрийн сонирхсон үйл ажиллагаандаа оролцдог хүн
5. Зөвлөх гишүүн: Шаардлагатай үед мэргэжлийн мэдлэг, техникийн дэмжлэг үзүүлдэг хүн

Үйл ажиллагааг төлөвлөхдөө бүх оролцогчид өөрсдийн үүргийг хүссэн үедээ хэрэгжүүлэх боломжтой мэтээр мэдрэх нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй.

Оролцоог албадлагаар хэрэгжүүлэхийн оронд хүмүүсийг соронз мэт татахуйц уур амьсгалыг бүрдүүлж, тэднийг чөлөөт байдлаар оролцохыг дэмжих нь хүчирхэгжүүлэх үйл явцыг амжилттай хэрэгжүүлэх үр дүнтэй арга юм. Мөн оролцооны хэлбэрүүдийг уян хатан, харилцан шилжих боломжтой байлгах нь чухал бөгөөд ингэснээр аливаа гишүүн хэрэгцээ, нөхцөл байдлаасаа хамааран гол гишүүн эсвэл идэвхтэй гишүүний үүргийг гүйцэтгэх боломжтой болно.



Зураг 7. Оролцооны хэлбэрүүд

(6) Үргэлж хөгжил дэвшлийг зорих

Хувь хүн болон хамт олон нь нэгэн хэвийн төлөвт, өөрчлөгдөхгүй тогтвортой орших боломжгүй юм. Тэд ирээдүй рүү тэмүүлж, тасралтгүй хөгжин дэвшихийг эрмэлздэг. Хатуу тогтсон хэв маягт баригдахгүйгээр уян хатан, нээлттэй хандлагыг эрхэмлэх нь олон гишүүдэд хүлээн зөвшөөрөгдөх үндэс болно. Орчин нөхцөлдөө дасан зохицохын хэрээр идэвхтэй үйл ажиллагаанууд аяндаа бий болдог

Хүчирхэгжих үйл явцын зорилго нь эрч хүчээр дүүрэн хувь хүн болон олон нийтийг бий болгоход оршино. Хүмүүс өөрсдийн дотоод нөөц, боломжоо нээж, идэвхжүүлэхэд нь дэм болсноор бодит өөрчлөлтийг бий болгох боломж бүрддэг.

АНУ-д хар тамхины хамааралтай хүмүүст зориулсан дэмжих бүлэг үүсгэн байгуулсан Чарльз Дедерих нэгэнтээ ‘Өнөөдөр бол таны үлдсэн амьдралын эхний өдөр юм’ хэмээн хэлсэн байдаг.

Ирээдүйг эрч хүчтэй, эерэгээр харахын тулд үргэлжид хөгжин дэвших зорилго бүхий төлөвлөгөөтэй байх нь чухал юм.


(7) Бодит үнэлэлт, дүгнэлт өгөх

Үйл ажиллагааны ач холбогдлыг бүрэн дүүрэн ухамсарлахын тулд түүний мөн чанар, утга учрыг танин мэдэж, зөв үнэлж дүгнэх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм. Олон нийтийн үйл ажиллагааны зорилго, үр дүн, үр нөлөө болон зардлыг нарийн ойлгосноор оролцогчид сэтгэл ханамжийг мэдэрч, ирээдүйн талаар илүү өргөн, тодорхой алсын хараатай болох боломж бүрддэг.

Хүчирхэгжих үйл явцыг дэмжих үүднээс үйл ажиллагааны үнэ цэнийг байнга таниулах шаардлагатай. Үйл ажиллагааг хэрэгжих явцад нь үнэлж, бодитой дүгнэлт хийх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм. Ил харагдаж буй болон боломжит нөөц чадварын түвшинг тодорхой болгож, шинэ арга замуудыг санал болгосноор ирээдүйд үүсэж болзошгүй асуудлуудыг урьдчилан таамаглах боломж бүрдэнэ.

Үнэлгээний ажлын хүрээнд үнэт зүйлсийг тодорхой болгосноор хувь хүмүүс болон олон нийтийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх хүчин зүйлсийг илрүүлэх боломжтой болдог. Үр дүнтэй үнэлгээ нь тухайн олон нийтийн бодит мөн чанарыг гүнзгий ойлгох чадвартай, дотоод болон хөндлөнгийн үнэлэгчдийн хамтын ажиллагаагаар тодорхойлогддог.

Үнэлгээний үндсэн зорилго нь гарсан үр дүн, дүгнэлтийг дараагийн шатанд үр ашигтайгаар хэрэглэхэд оршино. Томас Эдисон “Би хэзээ ч бүтэлгүйтэж байгаагүй, зүгээр л ашиглаж болохгүй мянга мянган аргуудыг олж мэдсэн” хэмээн хэлсэнчлэн үнэлгээг цаашдын хөгжил рүү хөтлөх нэгэн шат, алхам болгон ашиглах хандлагыг төлөвшүүлэх нь нэн чухал юм.



1. Хүчирхэгжих үйл явцыг дэмжих нотолгоонд суурилсан практик үйл ажиллагаа

Нотолгоонд суурилсан хүчирхэгжих үйл явцын үндсэн тулгуур нь мэргэжлийн хандлага, ур чадвар юм. Үүнд нотолгоог оновчтой тогтоох болон тухайн нотолгоог үр дүнтэй ашиглах чадварууд багтана.

Мэргэжлийн хандлага (мэргэжилтний үзэл баримтлал, чиг баримжаа): Мэргэжлийн хандлага нь “хувь хүний хамгийн эрхэм ашиг сонирхлыг ямагт хамгаалах” гэсэн бат бөх итгэл үнэмшил дээр суурилдаг. Түүнчлэн энэ нь хувь хүний хүчирхэгжих үйл явцыг дэмжихийн зэрэгцээ тэдний хөгжлийг дэмжихүйц олон нийт, нийгмийн орчныг бүрдүүлэхэд чиглэнэ. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн хандлага гэдэг нь хувь хүний хөгжих болон бусдын хөгжлийг хурдасган тэтгэх чадварыг дэмжихийн тулд өөрийн нөөц бололцоог бүрэн дүүрэн дайчлахыг хэлнэ.

Мэргэжлийн ур чадвар (мэргэжилтний мэдлэг болон арга зүй): Эдгээр ур чадвар нь шинжлэх ухааны үндэслэлтэй болон практик туршлагаар баталгаажсан өргөн хүрээний мэдлэг, арга техникүүд багтдаг. Мэргэжилтнүүд өөрсдийн ур чадварыг амьдрал дээр хэрэгжүүлэхийн тулд логик дараалал бүхий дэмжлэг үзүүлэх загвар болон төрөл бүрийн арга хэрэгслүүдийг ашиглах шаардлагатай байдаг.

Хүний насан туршийн хөгжлийг дэмжих болон эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн олон нийтийн хүлээлт, эрэлт хэрэгцээ тасралтгүй өссөөр байна. Иргэд болон нийгмийн зүгээс шаардаж буй энэхүү мэдээлэл, тусламжийг бодит болгохын тулд мэргэжилтнүүд тусгайлсан ур чадваруудыг эзэмшсэн байх хэрэгцээ үүсдэг.

Энэхүү хамтын ажиллагаанд зайлшгүй чухал зүйл нь салбар хоорондын хил хязгаарыг давсан нийтлэг ойлголцол бөгөөд өөрөөр хэлбэл энэ нь нотолгоонд суурилсан хүчирхэгжих үйл явцын нэг хэсэг юм.

Мэргэжлийн ур чадварыг ашиглан нотолгоог баталгаажуулах, түүнийг бодитойгоор ашиглахын тулд дэмжлэгийн үйл явцад нийцсэн дараах гурван арга техник зайлшгүй шаардлагатай байдаг:

- 1) Хувь хүн болон нийгэмд буй “бодит хэрэгцээ”-г тодорхойлох чадвар (жишээлбэл, гол асуудал, шинж тэмдэг)
- 2) Тухайн “бодит хэрэгцээ”-нд тулгуурлан хувь хүн болон нийгмийн тухайд хамгийн үр дүнтэй тусламж үйлчилгээг зохион байгуулах, хэрэгжүүлэх арга техник
- 3) Хийсэн ажлын үр нөлөөг үнэлж, (ямар нэгэн үр дүн гарсан эсэх?) түүндээ тулгуурлан цаашдын үйл ажиллагааг сайжруулах ур чадвар зэрэг болно.





Зураг 8. Мэргэжлийн ур чадвараар дамжуулан хүчирхэгжих үйл явцыг дэмжих нь

Энэхүү үйл явцыг Зураг 8-ын дагуу илүү тодорхой, дэлгэрэнгүй авч үзье:

1. Хүмүүсийн үг яриа, үйлдлээрээ илэрхийлж буй хэрэгцээ нь тэдний жинхэнэ “бодит хэрэгцээ” биш байх нь элбэг. Тэдний бодит хэрэгцээ (дотоод мэдрэмж, чин хүсэл) нь ихэвчлэн эдгээр үг, үйлдлийн цаана нуугдаж байдаг. Иймд тусламж үйлчилгээ үзүүлэхдээ зөвхөн “хувийн таамаглал”, “ажлын туршлага”- д найдахын оронд асран хамгаалагчдын өгсөн мэдээлэл болон бодитоор ажиглагдсан үйлдлүүдийг бусад мэргэжилтнүүдтэй зөвшилцөн, мэдээлэл солилцох нь чухал юм. Үүний зэрэгцээ нотолгоонд суурилсан үнэлгээний аргуудыг ашигласнаар үнэн бодит хэрэгцээг илүү оновчтой тодорхойлох боломж бүрдэнэ. Эдгээр арга хэрэгслүүд нь мэргэжилтнүүдийн хамтын мэдлэгийг шингээсэн байдаг тул тэднийг хоорондоо нэгдсэн нэг ойлголтоор харилцах боломжийг олгодог.
2. Хэрэв бодит хэрэгцээг тодорхойлж чадвал түүнд тохирсон хамгийн зөв үйл ажиллагааг оновчтойгоор сонгох боломж бүрдэнэ.
3. Үйл ажиллагааг хэрэгжүүлсний дараа түүний бодит үр нөлөөг үнэлж, хүмүүс болон нийгэмд үзүүлсэн нөлөөг оновчтой тайлбарлах, мөн уг үр дүнг цаашдын үйл ажиллагааг сайжруулахад ашиглах боломжийг тодорхойлох нь чухал юм. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд нотолгоонд суурилсан үнэлгээний арга хэрэгслийг ашиглан үйл ажиллагааны үр дүнд гарсан өөрчлөлт, өөрчлөгдөөгүй талууд, цаашид авч хэрэгжүүлэх боломжит арга хэмжээний талаар бусад мэргэжилтнүүдтэй санал, дүгнэлтээ харьцуулан хэлэлцэж, нэгдсэн дүгнэлтэд хүрэх шаардлагатай.
4. Дээр дурдсан тасралтгүй үйл явцын үр дүнд мэргэжлийн ур чадвар улам боловсронгуй болж, эрүүл мэнд, нийгмийн дэмжлэгийн үйлчилгээний чанар дээшилж, хүмүүсийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааны үр нөлөө улам нэмэгдэнэ.

Нотолгоонд суурилсан дэмжлэгийн үр дүн нь уг үйл явцыг хэр зэрэг тууштай, тогтвортой, оновчтой хэрэгжүүлэхээс шууд хамаарна.

Эдгээр алхмуудыг хэрэгжүүлэхэд ямар тодорхой ур чадвар шаардлагатай вэ?

Юуны өмнө найдвартай, тасралтгүй дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай дараах гурван үндсэн чадавхыг хөгжүүлэх нь чухал юм:

1. Нотолгоонд суурилсан дэмжлэгийг тасралтгүй үзүүлэхийн тулд тусламж үйлчилгээний бүтцийг логик дараалалтайгаар төлөвлөх.
Нотолгоонд суурилсан үйл ажиллагааны загварыг хэрэглэх.
2. Асуудлыг олон талаас нь бодитоор таньж мэдэх болон нотолгоонд суурилсан дэмжих үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд олон төрлийн арга хэрэгслийг ашиглах чадвар.
Нотолгоонд суурилсан дэмжлэгийн аргуудыг хэрэглэх.
3. Дэмжлэгийн үйл ажиллагааг бодит үр дүнд хүргэх хүчирхэгжүүлэх ур чадвар.

Эдгээр алхамуудыг дараагийн хэсэгт дэлгэрэнгүйгээр тайлбарласан болно.

2. Хүчирхэгжих үйл явцыг дэмжих загвар

Тухайн хүн болон бусад мэргэжилтнүүдийн хамтран зөвшилцөж чадах, нотолгоонд суурилсан дэмжлэгийн чиглэлийг тодорхойлох нь чухал юм. Энэхүү үйл явцыг “Хүчирхэгжих үйл явцыг дэмжих загвар” гэж нэрлэдэг. Мэргэжилтнүүд тухайн хүний насан туршдаа хөгжих болон хүчирхэгжих үйл явцыг дэмжих суурь зураглал, аргачлалыг харилцан хуваалцсанаар, холбогдох бүх талууд нэгдсэн нэгдмэл ойлголтод тулгуурлан, оновчтой бөгөөд тасралтгүй дэмжлэг үзүүлэх боломж бүрддэг.

Тиймээс тухайн хүний бодит хэрэгцээ, хүсэл эрмэлзлийг тусгаж улмаар тэднийг хүчирхэгжүүлэхийн тулд “дэмжих загвар” – т суурилсан, логик учир шалтгаан бүхий дэмжлэг туслалцааны тогтолцоог хэрэгжүүлэх нь чухал. Энэхүү загвар нь зөвхөн мэргэжилтнүүдэд төдийгүй тухайн хүнд өөрт нь ч ойлгомжтой бөгөөд хамтран хуваалцаж, хэрэгжүүлэх боломжтой зорилтуудад чиглэсэн логик бүтэцтэй юм. Хувь хүнтэй үүсгэсэн түншлэлийн харилцааг эрхэмлэж, тэдний оролцох чин хүсэл эрмэлзлийг дэмжсэнээр мэргэжилтнүүд зорилго, зорилтоо тухайн хүнтэй хамтран тодорхойлохын зэрэгцээ найдвартай бөгөөд тогтвортой дэмжлэг үзүүлэх нөхцөл бүрдэнэ.

Энэ хэсэгт дэмжлэг туслалцааг логик дарааллаар төлөвлөхийн тулд “Хүчирхэгжих үйл явцыг дэмжих загвар”-ыг ашиглан үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх бүхий л хүчин зүйлсийг хэрхэн уялдаа холбоотойгоор ойлгож, практикт оновчтой хэрэглэх аргачлалыг танилцуулна (Зураг 9, 10).

Энэхүү аргын гол онцлог нь тодорхой зорилгод хүрэхийн тулд яагаад тухайн дэмжлэг шаардлагатай болохыг болон уг дэмжлэгийн үндэслэл, нотолгооны үйл явц, зураглалыг тодорхой тайлбарлаж буйд оршино. Мөн дэмжлэг туслалцааны зорилтыг хэрхэн хэрэгжүүлэх (арга, аргачлал) болон тухайн үйл ажиллагаа яагаад үр дүнтэй болохыг (нотолгоонд суурилсан) логик дараалалтайгаар тайлбарлах боломжийг олгодог.

Үүнийг нарийвчлан авч үзвэл, “Хүчирхэгжих үйл явцыг дэмжих загвар”-ыг дараах зургаан алхмын дагуу зохион байгуулж хэрэгжүүлнэ (Зураг 9, 10).

Дараах хэсгүүдэд алхам бүрийг аль болох ойлгомжтой бөгөөд хураангуй байдлаар тайлбарлах болно.

Нэгдүгээр алхам: Хүрэх үр дүн юу вэ?

Хувь хүн, гэр бүл, олон нийт юунд зорьж, ямар үр дүнд хүрэхийг хүсэж байна вэ? Тэдэнд ямар хүсэл тэмүүлэл байна вэ, ирээдүйд юу болно гэж найдаж байна вэ? Эдгээр чиглүүлэгч асуултуудыг удирдамж болгон зорилгоо тодорхойлон бичнэ. Үүнээс гадна урт болон богино хугацааны зорилго, тэдгээрт хүрэх цаг хугацаа, мөн зорилго биелэх үеийн үнэлгээний аргуудыг нарийвчлан тусгах хэрэгтэй.


Хоёрдугаар алхам: Өнөөгийн бодит нөхцөл байдал ямар байна вэ?

Бодит нөхцөл байдал ямар байгааг тодорхой болгоно. “Бодит нөхцөл байдал” гэдэгт зөвхөн хувь хүн, гэр бүл, олон нийтийн ойлгон ухамсарлаж буй зүйлээр хязгаарлагдахгүй. Үүнд тухайн хүн болон гэр бүлийнхэн нь өөрсдөө анзаарсан эсэхээс үл хамааран, мэргэжилтнүүд болон гэр бүлийн бусад гишүүдийн олж харсан, урьдчилан таамаглаж буй асуудал, зорилтуудыг мөн адил багтаана. Түүнчлэн, бодит нөхцөл байдлын давуу тал, эерэг шинжүүдийг зайлшгүй тусгах шаардлагатай.



- Алхам 1:** Зорилго тодорхойлох: Хүрэхээр зорьж буй үр дүн юу вэ?
- Алхам 2:** Бодит байдлыг тодорхойлох: Өнөөгийн нөхцөл байдал ямар байна вэ?
- Алхам 3:** Суурь нөхцөлийг судлах: Ямар суурь нөхцөл, орчны хүчин зүйлс байна вэ?
- Алхам 4:** Нөлөөлөх хүчин зүйлсийг ангилж, цэгцлэх: Асуудал, хүндрэл болон суурь нөхцөлд нөлөөлж буй гол шалтгаанууд юу вэ?
- Алхам 5:** Дэмжлэг үзүүлэх арга замыг тодорхойлох: Нөлөөлж буй хүчин зүйлсийг өөрчлөхийн тулд ямар арга хэмжээ авах вэ?
- Алхам 6:** Дэмжлэг туслалцааны үндэслэл, нотолгоог баталгаажуулах: Тухайн дэмжлэг туслалцааг ямар үндэслэл, нотолгоонд суурилан хэрэгжүүлж байна вэ?

Зураг 9. Хүчирхэгжих үйл явцыг дэмжих загварыг боловсруулах алхамууд



Зураг 10. Хүчирхэгжих үйл явцыг дэмжих загвар

Гуравдугаар алхам: Ямар суурь нөхцөл, орчны хүчин зүйлс байна вэ?

Хоёрдугаар алхамд нарийвчлан тодорхойлсон “бодит нөхцөл байдал”-д тулгуурлан, түүнийг бүрдүүлж буй “суурь нөхцөл, орчин”-ы хүчин зүйлсийг цэгцлэн бичнэ. Үүнд тухайн хүн болон гэр бүлтэй холбоотой хүчин зүйлсээс гадна гэр бүл, олон нийт, цаашлаад нийгмийн зүгээс нөлөөлөх суурь нөхцөлийг мөн адил бичиж тэмдэглэнэ.

“Суурь нөхцөл” ба “нөлөөлөх хүчин зүйлс”-ийн ялгаа нь дараах байдлаар илэрнэ. “Суурь нөхцөл”-д гэр бүлийн бүтэц, ядуурал, бүс нутгийн онцлог шинж чанар зэрэг өөрчлөхөд хүндрэлтэй хүчин зүйлсийг багтаан бичнэ.

Нөгөө талаас, “нөлөөлөх хүчин зүйлс”-ийн хүрээнд дэмжлэг, туслалцааны үр дүнд өөрчлөх боломжтой хүчин зүйлсийг тэмдэглэнэ. Мөн орчны давуу тал, эерэг шинж чанаруудыг нөлөөлөх хүчин зүйлст хамруулан авч үзэх шаардлагатай.

Дөрөвдүгээр алхам: Асуудал, хүндрэл болон суурь нөхцөлд нөлөөлж буй гол шалтгаанууд юу вэ?

Зөвхөн одоогийн бодит нөхцөл байдалд төдийгүй суурь нөхцөлд ч нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлно. Тулгамдсан асуудал, зорилтуудад шууд нөлөөлж буй хүчин зүйлс болон суурь нөхцөлийг өөрчлөх замаар шууд бус байдлаар нөлөөлж буй хүчин зүйлсийг ялган ангилж тэмдэглэнэ.

Тавдугаар алхам: Нөлөөлөх хүчин зүйлсэд өөрчлөлт авчрах ямар арга зам (стратег) байна вэ?

Нөлөөлөх хүчин зүйлсийг өөрчилж чадах дэмжлэг туслалцааны практик үйл ажиллагааг тодорхойлно. Ингэхдээ өөрчлөх боломжтой хүчин зүйлс дээр голлон анхаарч, дэмжлэг хэрхэн үзүүлэх талаар аль болох нарийвчлан бичнэ. Харин өөрчлөхөд хүндрэлтэй хүчин зүйлсийг авч үзэхдээ, тэдгээрийг хэвээр үлдээх эсэх, эсвэл өөр арга барил хэрэглэх, нөхцөл байдалд арай өөр өнцгөөс хандах замаар шууд бус өөрчлөлтийг бий болгохыг зорих уу гэдгийг нухацтай судална.

Үүний тулд тухайн хүчин зүйлийг өөрчлөх боломжтой юу, өөрчлөх боломжгүй юу, эсвэл өөрчлөх боломжгүй байсан ч ямар нэгэн арга хэмжээ авах шаардлагатай юу гэдгийг урьдчилан харж дүгнэлт хийх хэрэгтэй болно.

Үзүүлэх дэмжлэгийн төрлийг ойлгомжтой, тодорхой байдлаар илэрхийлнэ. Ерөнхий, бүдэг утгатайгаар бичихээс зайлсхийж, хэн бүхэнд ойлгомжтой хэллэг ашиглах нь зүйтэй.

Зургаадугаар алхам: Тухайн дэмжлэг туслалцааг ямар үндэслэл, нотолгоонд суурилан хэрэгжүүлж байна вэ?

Үйл ажиллагааг дэмжих үндэслэл болох холбогдох онол, өмнөх судалгааны үр дүн, дэмжлэгийн арга хэрэгслүүдийг жагсаан бичиж, тухайн дэмжлэг нь яагаад тохиромжтой бөгөөд үр дүнтэй байгааг тайлбарлана.

Эдгээр зургаан алхмыг хэрэгжүүлсний дараа, цаашид логик дараалалтай, тасралтгүй хэрэгжих боломжтой, чанартай практик үйл ажиллагааг хангах зорилгоор дараах зүйлсийг бусад мэргэжилтнүүдтэй хамтран баталгаажуулна: а) зорилго, үр дүн болон нөлөөлөх хүчин зүйлс тодорхой илэрхийлэгдсэн эсэх; б) зорилгууд нь тохиромжтой бөгөөд хэрэгжих боломжтой эсэх зэрэг болно. Өөрөөр хэлбэл, тодорхой зорилго тогтоож улмаар төлөвлөсөн дэмжлэгийн арга хэмжээнүүд үр дүнтэй болохыг батлах үндэслэл, нотолгоог гаргаж өгөх нь чухал юм.

Жишээлбэл, тусгай дэмжлэг шаардлагатай хүүхэд болон түүний асран хамгаалагчид дэмжлэг үзүүлэх энгийн загварыг эдгээр алхмуудын дагуу боловсруулж үзэцгээе (Зураг 11):

Алхам 1: Зорилго тодорхойлох

Хүүхэд болон асран хамгаалагчид юунд хүрэхийг хүсэж байгаа, мөн ямар үр дүн, ирээдүйн төлөвийг зорьж байгааг 1) Зорилго хэсэгт нэгтгэн тодорхойлно. Эдгээр зорилго нь ихэвчлэн тэдэнд одоо тулгарч буй асуудал, бэрхшээлийн эсрэг буюу эерэг байдлаар өөрчлөн тодорхойлсон хэлбэртэй байдаг. Зөвхөн нүдний өмнө байгаа 2) бодит байдалд анхаарахаас илүүтэйгээр, хүүхэд болон асран хамгаалагчдын урт хугацааны эерэг өөрчлөлтийг тусгасан зорилгуудыг тодорхойлох нь чухал юм.

Тухайлбал, энэхүү жишээн дээр ирээдүйд хүрэхийг хүссэн зорилгуудыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

Урт хугацааны зорилго: “Хүүхэд цэцэрлэгийн (хүүхэд харах үйлчилгээний) орчинд идэвхтэй байж, баяр хөөртэйгөөр бүх үйл ажиллагаанд оролцох боломж нэмэгдэх” “Асран хамгаалагчдын стрессийг бууруулж, хүүхэд асран хүмүүжүүлэх үйл явцыг эерэг, сэтгэл ханамжтайгаар хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх”

Богино хугацааны зорилго: “Хүүхэд үе тэнгийнхэнтэйгээ өөртөө итгэлтэйгээр тоглож сурах” “Асран хамгаалагчдын инээмсэглэл нэмэгдэх” Мөн эдгээр зорилгод хүрэхийн тулд хүлээгдэж буй цаг хугацаа болон зорилгын биелэлтийг үнэлэх аргачлалыг тодорхой, ойлгомжтой байдлаар тусгах шаардлагатай.

Алхам 2: Бодит байдлыг тодорхойлох

Одоогийн нөхцөл байдлыг бодитойгоор тодорхойлно. Жишээлбэл, хүүхдийн хувьд “стрессийн түвшин өндөр байх”, “үе тэнгийнхэнтэйгээ тоглоход хүндрэлтэй байх” зэрэг асуудлууд илэрч болно. Харин асран хамгаалагчдын хувьд мөн адил “стрессийн түвшин өндөр байх” нь гол асуудал байж болно.

Алхам 3: Суурь нөхцөл байдлыг судлах

Одоогийн нөхцөл байдалд нөлөөлж буй суурь хүчин зүйлсийг тодорхойлно. Тухайлбал, асран хамгаалагчийн “ажлын өндөр ачаалал, байнгын завгүй байдал”, болон “гэр бүлийн таагүй орчин” зэрэг нөхцөлүүд нь тэдний стрессийн түвшинг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болдог.

“Суурь нөхцөл байдлыг харгалзан үзэхдээ хүүхэд, асран хамгаалагч болон тэдний хүрээлэн буй орчны давуу тал, нөөц боломжийг хамтад нь үнэлэхийн зэрэгцээ дараагийн алхам болох 4) нөлөөлөх хүчин зүйлс болон 5) дэмжих хүчин зүйлсийн уялдаа холбоог мөн адил анхааралтай тооцох хэрэгтэй.

Өгөгдсөн жишээн дээр суурь нөхцөл байдлын хүрээнд хүүхэд хөгжлийн хоцрогдолгүй, анхаарал татахуйц зан үйлийн доголдолгүй бөгөөд өөрийн гэсэн хангалттай чадавх, нөөц боломжтой байгаа нь давуу тал болж байна. Түүнчлэн 2) өнөөгийн бодит нөхцөл байдал болон 3) суурь нөхцөл байдлын харилцан уялдааг нэгдмэл байдлаар ойлгон авч үзэх нь чухал. Энэхүү жишээний 2 болон 3 дугаар алхамтай холбоотой хэсгээс харахад хүүхэд хөгжлийн болон эрүүл мэндийн ямар нэгэн асуудалгүй нь тодорхой байна. Иймд хүүхдийн чадавхыг хөгжүүлэхийн зэрэгцээ асран хамгаалагчдын стрессийг бууруулахад чиглэсэн дэмжлэгийн арга хэмжээг (интервенц буюу мэргэжлийн зорилтот оролцоо бүхий үйл ажиллагааг) хэрэгжүүлэх нь эерэг үр дүнд хүргэх боломжтой.

Суурь нөхцөл байдлын хувьд гэр бүлийн бүтэц, орчин, ядуурал, бүс нутгийн онцлог шинж чанар зэрэг зарчмын хувьд өөрчлөхөд хүндрэлтэй хүчин зүйлсийг системтэйгээр тодорхойлж, нарийвчлан жагсаах нь зүйтэй.

Алхам 4: Нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох

Бодит нөхцөл байдал болон суурь нөхцөлд нөлөөлж буй, эсвэл нөлөөлж болзошгүй хүчин зүйлсийг аль болох нарийвчлан тодорхойлж, системтэйгээр жагсаан бичнэ. Энэ нь дараагийн шатанд хэрэгжүүлэх дэмжлэгийн арга хэмжээг төлөвлөхөд чухал суурь мэдээлэл болдог. Үүнээс гадна 1) зорилго, 2) өнөөгийн нөхцөл байдал, 3) суурь нөхцөл байдал зэрэг үндсэн хэсгүүдийн хамт тухайн улс орны тогтолцоо, орчны онцлогийг харгалзан үзэж, мэдээллийг уялдаа холбоотойгоор нэгтгэн зохион байгуулах нь зүйтэй.

Дээр дурдсан жишээний хүрээнд хүүхэд асрахад хангалттай дэмжлэг үзүүлдэггүй ажлын орчин нь нөлөөлөх гол хүчин зүйлсийн нэг гэж үзэгдэж байна. Үүний улмаас асран хамгаалагчид “ажлын стресс өндөртэй”, мөн “санаа бодлоо хуваалцах хүнгүй байх” зэрэг нөхцөлд орж, цаг хугацаа болон сэтгэл зүйн хувьд боломж бололцоо нь хязгаарлагддаг. Үүнээс шалтгаалан “хүүхэдтэйгээ харилцах харилцаа нь суларч”, цаашлаад “хүүхэд юу ч хийсэн өөртөө итгэлгүй болох нөхцөл байдал” үүсэхэд хүргэж байна.

Алхам 5: Нөлөөлөх хүчин зүйлсийг өөрчлөх боломжтой дэмжлэгийн арга замуудыг тодорхойлох


Нөлөөлөх хүчин зүйлсийг өөрчлөх, сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой дэмжлэгийн үйл ажиллагааны агуулга, хэлбэрийг тодорхойлсон байна. Энэ хүрээнд хүүхдийн өөртөө итгэх итгэл, өөрийгөө үнэлэх үнэлэмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн оролцоог бий болгох, мөн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, ололт амжилтыг бататгах үйл ажиллагааг зохион байгуулахаар тусгаж өгсөн нь хүүхдийг хүчирхэгжүүлэхэд голлох арга хэрэгсэл болж өгсөн байна. Түүнчлэн асран хамгаалагчдын стрессийг бууруулахад чиглэсэн сэтгэл зүйн дэмжлэг болон тэднийг ойлгоход чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар жишээн дээр дурдан оруулсан болно.

Эдгээр дээр дурдсан хүүхэд болон асран хамгаалагчийг дэмжих гурван үндсэн чиглэлийн хүрээнд хийгдэх тодорхой үйл ажиллагаануудыг жагсаалт хэлбэрээр, нарийвчлан системтэйгээр тусгах шаардлагатай.


Алхам 6: Дэмжлэгийн арга замуудыг нотолж баталгаажуулах

Дэмжлэг үзүүлэх арга замуудыг нотолгоонд тулгуурлан баталгаажуулж, тэдгээрийн онолын үндэслэл, үр нөлөөг тодорхойлно. Үүнд, энэхүү номд танилцуулсан бөгөөд үр дүн нь батлагдсан арга хэрэгслүүд болох Хүүхдийн хөгжлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт, Нийгэмшихүйн ур чадварын үнэлгээ, Онцгой анхаарал шаардлагатай хүүхдийг ажиглаж үнэлэх хуудас, Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчны шалгуур үзүүлэлт, болон Байгууллагад суурилсан хүүхэд асран хүмүүжүүлэх орчны индекс зэргийг ашиглах талаар дурдсан болно.

Дээрх алхмуудын дагуу нөлөөлөх хүчин зүйлсийг нотолгоонд суурилсан байдлаар системтэйгээр авч үзсэнээр хүүхэд болон асран хамгаалагчдын суурь нөхцөл байдалд нийцсэн, асуудлыг шийдвэрлэж, тавьсан зорилгодоо хүрэх боломжийг хангасан хүчирхэгжих үйл явцыг дэмжих загварыг боловсруулах бүрэн боломж бүрдэнэ.



Зураг 11. Хүчирхэгжих үйл явцыг дэмжих загвар
(Анхаарал халамж шаардлагатай хүүхэд болон асран хамгаалагчийн жишээн дээр тайлбарлав)



Хүчирхэгжих үйл явцыг дэмжих загвар болон үнэлгээний арга хэрэгслүүдийг ашиглан нөхцөл байдлыг цогцоор нь харах нь хүүхэд, асран хамгаалагч болон орчны эерэг талуудыг нээн илрүүлж, бэхжүүлэх боломжийг бүрдүүлдэг.

Нотолгоонд суурилсан мэдээлэлд тулгуурлан, хүүхэд болон гэр бүлийг халамжлан анхаар ч практик үйл ажиллагаагаа өөртөө итгэлтэйгээр тасралтгүй сайжруулан хэрэгжүүлээрэй.



3. Хүүхдийн хөгжлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт

Хүүхдийн хөгжлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт нь 54,000 хүүхдийн насны онцлог, хөгжлийн динамикийг тодорхойлсон бодит судалгаанд тулгуурласан хөгжлийн стандарт юм. Одоо ашиглагдаж буй хөгжлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд болох Enjoji Child Development Test (Энжожи хүүхдийн хөгжлийн сорил), Denver Developmental Screening Test (Денверийн хөгжлийн скрининг сорил), Kyoto Scale of Psychological Development (Киотогийн сэтгэл зүйн хөгжлийн үнэлгээний сорил)-ийн агуулгад тулгуурлахын зэрэгцээ хүүхэд хамгаалал, боловсролын мэргэжилтнүүдийн хэлэлцүүлгийн үндсэн дээр үнэлгээний хуудасны агуулгыг шинэчлэн боловсруулж, хүүхдийн насыг сараар ангилан дараалуулсан болно. Энэхүү хүүхдийн хөгжлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт (CDS) нь 7 хүртэлх насны хүүхдийн хөгжлийг дараах үндсэн чиглэлүүдээр үнэлэх боломжийг олгодог. Үүнд:

Булчингийн хөгжил: Том болон үзүүрийн жижиг булчингийн хөгжил
Нийгэмшихүйн хөгжил: Нийгмийн чадамж болон харилцааны хөгжил
Хэл ярианы ур чадвар: Үгийн баялаг болон оюуны хөгжил зэрэг болно.

Үнэлгээний хуудсыг бөглөхдөө үнэлгээ хийж буй хүн тухайн хүүхдийн насанд хамгийн ойр хэсгийг сонгон авч бөглөнө. Үзүүлэлт бүр дээр хүүхэд тухайн үйлдлийг бодитоор хийж чадаж байвал “О”, чадахгүй байвал “✓” гэж тэмдэглэнэ.

Үнэлгээ хийж буй хүн дараалсан 3 удаа “✓” тэмдэг илрэх хүртэл насны ангиллыг дээшлүүлэн үргэлжлүүлнэ. Үүний дараа дээшлэх хөдөлгөөнийг зогсоож, буурах чиглэлд шилжин шалгана. Үнэлгээний явцад дундаа тасалдалгүй 3 дараалж “О” тэмдэг гарсан тохиолдолд үнэлгээг бүрэн дуусгаж зогсооно.

Энэхүү хөгжлийн үнэлгээ нь хүүхдийн хөгжлийн онцлогийг чиглэл бүрээр тодорхойлох боломжийг олгодог. Жишээлбэл, хүүхдийн том булчин болон үзүүрийн жижиг булчингийн хөгжил хэвийн боловч хэл яриаг ойлгох чадвар сул байгааг илрүүлж болно. Ингэснээр тухайн хүүхдийн хөгжлийн түвшинг тухайн насны бусад хүүхдүүдтэй харьцуулан бодитойгоор тодорхойлохын зэрэгцээ энэхүү үнэлгээг өдөр тутмын практик үйл ажиллагаандаа үр дүнтэй хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Хүүхдийн хөгжлийн үнэлгээ нь хүүхдийн боломжит чадавх болон өдөр бүр өөрчлөгдөж байдаг одоогийн хөгжлийн түвшнийг таньж мэдэхэд туслах үндсэн чиглүүлэгч удирдамж болж өгдөг.

Үнэлгээг тухайн хүүхдийн насанд (сараар) хамгийн ойр ангиллаас эхлүүлнэ.
Жишээлбэл, хүүхэд 2 нас 1 сартай бол 2 настай хүүхдийн ангиллаас, хэрэв 2 нас 2 сартай бол 2 нас 3 сартай хүүхдийн ангиллаас эхлүүлэн үнэлгээг хийнэ.


4:00	Нэг хөл дээрээ хэд хэдэн удаа догонцон үсрэх ✓	Хайчаар зураасын дагуу зөв хайчилж чадна ✓	Тусламжгүйгээр биеэ угаадаг (биеийн бүх хэсгийг заавал гүйцэд угаахгүй байж болно) ✓	Том хүнд хаашаа явахаа хэлж чадна ✓
3:09	Байрнаасаа урагш хол үсэрдэг ✓	Хэрээс хэлбэрийн дүрсийг дуурайн зурах гэж оролддог ✓	Нусаа нийж чадна ✓	Бүлгээрээ байхдаа (тоглохдоо) өөрийн ээлжийг хүлээдэг ✓
3:06	Гурван дугуйтай унадаг дугуй унадаг ✓	Шидэж өгсөн бөмбөгийг хоёр гараараа барьж авдаг ✓	Гараа өөрөө угааж, арчиж чаддаг	Тоглоомоо бусдад зээлдүүлж, бусдаас зээлж авч чаддаг
3:03	Чигээрээ урагшаа (эсвэл арагш) өнхөрч чадна	Жижиг товчийг (ойролцоогоор 1 см) бие даан товчилдог	Нүүрээ бие даан угааж, арчиж чадна	Ямар нэгэн зүйл хийхдээ (бусдын эд зүйлийг авахдаа) зөвшөөрөл авдаг
3:00	Нэг хөл дээрээ хэдэн секундын турш тэнцвэрээ олж зогсдог	Хайчаар цаас хайчилж чаддаг	Гадуур хувцас (хүрмээ) тусламжгүйгээр тайлдаг	“Айл гэр” болох гэх мэтээр дүрд хувирч тоглодог
2:09	Өсгий дээрээ зогсоод эргэдэг (заавал бүтэн эргэх албагүй)	Дугуй дүрсийг дуурайж зурдаг	Үдээсгүй гутлыг бие даан өмсдөг	Өөрөөсөө дүү хүүхдүүдийг халамжлах, анхаарал тавих хандлага гаргадаг
2:06	Шатаар өгсөхдөө хоёр хөлөө ээлжлэн алхаж өгсдөг	Шулуун зураас дуурайлган зурж чаддаг	Хоолоо асгаж цутгалгүйгээр бие даан иддэг	Хүүхдүүд хоорондоо муудалцсан талаар насанд хүрэгчдэд хэлж мэдэгддэг
2:03	Хоёр хөл дээрээ үсэрч чаддаг	Төмөр турникнээс гараараа зуурч, хэдэн секундын турш зүүгддэг	Өмдөө бие даан тайлж чаддаг	Утасаар ярьж буй мэт үйлдлийг дуурайж тоглодог
2:00	Бөмбөгийг урагш өшиглөдөг	Тоглоомон шоог дараалуулан зэрэгцүүлж өрдөг	Бие засах хэрэгцээгээ бусдад хэлж илэрхийлдэг	Эцэг эх нь дэргэд нь байхгүй байсан ч ганцаараа саатан тоглодог

Зураг 12. Хүүхдийн хөгжлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт

4. Нийгэмшихүйн ур чадварын үнэлгээ

Хүүхдийн бусадтай харилцах ур чадварын хөгжлийг нийгэмшихүйн ур чадварын үнэлгээний шалгуурын тусламжтайгаар тодорхойлж болно. Нярай болон бага насны хүүхдийн нийгэмшихүйн ур чадварыг үнэлснээр тухайн хүүхдийн хөгжлийн түвшинг нийтлэг стандарт хөгжлийн үзүүлэлттэй харьцуулан тодорхойлох боломжтой.

Нийгэмшихүйн ур чадварын үнэлгээ нь хүүхдийн онцлогийг өөрийгөө илэрхийлэх чадвар, өөрийгөө хянах чадвар, хамтран ажиллах чадвар гэсэн гурван үндсэн чиглэлээр авч үздэг бөгөөд



эдгээр нь олон улсын судалгаанд өргөн хэрэглэгддэг үндсэн үзүүлэлтүүд юм. “Өөрийгөө илэрхийлэх чадвар” нь бусадтай харилцах явцад нүдээрээ холбоо тогтоох, зохистой байдлаар мэндлэх, ярилцаж байх үедээ харц тулгарах зэрэг зан үйлээр илэрхийлэгддэг. Харин “Өөрийгөө хянах чадвар”-т олон нийтийн орчинд уур бухимдлаа илэрхийлэхгүй байх, өөрийн ээлжийг хүлээх, бусдаас тоглоомыг нь зөвшөөрөлтэйгөөр авах зэрэг үйлдлүүд багтаж болно.

“Хамтран ажиллах чадвар”-т ганцаардсан мэт харагдах найзуудаа дэмжих, хүссэн үед нь бусдад туслах, мөн тусламж хүсээгүй байсан ч бусдад санаачилгатайгаар туслах зэрэг зан үйлүүд багтана.


Тухайн хүүхдийн өдөр тутмын амьдралыг хамгийн сайн мэддэг мэргэжилтнүүд энэхүү шалгуур хуудсыг бөглөх хэрэгтэй. Хэрэв хүүхдэд тухайн зан үйл тогтмол ажиглагддаг бол “үргэлж”, бараг харагддаггүй бол “хэзээ ч үгүй”, харин зарим тохиолдолд л илэрдэг бол “заримдаа” гэж тэмдэглэнэ.

Шалгуур тус бүрийн агуулгад нийцсэн дэлгэрэнгүй үзүүлэлтүүдийг “Нийгэмшихүйн ур чадварын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ээс (Хавсралт 2) харна уу.

5. Онцгой анхаарал шаардлагатай хүүхдийг ажиглаж үнэлэх хуудас

Онцгой анхаарал шаардлагатай хүүхдийг ажиглаж үнэлэх хуудас нь хүүхдийн ерөнхий төлөв байдлыг цогцоор нь ойлгох, тухайн хүүхдэд тусгайлан дэмжлэг үзүүлэх шаардлагатай эсэхийг тодорхойлоход ашиглагддаг үнэлгээний арга юм. Тус үнэлгээний үр дүнг хүүхдэд шаардлагатай дэмжлэг үзүүлэхэд шууд ашиглах боломжтой байдлаар боловсруулсан болно (Хавсралт 3-ыг үзнэ үү). Энэхүү шалгуур нь 36 үзүүлэлтээс бүрдэх бөгөөд үнэлгээ хийж буй үнэлээч нь тодорхой жишээнүүдийг тэмдэглэж авахын зэрэгцээ шалгуур үзүүлэлт бүртэй холбоотой суурь хүчин зүйлсийг нэг бүрчлэн харгалзан үзсэнээр хүүхдийн нөхцөл байдлыг улам илүү нарийвчлан үнэлэх боломжтой.

Шалгуур үзүүлэлтүүдийг хүүхдийн хөгжлийн дарааллын дагуу эрэмбэлсэн бөгөөд нэгдүгээрт хөгжлийн хоцрогдол, хоёрдугаарт стандарт хөгжлөөс хазайсан шинж тэмдэг, гуравдугаарт асран хамгаалагчдын зүгээс ойлгож мэдэхгүй байгаа шинж тэмдгүүдийг үнэлэхэд чиглэгдсэн болно (Зураг 13).



Зураг 13. Тусгай анхаарал шаардлагатай хүүхдийг ойлгох зураглал: Гурван талт хандлага

6. Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчны шалгуур үзүүлэлт

Хүүхэд асрах орчныг үнэлэх энэхүү шалгуурыг АНУ-д анх боловсруулсан бөгөөд өдгөө дэлхийн 100 гаруй оронд ашиглаж буй HOME (Home Observation for Measurement of the Environment) буюу “Хүүхдийн гэрийн орчныг ажиглаж үнэлэх аргачлал”-д суурилан хөгжүүлсэн болно. Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчны шалгуур үзүүлэлт нь дээрх аргачлалаас 13 заалтыг суурь болгон авахын зэрэгцээ хүүхэд өсгөн хүмүүжүүлэх талаарх эцэг эхийн ухамсар болон хүүхдийн дасан зохицох чадварыг шалгах шинэ шалгуур үзүүлэлтүүдийг нэмж баяжуулснаар нийт 6 хэсэг, 15 үзүүлэлт бүхий үнэлгээний шинэ хувилбарыг гаргаж авсан юм (дэлгэрэнгүйг номын төгсгөлд буй Зураг 14, Хавсралт 4-өөс үзнэ үү). Энэхүү үнэлгээг хүүхдийн асран хамгаалагч бөглөх бөгөөд ингэснээр хүүхдийн өдөр тутмын гэр бүлийн орчны талаар ойролцоогоор таван минутын дотор ерөнхий ойлголт, үнэлэлт авах боломж бүрдэнэ. Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчны шалгуур үзүүлэлт нь дараах бүтэцтэй байна:

Ангилал	Шалгуур үзүүлэлт
1. Хүмүүс хоорондын харилцан үйлчлэл	① Та хүүхэдтэйгээ хэр их тоглодог вэ? (хүүхэдтэйгээ хамт байж нүүр тулан харилцан тоглох)
	② Та хүүхдэдээ ном уншиж өгдөг үү?
	③ Та хүүхэдтэйгээ хамт хэр их дуу дуулдаг вэ?
	④ Таны хань, хамтран амьдрагч эсвэл хүүхэд асрагч гэх мэт хүмүүс таныг хүүхдээ асрах, хүмүүжүүлэхэд хэр их тусалдаг вэ?
	⑤ Таны хүүхэд эцэг эхтэйгээ хамт хооллох давтамж хэр байдаг вэ?

2. Хэт хориглох, шийтгэхээс зайлсхийх	⑥ Таны хүүхэд зориуд сүү асгавал та ямар хариу үйлдэл үзүүлдэг вэ?
	⑦ Та өнгөрсөн долоо хоногт хүүхэддээ хэдэн удаа гар хүрсэн / цохисон бэ?
3. Нийгмийн орчны нөлөөлөл	⑧ Та хүүхэдтэйгээ хамт хэр их дэлгүүр явдаг вэ?
	⑨ Та хүүхэдтэйгээ салхинд (парк/цэцэрлэгт хүрээлэн гэх мэт) хэр их гардаг вэ?
	⑩ Та хүүхдээ үе тэнгийнх нь хүүхдүүдтэй тоглуулахаар найз нөхөд, хамаатан садныхаараа хэр зэрэг очдог вэ?
4. Нийгмийн дэмжлэг	⑪ Танд хүүхдээ өсгөхөд хэн нэгэн тусалдаг уу?
	⑫ Танд хүүхэд асрах, өсгөх талаар зөвлөлдөх хүн байдаг уу?
	⑬ Танд хүүхдийнхээ талаар ханьтайгаа/хамтрагчтайгаа ярилцах боломж хэр зэрэг гардаг вэ?
5. Хүүхэд асрах талаарх ойлголт, хандлага	⑭ Хүүхэд асрах, өсгөхөд өөртөө итгэх итгэл
6. Хүүхдийн дасан зохицох байдал	⑮ Хүүхэд цэцэрлэгийн орчинд дасан зохицож буй байдал

Зураг 14. Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчны шалгуур үзүүлэлт

(1) Хүмүүс хоорондын харилцан үйлчлэл

Хүүхэд өдөр тутмын амьдралдаа асран хамгаалагчаас гадна бусад хүмүүстэй өргөн хүрээтэй, олон талт, үр өгөөжтэй харилцаанд орж байгаа эсэхийг энэ хүрээнд тодорхойлно. Хүүхдийн хөгжил орчинтойгоо харилцах үйл явцаар дамжин бүрэлддэг тул гэр бүлийн гишүүд болон ойр дотно хүмүүстэйгээ хамт хооллох, тоглох, ном унших боломжтой эсэхийг үнэлэх нь чухал юм. Цаашилбал, асран хамгаалагч ажлын өдрүүдэд завгүй байсан ч амралт, баярын өдрүүдээр хүүхэддээ ухамсартайгаар цаг гаргаж, чанартай харилцаа үүсгэж чадаж буй эсэхийг нягтлах шаардлагатай.

(2) Хэт хориглох, шийтгэхээс зайлсхийх

Хэдийгээр асран хамгаалагчид хүүхэдтэйгээ харилцах боломж их байвч тухайн харилцаа нь сөрөг шинжтэй, тухайлбал хүүхдийг цохиж зодох, хэл амаар доромжлох зэрэг үйлдэл агуулсан бол хүүхдийн хөгжилд үлэмж сөрөг нөлөө үзүүлдэг. Иймд гэр бүлийн орчинд энэ төрлийн таагүй харилцаа байгаа эсэхийг урьдчилан илрүүлж, нарийвчлан тодорхойлох хэрэгтэй.

(3) Нийгмийн орчны нөлөөлөл

Гадаа орчин нь хүүхдэд дотор орчноос авч чадахгүй шинэ өдөөлт, баялаг туршлагыг олгодог. Ялангуяа бага насны хүүхдүүд бие даан гадагш гарах боломж ховор байдаг тул асран хамгаалагчид хүүхэдтэйгээ хамт дэлгүүр явах,

цэцэрлэгт хүрээлэнд очих зэргээр бусадтай харилцах боломжийг зориудаар бүрдүүлэх нь нэн чухал юм. Энэ хүрээнд хүүхдийн нийгэмших харилцааны төрөл, давтамжийг тодорхойлно.

(4) Нийгмийн дэмжлэг

Хүүхэд өсгөж буй эцэг эхэд хүүхэд асрах үүрэг хариуцлагыг нь хуваалцах хань ижил, эсвэл ойр дотно хэн нэгэн байх нь маш чухал юм. Энэ нь эцэг эхийг хүүхдээ хараад гэртээ ганцаараа нийгмээс тусгаарлагдаж, ядарч туйлширахаас сэргийлдэг хамгийн гол хүчин зүйл болдог. Асран хамгаалагчид хүүхэд өсгөх явцад тулгарсан асуудлаа хэн нэгэнтэй ярилцаж зөвлөлдөх, эсвэл шууд тусламж дэмжлэг авах хүн байгаа эсэхийг энд тодорхойлно.

(5) Хүүхэд асрах талаарх ойлголт, хандлага

Хүүхэд өсгөж хүмүүжүүлэхдээ өөртөө үргэлж итгэлтэй байх нь амаргүй боловч тулгарч буй асуудал, мэдрэмжээ байгаагаар нь хүлээн зөвшөөрч ойлгосноор хүүхэд асрах үйл явц илүү баяр баясгалантай, таатай болдог. Энэ хэсэгт асран хамгаалагчийн хүүхэд асрахтай холбоотой ойлголт, ухамсар, хандлагыг нарийвчлан үнэлнэ.

(6) Хүүхдийн дасан зохицох байдал

Хүүхэд цэцэрлэгтээ явах дургүй байх нь асран хамгаалагчдад, ялангуяа ажил болон гэр бүлийн амьдралаа зохицуулахыг зорьж буй хүмүүс, эсвэл түр амсхийхийг хүсэж буй эцэг эхчүүдэд хүүхэд асрахтай холбоотой зовнилыг бий болгодог. Асран хамгаалагчийн зүгээс хүүхэд нь цэцэрлэгтээ хэр зэрэг дуртай, сэтгэл хангалуун явж байгааг энэ хэсэгт үнэлнэ.

Судалгааны үр дүнгээс үзэхэд хүүхэд өсөж хөгжиж буй орчны чанар нь тэдний эрүүл мэнд, хөгжил болон зан харилцаанд онцгой нөлөө үзүүлдэг болохыг тогтоосон байна.



Мэргэжилтэн хүн хүүхэд болон эцэг эхийн эргэн тойрон дахь амьдралын олон талт орчныг бүхий л талаас нь, аль болох бүрэн дүүрэн судалж, таньж мэдсэн байх шаардлагатай.

7. Байгууллагад суурилсан хүүхэд асран хүмүүжүүлэх орчны индекс

Хүүхдийн эрүүл, зохистой өсөлт хөгжилд эерэг нөлөө үзүүлэхүйц хүүхэд хүмүүжүүлэх орчныг тодорхойлох зорилгоор хүүхдийн хөгжил, хамгаалал, хүмүүжлийн салбарын 4,000 гаруй мэргэжилтний санал, үзэл бодлыг нэгтгэн, энэхүү “Байгууллагад суурилсан хүүхэд асрах орчны индекс”-ийг боловсруулсан болно (Номын төгсгөл дэх Хавсралт 5-аас дэлгэрэнгүйг үзнэ үү).

Энэхүү үнэлгээний аргачлал нь дараах үндсэн дөрвөн чиглэлийн хүрээнд боловсруулсан үзүүлэлтүүдийг агуулна. Үүнд:

1. Хүүхдийн талаарх дэлгэрэнгүй, цогц ойлголт авах
2. Гэр бүлийн нөхцөл байдлын талаарх цогц ойлголт бүрдүүлэх
3. Хүүхдэд ээлтэй, таатай орчныг бүрдүүлэх
4. Холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх

Эдгээр тулгуур чиглэлд үндэслэн практик үйл ажиллагааны зохистой байдлыг үнэлэх, хянах нийт 471 үзүүлэлтийг жагсаасан бөгөөд тэдгээрийн нарийвчилсан агуулгыг доор дурдсан болно:

(1) Хүүхдийн талаарх дэлгэрэнгүй ойлголт авах

Энэ хэсэгт хүүхэд цэцэрлэгт элсэх үеийн болон өдөр тутмын амьдралтай нь холбоотой дараах үзүүлэлтүүд багтана: ① Суурь үзүүлэлтүүд (хүүхдийн өсөлт хөгжлийн явц, өвчин эмгэг, биеийн ердийн халуун гэх мэт), ② хүүхдийн хөгжилтэй холбоотойгоор ажиглалтаар дамжуулан суралцах үйл явц, ③ хүүхдийн эрх хамгаалалтай холбоотой асуудлууд орно.

Түүнчлэн, урт хугацааны хүүхэд асрах үйлчилгээг зохих ёсоор үзүүлэхийн тулд амьдралын зөв хэмнэл, өдөр тутмын дадлыг олж тогтоох зорилгоор хүүхдийн унтах хугацаа, сэрэх цаг зэрэг нарийвчилсан үзүүлэлтүүдийг мөн багтаасан болно.

(2) Гэр бүлийн нөхцөл байдлын талаарх цогц ойлголт бүрдүүлэх

Эдгээр үзүүлэлтүүд нь хүүхэд цэцэрлэгт элсэх үе болон хүүхдийн өдөр тутмын амьдралтай холбоотой гэр бүлийн бүхий л нөхцөл байдлыг цогцоор нь хамарч буйгаараа онцлог шинжтэй бөгөөд дараах дөрвөн үндсэн хэсгээс бүрдэнэ: ① Элсэлтийн ярилцлага, зөвлөгөө (Хүүхдийг цэцэрлэгт элсэх үед мэргэжилтний зүгээс хийх ганцаарчилсан ярилцлага, зөвлөгөө) ② Гэр бүлийн суурь тодорхойлолт (Гэр бүлийн бүтэц, бүрэлдэхүүн болон гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг нарийвчлан тогтоох) ③ Гэр бүлийг танин мэдэх, ойлгох (Гэр бүлийн гишүүдийн хүүхэд асрах үйл явц дахь оролцоо болон тэдэнд тулгарч буй гол асуудал, хэрэгцээг тодорхойлох) ④ хүүхдийн эрх, хамгаалалтай холбоотой мэдээлэл багтана.

Үүний зэрэгцээ, урт хугацааны хүүхэд асрах, хүмүүжүүлэх үйл ажиллагааг харгалзан, гэр бүлийн зүгээс дэмжлэг авах хэрэгцээ шаардлагатай холбоотой үзүүлэлтүүдийг багтаасан болно. Үүнд: шөнийн цагаар яаралтай үед холбоо барих мэдээлэл, болон асран хамгаалагчаас гадуур хүүхдийг цэцэрлэгээс авах боломжтой хүмүүсийн мэдээлэл зэрэг асуудлууд орно.


(3) Хүүхдэд ээлтэй, таатай орчныг бүрдүүлэх

Энэхүү үзүүлэлтээр хүүхдийн сурч, хөгжихөд тохиромжтой асран хамгааллын орчныг бүрдүүлсэн эсэх, мөн хүүхдийн дээд ашиг сонирхол хамгаалагдаж буй эсэх зэрэг орчны хүчин зүйлс болон хамгаалалтын асуудлыг авч үздэг. Хүүхэд тухайн орчинд тав тухтай, амар амгалан байх боломжтой эсэх, мөн гэмт хэрэг, байгалийн гамшиг, гэнэтийн осол болон яаралтай нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах зэрэг биет орчны хүчин зүйлсээс гадна дараах үндсэн ангиллуудыг багтаасан болно. Үүнд: 1) Хүүхэд асран хүмүүжүүлэх орчин (Орчин нөхцөл нь хүүхдийн нас, хөгжлийн онцлогт нийцсэн эсэхийг үнэлж, шалгах), 2) Хүүхдийн эрх, хамгаалал (Хүүхэд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг нь хүндэтгэж байгаа эсэхийг үнэлнэ), 3) Хүний нөөцтэй холбоотой орчин (Хүүхэд асрах үйл явц дахь мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг хангах, мөн тэдний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдах боломжийг үнэлж, шалгах).

Урт хугацааны хүүхэд асрах үйлчилгээний чанар, хүртээмжийг хангах үүднээс “Олон цагаар ашиглах боломжтой хүүхэд асрах орчин, орон зайг бүрдүүлэх”, “Усанд орох, бие засах/шүршүүрийн нөхцөлийг хангах”, “Гаднаас ирсэн зочдыг хаалганы дотуур холбооны (интерком/домофон) төхөөрөмжөөр шалгах боломжтой эсэхийг үнэлэх”, “Улирал болон орон нутгийн онцлогийг харгалзан оройн цагийн үйл ажиллагааг зохион байгуулах”, “Эцэг эх, асран хамгаалагчдад тохиромжтой цагт уулзалт, арга хэмжээ, спортын үйл ажиллагааг зохион байгуулж байгаа эсэхийг шалгах” зэрэг нарийвчилсан үзүүлэлтүүдийг давхар тусгаж өгсөн болно.

(4) Холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх

Холбогдох байгууллагуудын зорилго, үйл ажиллагааны талаарх мэдээлэл, ажил үүрэг, хариуцлагын хуваарилалт, мөн хүүхэд болон түүний гэр бүл холбогдох байгууллагуудтай зохистойгоор холбогдох, тэднийг холбон зуучлах боломж бүрдсэн эсэхийг энэ хэсэгт үнэлнэ. Үнэлгээний явцад дараах хоёр үндсэн ангиллыг харгалзаж үзнэ: ① Хамтын ажиллагааны сүлжээ үүсгэх (Хүүхэд болон түүний гэр бүлд илүү чанартай эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор бусад мэргэжилтэн, оршин суугчид, орон нутгийн байгууллага, үйлчилгээний газруудтай хамтын ажиллагааны сүлжээг бий болгох), ② Эрх хамгаалал (Дээрх хамтын ажиллагаа, түншлэлийн сүлжээг өргөжүүлэхтэй холбоотойгоор хүүхэд, гэр бүлийн эрхийг хамгаалах) асуудлыг тусгасан болно.



Хүн бүрийн гадаад төрх, зан чанар өөр хоорондоо ижилгүй байдгийн адил тэдний өсөлт хөгжилтөд ч хувийн онцлог, хувь хүний ялгаатай байдал ажиглагддаг. Иймээс хүн бүр өөрийн давуу талаа улам бүр тордож, хөгжүүлэх боломжийг олгох нь нэн чухал юм.

Оролцоог нэмэгдүүлж боломжоор дүүрэн ертөнцийг бүтээх нь

Хүн төрөлхтөн амьдралынхаа туршид тасралтгүй өсөн хөгжсөөр байдаг бөгөөд энэхүү хөгжил нь амьдралын бүхий л үе шатанд тасралтгүй өрнөж байдаг. Хүн хөгжлийн явцад хүрээлэн буй орчинтойгоо идэвхтэй болон идэвхгүй байдлаар харилцан үйлчилж, уялдан өөрчлөгддөг. Орчинтойгоо байнгын харилцан үйлчлэлд орж, шинэ боломжуудыг нээн илрүүлж, амьдралынхаа туршид хуримтлуулсан арвин их туршлагаа өөртөө шингээж авах нь хүнийг онцгой, давтагдашгүй нэгэн болгодог гол хүчин зүйл юм. Ийнхүү тасралтгүй хувьсал, өөрчлөлт дунд явагдах хөгжлийн энэхүү үйл явцыг насан туршийн **хөгжлийн динамик хөдөлгөөн** гэж нэрлэдэг.

Хувь хүн болон мэргэжилтнүүд нь хүний хөгжлийн динамик хөдөлгөөний хүрээнд харилцан үйлчлэл, хамтран ажиллаагаар дамжин хамтдаа хөгждөг. Ялангуяа мэргэжилтнүүд нь хувь хүнийг дэмжиж, ирээдүйн зорилгодоо хүрэх замыг тэдэнд нээж өгөх замаар амьдралын турш хөгжих тулгуур болж өгдөг. Хүчирхэгжих үйл явцыг дэмжин ажилладаг мэргэжилтнүүд хувь хүнд өөрийн чадвар, боломжоо бүрэн дайчлах нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ нь улмаар тухайн хүнд амьдралын баяр баяслыг мэдрүүлдэг.

Хүний насан туршийн хөгжил нь **уян хатан чанар**, амьдралын олон янзын туршлага, **ялгаатай байдал** болон тэдгээрийн нэгдэл дээр оршин тогтдог. Учир нь өөрийгөө болон орчноо өөрчлөхийн тулд хүнд дасан зохицох уян хатан чанар хэрэгтэй байдаг. Энэхүү чанар нь амьдралдаа олон өөр хүмүүстэй уулзах, янз бүрийн үйл явдалтай тулгарах тусам улам бүр хөгжиж, гүнзгийрдэг байна. Ийнхүү цаг хугацааны явцад гарсан бүхий л өөрчлөлтүүд хоорондоо уялдан нэгдсэнээр хүний хөгжлийн цогц үйл явц бүрэлддэг.

Нотолгоонд суурилсан мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхийн тулд дараах гурван үндсэн зүйл чухал үүрэгтэй:

Нэгдүгээрт, мэргэжилтнүүд үйл ажиллагаагаа байнга сайжруулахыг зорин ажиллах шаардлагатай. Энэ нь суралцах үйл явц төгсгөл үгүй гэдгийг илтгэнэ. Дэлхий ертөнц үргэлж хувьсан өөрчлөгдөж байдгийн адил хүмүүсийн хэрэгцээ, сэтгэлгээ ч мөн даган өөрчлөгддөг. Тархи судлал болон генетикийн шинжлэх ухааны салбаруудын сүүлийн үеийн судалгааны үр дүнгээр өмнө нь мэдэгдээгүй байсан олон шинэ нээлт, баримтууд илэрсээр байна. Иймээс шинэ мэдлэг, технологийг тасралтгүй сурч мэдэж, практик үйл ажиллагаандаа зөв, зохистой хэрэгжүүлэх хандлагыг төлөвшүүлэх нь чухал юм.

Хоёрдугаарт, аливаа зүйлийн жинхэнэ мөн чанарыг эрхэмлэн дээдлэхэд чиглэсэн хүчирхэгжих сэтгэлгээг төлөвшүүлэх нь чухал. Энэхүү сэтгэлгээ нь янз бүрийн ажил, даалгавар гүйцэтгэх явцдаа өөрийгөө эрч хүчтэй, хүчирхэгжиж байгааг мэдрэхэд оршино. Амьдралд бид баяр баясал болон зовлон бэрхшээлтэй тулгарч байдаг. Хэдийгээр хүн хүнд хэцүү нөхцөл байдалд орсон ч чин сэтгэлийн аз жаргалыг мэдрэх мөчүүд бидэнд бас тохиолддог. Хүн бүр энэ хорвоод давтагдашгүй онцлогтой бөгөөд орчлон ертөнцөд бүх зүйл тасралтгүй өөрчлөгдөж байдаг нь маргаангүй үнэн юм.

Амьдралд өгсөлт, уруудалт үргэлж ээлжилдэг. Бид энэхүү зүй тогтлыг хүлээн зөвшөөрч, улмаар уян хатан чанарт тулгуурласан хүчирхэгжих сэтгэлгээг өөртөө болон эргэн тойрныхондоо төлөвшүүлэх нь чухал юм.

Гуравдугаарт, мэргэжилтнүүд болон олон нийтийн төлөөлөл гэх мэт холбогдох талуудтай хамтын ажиллагааг эрхэмлэн хөгжүүлэх хэрэгтэй. Хүн хичнээн их хичээсэн ч ганцаараа энэ орчлонд бусдын оролцоогүйгээр амьдрах боломжгүй. Харин хүн бүрийн давуу тал, хүч чадлыг нэгтгэснээр ганцаараа туулахад бэрх, хүнд хэцүү орчин нөхцөлийг ч хамтдаа даван гарах боломж бүрдэнэ.

Хувь хүний хүчирхэгжих байдлыг дэмжихийн тулд зөвхөн хувь хүний түвшинд бус, **хамт олон, олон нийт, нийгмийн болон тогтолцооны (системийн) түвшинд үйл явцыг** цогцоор нь авч үзэх нь чухал юм. Энэ бүх харилцан уялдаатай үйл явцыг **хүчирхэгжих үйл явцын динамик загварын** хүрээнд ойлгож, хэрэгжүүлнэ.

Хүчирхэгжих үйл явцыг бий болгохын тулд бид эхлээд “Бидний эргэн тойрон дахь хүмүүс юуг эрхэмлэн дээдэлдэг вэ?”, “Тэдэнд ямар хэрэгцээ шаардлага байна вэ?”, “Би тэдэнд юугаар тусалж чадах вэ?” хэмээн эргэцүүлэн бодох хэрэгтэй. Хамт олон болон эргэн тойрныхонтойгоо харилцаа холбоо тогтоосноор бид эдгээр хэрэгцээ шаардлагыг нэг баг болон хамтдаа шийдвэрлэх боломжтой. Дэмжлэг үзүүлэх, бусдаас тусламж хүлээн авах нь **харилцан бие биедээ туслах, харилцан хүндэтгэх** зарчимд тулгуурладаг бөгөөд бид энэхүү үнэт зүйлийг эрхэмлэсэн **баг хамт олон, хамтын ажиллагааг** төлөвшүүлэх нь зүйтэй.

Бид бүхэн хүчирхэгжсэнээр илүү хүртээмжтэй, боломж бололцоогоор дүүрэн ертөнцийг хамтдаа цогцлооно гэдэгт итгэлтэй байна.



1. Гэр бүлийн таатай орчин нь хүүхдийн хөгжлийн суурь хүчин зүйл юм

Хүүхдийн өсөлт хөгжил нь зөвхөн генетик болон биологийн хүчин зүйлээс шалтгаалдаггүй, харин түүний өсөн торниж буй орчин, ялангуяа эцэг эх, асран хамгаалагчтайгаа харилцах өдөр тутмын харилцаатай салшгүй холбоотой юм. Хүчирхэгжих онолын үүднээс авч үзвэл, гэр бүлийн орчин нь хүүхдийн дотоод нөөц боломжийг нээн илрүүлэх гол суурь болж өгдөг бөгөөд хүүхэд өөрийн амьдралын эзэн байх суурь чадварыг эндээс олж авдаг. Айх аюулгүй, урам зориг дүүрэн, хүүхдийнхээ хөгжлийг ойлгон дэмжсэн, хүндлэн халамжилсан орчин нь бага насны хүүхдийн нийгмийн хөгжил, нийгэмшихүйд эерэг үр дүн үзүүлдэг.

Профессор Токи Анмэ-гийн батласнаар, хүүхдийн хөгжлийн хамгийн тохиромжтой орчин нь эцэг эх, хүүхдийн хоорондын харилцааны чанараар тодорхойлогддог. Энэхүү харилцаа нь хүүхдийн дотоод нөөц боломжийг идэвхжүүлэн, бие даасан, шийдвэр гаргах чадвартай хувь хүн болон төлөвшихөд гол түлхэц болдог.

Эцэг эхийн хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх арга барил нь соёлын хувьд ялгаатай хэдий ч аль ч тохиолдолд зохистой харилцаа нь хүүхдийн нийгэмшихүйн хөгжлийг дэмждэг болохыг олон судалгаагаар тогтоосон байдаг. Орон байр, хоол тэжээл зэрэг материаллаг нөхцөл нь хүүхдийн өсөлтийн суурь боловч, танин мэдэхүй болон сэтгэл зүйн хөгжилд эцэг эхийн харилцааны арга барил илүү шийдвэрлэх үүрэгтэй. Эцэг эх, асран хамгаалагч болон хүүхдийн хоорондын харилцаа хөндийрөх тусам хүүхдийн сэтгэл зүйн хөгжилд үүсэх эрсдэлүүд аажмаар нэмэгдсээр байдаг. Энэхүү хөндийрөл нь хүүхдийн өсөж хөгжих “хүчирхэгжих орон зай”-г хумьж, дотоод нөөц боломжийг нь дарах аюултай юм. Товчхондоо, эцэг эхийн харилцаа хөндийрөх нь хүүхдийн ирээдүйн боломжийг хааж, амьдралын аливаа сорилтыг даван туулах суурийг ганхуулдаг. Тиймээс гэр бүлийн харилцааг эрхэмлэн тордох нь хүүхдэд төдийгүй нийгэмд оруулж буй хамгийн том, хамгийн үнэ цэнтэй хөрөнгө оруулалт юм.

2. Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчныг үнэлэх нь: Онол ба практик ач холбогдол

Бодит амьдрал дээр бидний хүүхдүүд “хүчирхэг иргэн” болон өсөж байна уу, эсвэл үгүй юу гэдгийг хэрхэн таньж мэдэх вэ? Энэ асуултад хариулахын тулд гэр бүлийн орчныг шинжлэх ухаанч байдлаар, тодорхой шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэх шаардлага тулгардаг.

Монгол Улсад хот, суурин газрын хөгжил эрчимжихийн хэрээр нүүдэлчдийн уламжлалт хүмүүжлийн соёл, гэр бүлийн орчин, эцэг эх болон хүүхдийн харилцаанд томоохон өөрчлөлтүүд гарсаар байна. Өнөөгийн нийгмийн хурдтай хэмнэл, шинэчлэл нь хүний амьдралын салшгүй хэсэг болсон эцэг эх, асран хамгаалагч ба хүүхдийн хоорондын нандин холбоонд гүнзгий нөлөө үзүүлж байна. Амьдралын завгүй хэмнэл, санхүүгийн дарамт,

ажил хөдөлмөрийн ачаалал нь эцэг эх, хүүхдийн хамтдаа өнгөрүүлэх “чанартай цаг”-ийг хумиж, дижитал ертөнцийн хязгааргүй хэрэглээ нь тэднийг бие биеэс нь хөндийрүүлэн, хооронд нь үл үзэгдэх хана босгоод байна. Түүнчлэн, хүүхдийг хэт хориглох, шийтгэх хандлага хүмүүжлийн хэв маягт байсаар байгаа нь уламжлалт ухааныг орчин үеийн шинжлэх ухаантай хослуулан шинэчлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Эцэг эх, асран хамгаалагч болон багш нарын эрхэм зорилго бол хүүхдийг зөвхөн дуулгавартай нэгэн байлгах бус, харин өөрийн гэсэн үзэл бодолтой, амьдралын сорилт бүрийг даван туулах чадвартай “хүчирхэг иргэн” болгон төлөвшүүлэх явдал юм. Энэхүү өөрчлөлт нь эцэг эх, асран хамгаалагчид өөрсдийн харилцааны арга барилаа “хориглогч” байр сууринаас “дэмжигч” болгон хувиргахаас эхлэх учиртай.

Асран хамгаалагчид өөрсдийн харилцааг бодитойгоор тольдон харж, хүүхдийнхээ хөгжилд яг юун дээр анхаарах ёстойгоо олж мэдэх нь нэн чухал юм. Энэхүү зорилгын хүрээнд бид Профессор Токи Анмэ-гийн боловсруулсан “Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчны шалгуур үзүүлэлт”-ийг ашиглан (хавсралт 4) Ховд аймгийн төв Жаргалант суманд оршин суух нийт 500 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан практик судалгааг дараах үндсэн зорилготойгоор зохион байгуулсан:

- Бодит байдлыг тольдох: Эцэг эх, асран хамгаалагчдыг “дүгнэх” бус, харин тэдний хүүхэдтэйгээ тогтоосон харилцааны өнөөгийн байдлыг ил тод харуулах;
- Аргачлалын нийцлийг шалгах: Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчны шалгуур үзүүлэлтийг Монгол хүүхдийн өсөн торниж буй өвөрмөц орчныг үнэлэхэд ашиглах боломжтой эсэхийг тодорхойлох;
- Хөгжлийн гарцыг нээх: Судалгааны үр дүнд тулгуурлан Монгол гэр бүлийн хүмүүжлийн уламжлал болон орчин үеийн сэтгэл зүйн шинжлэх ухааны ололтыг хослуулах боломжийг эрэлхийлэх зэрэг болно.

Судалгааны үр дүнгээс харахад эцэг эхчүүд хүүхэдтэйгээ бие махбодын хувьд нэг орон зайд байгаа ч, тэдний хөгжлийг дэмжих идэвхтэй оролцоо хангалтгүй байна. Хүүхэдтэйгээ хамт салхинд гарах, дэлгүүр явах, дуу дуулах, ном уншиж өгөх зэрэг энгийн мөртлөө үнэ цэнтэй үйлдлүүдийн үзүүлэлт доогуур байгаа нь биднийг гэр бүлийн харилцаагаа эргэцүүлэн бодоход хүргэж байна. Асран хамгаалагчдын энгийн гэж үзэж болохуйц үйлдлүүд, тухайлбал салхинд гарах, дэлгүүр явах, дуу дуулах, ном унших зэрэг нь хүүхдийн тархины хөгжил, сэтгэл зүйн аюулгүй, тайван байдлыг цогцлоон бүрдүүлдэг болохыг нотолгоонд суурилсан судалгаанууд баталсан байдаг. Хүүхэдтэйгээ хамт ном унших нь тэдний хэл ярианы баялаг, төсөөлөн бодох чадвар, бүтээлч сэтгэлгээг хурцалдаг бол хамт дуу дуулах нь аз жаргалын дааврыг нэмэгдүүлж, стресс тайлах, анхаарал төвлөрөлтийг сайжруулахад чухал нөлөөтэй. Түүнчлэн дэлгүүр явах, салхинд гарах зэрэг нь хүүхдийн мэдрэхүйг идэвхжүүлж, бие даасан байдлыг нь дэмжихийн зэрэгцээ сонголт хийх, шийдвэр гаргах, бусадтай харилцах гэх мэт нийгмийн чухал ур чадваруудыг эзэмшүүлэхэд тусалдаг. Эцэг эх, асран хамгаалагчдын хувьд хүүхдээ зөвхөн өсгөж байгаа бус, харин тэдэнтэй хамт хөгжиж, хүчирхэгжиж байна гэдгээ ухамсарлах нь нэн чухал.

Тоон судалгаагаар гэр бүлээрээ хамт хооллох, хүүхдийнхээ хүмүүжлийн талаар харилцан ярилцах явдал Монгол өрхүүдэд түгээмэл байгаа нь бидний уламжлалт үнэт зүйлс амь бөхтэй хадгалагдаж буйн илрэл. Гэвч чанарын судалгааны үр дүнгээс харахад, гэр бүлээрээ хамт хооллодог ч, бие бие рүүгээ харж ярилцахын оронд ухаалаг төхөөрөмж эсвэл зурагт руу анхаарлаа хандуулах хандлага зонхилж байна. Анхаарлаа дэлгэцэнд зориулах нь хүүхдийнхээ хөгжлийг дэмжих хамгийн нандин боломжоо өөрсдөө алдаж байна гэсэн үг юм. Түүнчлэн хүүхдэдээ ямар ном уншиж өгдөг, ямар тоглоомоор тоглодог, салхинд гарахдаа хаагуур хэр хугацааг хамтдаа өнгөрүүлдэг, мөн хэнтэй уулздаг зэрэг эцэг эхийн өдөр тутмын үйлдлийг дэлгэрэнгүй судлах шаардлага тулгарч байна. Хүүхдийн хөгжилд нөлөөлж буй эдгээр нарийн хүчин зүйлсийг таньж мэдэх нь илүү үр дүнтэй дэмжлэг үзүүлэхэд чухал түлхэц болох болно.

Эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийнхээ хүмүүжлийн талаар гэр бүл, найз нөхдийн хүрээнд харилцан ярилцаж, туршлага солилцох нь түгээмэл ажиглагддаг. Хүүхдийнхээ талаар ярилцах дотнын хүнтэй байх нь сайшаалтай ч, зөвлөлдөж буй тэрхүү яриа мэргэжлийн түвшний мэдлэг, зөвлөгөөг бүрэн орлож чадах эсэх нь эргэлзээтэй. Эцэг эхчүүдийн дунд мэргэжлийн байгууллагаас дэмжлэг авах хандлага хангалтгүй байгаа нь анхаарал татаж байна. Хүүхдийн хөгжилтэй холбоотой асуудлыг зөвхөн гэр бүлийн хүрээнд, өөрсдийн туршлагаар хязгаарлан шийдвэрлэх нь учир дутагдалтай. Иймд шинжлэх ухаанд суурилсан мэргэжлийн зөвлөмжийг амьдралдаа тусгах нь хүүхдийн ирээдүйд оруулж буй хамгийн оновчтой хөрөнгө оруулалт болох билээ.

Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдийн дунд хүүхдээ бие махбодоор шийтгэсэн тохиолдол илэрсэн нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл бодит байдлаар оршсоор байгааг илтгэж байна. Эцэг эх, асран хамгаалагчид хүүхэддээ үзүүлж буй бие махбодын шийтгэлийн талаар үнэнийг илэн далангүй хуваалцахаас эмээх, эсвэл нийгмийн зүгээс шүүмжлэлд өртөхөөс болгоомжлох хандлагатай байдаг. Иймд судалгаагаар илэрснээс илүү өргөн хүрээг хамарсан хүчирхийлэл далд хэлбэрээр оршиж байх магадлалтай.

Судалгаанд оролцогчдын хариултын дундаж оноог Япон зэрэг хөгжингүй орнуудын жишигтэй харьцуулахад нэлээд доогуур үзүүлэлттэй байгаа нь анхаарал татаж байгааг энэхүү судалгааны үр дүн нь эцэг эх, асран хамгаалагчид болон мэргэжилтнүүд нөхцөл байдлыг бодитоор таньж мэдэх, хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчин, түүний ач холбогдлын талаарх мэдлэгээ нэмэгдүүлэх шаардлагатай байгааг илтгэн харуулж байна.

3. Хүчирхэгжих онолын хүрээнд хүүхдийн өсөж торних орчныг сайжруулах нь

Хүчирхэгжих онол нь хүүхдийг зөвхөн асран хамгаалах объект бус, өөрийн гэсэн нөөц боломжтой, бие даасан субъект гэж авч үздэг. Энэхүү онолыг хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчны үнэлгээтэй хослуулснаар эцэг эхчүүд хүүхдийнхээ хөгжлийн түвшинг “тольдон харах” боломж бүрдэнэ. Хүүхдэд шийдвэр гаргах эрх олгох, тэднийг сонсох, алдааг нь сургамж болгон ашиглах зэрэг нь тэдний дотоод нөөц бололцоог нээж өгдөг. Ингэснээр эцэг эхчүүхдийн харилцаа нь хяналт гэхээс илүүтэй “хамтын хөгжил” болж хувирдаг.

Хүүхдийн хөгжлийг дэмжинэ гэдэг нь мэргэжилтний зааварчилгааг сохроор дагах бус, эцэг эх өөрөө “ажиглагч болон хөгжүүлэгч” болох үйл явц юм. Хүчирхэгжих онолыг практикт хэрэгжүүлэхэд эцэг эхээс амьдралын хэв маягаа бүрмөсөн өөрчлөх эсвэл нэмэлт ачаалал үүрэх шаардлагагүй. Эсрэгээрээ, өдөр тутмын хэвшил, харилцаандаа жижиг боловч ухамсартай, эерэг үйлдлүүдийг нэвтрүүлэх нь хүмүүжлийн үр дүнг эрс нэмэгдүүлдэг. Хүчирхэгжих үйл явц нь хүүхдийн өсөлт хөгжлийн хурд, сонирхолд нийцсэн, эцэг эхийн тууштай дэмжлэг дээр суурилдаг

Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчныг сайжруулах нь зөвхөн гэр бүлийн дотоод асуудал бус, улс орны ирээдүйн хүний хөгжлийн чадавхийг тодорхойлох стратегийн чухал үзүүлэлт юм. Хүүхдийн хөгжил нь гэр бүлийн халуун дулаан уур амьсгал болон нийгмийн дэмжлэгийн тогтолцооны харилцан үйлчлэлийн үр дүнд төлөвших тул эцэг эх, асран хамгаалагчид болон мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэх нь тогтвортой хөгжлийн зайлшгүй шаардлага юм.

Эцэг эхийн өөртөө итгэх итгэл нэмэгдсэнээр хүүхэдтэйгээ харилцах харилцаа эрс сайжирч, нийгэмд өөрийгөө илэрхийлэх, бэрхшээлийг сөрөх, шаардлагатай үед дэмжлэг авах чадвар бүхий бие хүнийг төлөвшүүлэх суурь тавигддаг.

Эцэст нь дүгнэхэд, хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчныг үнэлэх энэхүү шалгуур үзүүлэлтүүд нь Монгол хүүхдийн өсөн торниж буй нийгэм, соёлын өвөрмөц онцлогт бүрэн нийцэж байна. Энэхүү аргачлал нь манай улсын нөхцөлд хүүхдийн хөгжлийг дэмжих, хэмжих бодит бөгөөд шинжлэх ухаанч хэмжүүр болж чадна.

Хүүхдийн өсөж торних орчныг шинжлэх ухаанд тулгуурласан байдлаар сайжруулах нь зөвхөн гэр бүлийн дотоод асуудал бус, улс орны ирээдүйн хүний хөгжлийн чадавхийг тодорхойлох стратегийн чухал үзүүлэлт юм. Хүчирхэгжих онолд тулгуурласан арга аргачлал, шалгуур үзүүлэлтүүд нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлогын нэгэн тулгуур болох “Хүний хөгжил”-ийг дэмжихэд үнэтэй хувь нэмэр оруулах юм.

ХАВСРАЛТ

Хавсралт 1: Хүүхдийн хөгжлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт

7:06	Нэг хөл дээрээ 30 орчим секунд зогсоно.	Төгөлдөр хуур гэх мэт даралтад хөгжмийн товчлуурыг чөлөөтэй дарж тоглоно.	Шүүрээр цэвэрлэгээ хийнэ.	Хамтран цэвэрлэгээ хийнэ. Нэг нь шүүр ашиглаж байхад нөгөө хүүхэд тосгуур ашиглах гэх мэт	Уншиж чадна	Энгийн нэмэх үйлдэл хийж чадна.
7:00	Нэг хөлнийхөө доогуур бөмбөг ойлгож гаргана.	Цаасан онгоц хийнэ	Гутлын үдээсээ бие даан үднэ.	Найзынхаа юу хүсэж байгааг урьдчилан тааварлан ойлгоно.	Жоохон хүүхдийн эрхэлсэн хэллэг хэрэглэхгүйгээр ярина.	Цаг хэлж чадна.
6:06	Дээсээр бие даан тоглож чадна.	Бийр, будаг ашиглан зураг зурна	Нойтон алчуур мушгиж чадна.	Дүрэмтэй тоглоом (жишээ нь хөзөр) ойлгож тоглож чадна	Энгийн үг, үгсийг үсэглэж уншина.	Анхаарал төвлөрүүлдэг хөзрийн тоглоом (ижил дүрс хайх г.м) тоглоно.
6:00	Нэг хөл дээрээ 10 орчим секунд зогсоно.	Хүний зургийг дор хаяж гурван ялгагдах биеийн хэсэгтэйгээр зурж чадна.	Гадагшаа гарахад тохируулан хувцаслана.	Энгийн тоглоомд бие даан тодорхой үүрэг гүйцэтгэж тоглоно.	Өөрт тохиолдсон явдал, үлгэрийг ярьж өгнө.	Энгийн зүйрлэл ойлгож чадна (жишээ нь: "Мөс хүйтэн бол гал ...")
5:06	Савлуур савлаж байх үед зогсоо/суугаа байрлалаас суугаа/зогсоо байрлал руу шилжинэ. ¹	Цаасан онгоцыг хэрхэн сайжруулах талаар шийд гаргаж чадна.	Усанд орсны дараа хувцаслана.	Касснаас хариулт мөнгөө авч чадна.	Хэл яриа хөгжүүлэх, үгийн баялаг сайжруулах зорилго бүхий үг давтах, холбох тоглоом тоглож чадна.	Онъого тааж, ойлгоно.
5:00	Нэг хөл дээрээ 5 орчим секунд зогсоно.	Хүний зургийг дор хаяж гурван ялгагдах биеийн хэсэгтэйгээр зурж чадна.	Гадагшаа гарахад боломжийн түвшинд хувцаслаж чадна.	Хэн нэгний тусламжтайгаар энгийн тоглоомд тодорхой үүрэг гүйцэтгэж тоглоно.	Богино хэмжээний түүх, үлгэрийг давтан ярина.	Өлсөх, ядрах, даарах зэрэг мэдрэмж, сэтгэгдлийг ойлгоно.
4:08	Дэгдэн гүйнэ.	Насанд хүрсэн хүний зааварчилгааны дагуу цаасан онгоц хийнэ.	Хувцаслаж чадна	Элсэн талбайд бусадтай хамтран тоглож, элсэн бүтээл (уул) хийж чадна.	Насанд хүрсэн хүний хэлсэн энгийн өгүүлбэрийг давтах бөгөөд 3 оролдлогоос 2-ийг нь зөв хэлнэ. ²	Баруун, зүүн талыг ялгаж салгаж чадна.
4:04	Савлуур дээр тоглох дуртай.	Ойсон бөмбөгийг барьж авна.	Гэрлэн дохионы өнгийг тодорхой ялгаж, замаар гарна.	"Хайч-Чулуу-Даавуу" тоглоомын аргыг ашиглан шийдвэр гаргаж тоглож чадна	Дөрвөн оронтой тооны дарааллыг давтах бөгөөд 3 оролдлогоос 2-т нь зөв хэлнэ. ³	5 хүртэлх тооны утга, дарааллыг ойлгоно.
4:00	Нэг хөл дээрээ 2 ба түүнээс дээш удаа догонцон үсрэх.	Хайчаар зураасны дагуу амжилттай хайчилж чадна.	Бусдын тусламжгүйгээр биеэ угаана (биеийн бүх хэсгийг заавал гүйцэд угаах албагүй).	Насанд хүрэгчдэд хаашаа явахгаа хэлж чадна	Эцэг эхийнхээ нэрийг бүтэн хэлж чадна.	Өгөгдсөн таван асуултыг бүрэн ойлгон, тохиромжтой бөгөөд зөв хариулж чадна ⁴
3:09	Байрнаасаа урагш хол үсэрснэ.	Хэрээс хэлбэрийн дүрсийг дуурайн зурах гэж ородоно.	Нусаа нийнэ.	Өөрийн ээлжийг хүлээж чадна	Дээрхтэй адил 3 энгийн өгүүлбэрийг давтах бөгөөд хамгийн багадаа 2-ыг нь зөв хэлнэ.	3 хүртэлх тооны утга, хэмжээг ойлгоно.
3:06	Гурван дугуйтай унадаг дугуй унана.	Бөмбөг барьж авна.	Гараа угааж, арчина.	Тоглоомоо бусдад эзэлдүүлж, бусдаас гуйж авч чадна.	Гурван энгийн өгүүлбэрийг давтан хэлэх бөгөөд гурван оролдлогын дор хаяж нэгд нь зөв хэлж чадна. ⁵	2 хүртэлх тооны утга, хэмжээг ойлгоно.
3:03	Чигээрээ урагшаа өнхөрч чадна.	Жижиг товчийг (ойролцоогоор 1 см)-амжилттай товчилно.	Нүүрээ бусдын тусламжгүйгээр угааж, арчина.	Зөвшөөрөл хүсэж чадна.	Үеийнхээ хүүхдүүдтэй энгийн яриа өрнүүлнэ.	Өндөр ба намын ялгааг ойлгоно.

3:00	Нэг хөл дээрээ зогсох гэж оролдоно.	Хайчаар цаас хайчилж чадна.	Хувцсаа тайлна.	"Айл гэр" болох гэх мэтээр дүрд орж тоглож чадна.	Хоёр үгнээс бүтсэн дарааллыг давтан хэлэх бөгөөд гурван оролдлогын хоёрт нь зөв гүйцэтгэнэ.	Дөрөв ба түүнээс дээш өнгийг нэрлэж чадна.
2:09	Өсгий дээрээ зогсоод эргэнэ. (заавал бүтэн эргэх албагүй)	Дугуй дүрсийг дуурайж зурна.	Гутлаа өмсөнө. (үдээсгүй)	Өөрөөсөө дүү хүүхдүүдийг халамжлах хандлага гаргана.	2 тооны дарааллыг давтан хэлэх бөгөөд 3 оролдлогоос 2-ийг нь зөв хэлнэ. ⁶	Урт болон богино гэдгийн утгыг ойлгоно.
2:06	Шат өөд хөлөө ээлжлэн алхаж өгсөнө.	Шулуун зураас дуурайлган зурж чадна.	Халбагаар хоолоо асгалгүйгээр өөрөө иднэ.	Хэрүүл маргааны талаар насанд хүрэгчдэд хэлж мэдэгдэнэ.	Өөрийн бүтэн нэрийг хэлнэ.	Том ба жижгийн ялгааг ойлгоно.
2:03	Хоёр хөлөөрөө зэрэг үсэрнэ.	Төмөр турникнээс гараараа зуурч, хэдэн секундын турш зүүгдэнэ.	Өмдөө тайлна.	Утсаар ярьж буй мэт үйлдлийг дуурайж тоглоно.	Үгээр дамжуулан сэтгэл хөдлөлөө илэрхийлнэ (гоё, сайхан, хөөрхөн гэх мэт).	Нүд, ам, чих, гар, хөл, гэдэс гэх мэт биеийн хэсгүүдийг ялган таньж, 6-аас дор хаяж 4-ийг нь зөв зааж нэрлэнэ.
2:00	Бөмбөгийг урагш өшиглөнө	Тоглоомон шоог дараалуулан зэрэгцүүлж өрнө.	Бие засах хэрэгцээ гарсан үед бусдад хэлж мэдэгдэнэ.	Эцэг эх нь ойр хавьд байхгүй байсан ч ганцаараа тоглоно.	Хоёр үгнээс бүтсэн өгүүлбэрээр ярина.	"Дахиад нэг", "бага зэрэг" гэсэн ойлголтыг ялган танина.
1:09	Шатны гишгүүр бүр дээр хоёр хөлөө зэрэг тавьж алхана.	Дугуй дүрсийг дараалуулан зурж чадна.	Шингэн зүйлийг соруулаар сорж ууна.	Найзуудтайгаа хөтлөлцөнө.	Зурагтай номноос гурван зүйлийг нэрлэн зааж чадна.	Биеийн үндсэн хэсгүүдээс нүд, ам, чих, үс, шүд, хэл, хүйс, хумс гэх мэтийг ялган таньж, 6 - аас дор хаяж 4-ийг нь зөв заана.
1:06	Гүйнэ.	Нэг аяганаас нөгөө аяга руу усыг асгалгүйгээр юулнэ.	Өмд өмсгөхөд хөлөө салгаж үйлдлийг хөнгөвчлөх оролдлого хийнэ.	Тусламж хүснэ.	Зурагтай номноос нэг зүйлийг нэрлэн зааж чадна.	Насанд хүрсэн хүнээс ном уншиж өгөхийг хүснэ.
1:04	Гуталтайгаа алхаж чадна.	Хоёр шоог дээр дээр нь давхарлаж байшин барина.	Амаа арчих гэж оролдоно.	Энгийн хоол (жишээ нь: сүүн дээр овъёос нэмэх гэх мэт) бэлдэж чадна	Гурван үг хэлнэ.	Дараалсан энгийн тушаал, даалгавруудыг биелүүлж чадна.
1:02	Бусдын дэмжлэггүйгээр 2-3 алхам хийнэ.	Аяган доторх жижиг биетийг (шоо гэх мэт) гаргаж авна.	Чихрийн цаасыг задалж чадна.	Бусдын анхаарлыг татах, инээд хүргэх үйлдлүүдийг давтан хийнэ.	Утга бүхий хоёр үг хэлнэ.	Дээрхтэй адил энгийн амаар өгсөн зааврыг ойлгох бөгөөд 3 оролдлогоос 3-ууланг нь зөв гүйцэтгэнэ.
1:00	Суугаа байрлалаас бусдын дэмжлэггүйгээр босож зогсоно.	Цаасан дээр сараачина.	Халбагаар бие даан хооллоно.	Эцэг эх нь явах үед араас нь дагах гэж оролдоно.	Тодорхой ярианы дуу авиаг дуурайна.	Дээрхтэй адил энгийн амаар өгсөн зааврыг ойлгох бөгөөд 3 оролдлогоос 1-д нь зөв биелүүлнэ.
0:11	Тавилга түшиж алхана	Тоглоомон машиныг түлхэж тоглоно.	Аяганаас асгалгүй ууна.	Танихгүй хүнээс айж цэрвэнэ.	Дуу чимээг дуурайж эхэлнэ.	Мэндчилгээнд гар даллан хариу үйлдэл үзүүлнэ.
0:10	Юмнаас зуурч өөрийгөө татаж босгоно.	Савны тагийг эргүүлж хааж, нээнэ.	Уйлахгүйгээр өөрийн мэдрэмжийг илэрхийлнэ.	Энгийн үйлдэл болон дуу чимээг дуурайна.	Эгшиг авиаг гаргаж, үе холбосон авиаг (баба, дада, кака гэх мэт) идэвхтэй хэлж чадна	"Үгүй" (болохгүй) гэсэн үгэнд хариу үйлдэл үзүүлнэ.
0:09	Тавилга түшин зогсож чадна.	Бөмбөрийг идэвхийлэн цохино.	Аягийг хоёр гараараа барьж ам руугаа дөхүүлнэ.	Барьж буй зүйлийг нь авахад дургүйцнэ.	Хоёр үе бүхий авиа хэлнэ	Танил ба танихгүй дуу хоолойг ялгана.
0:08	Дэмжлэггүй-гээр сууж чадна.	Эрхий, долоовор хуруугаараа жижиг зүйлсийг хавчин барина.	Нүүрээ арчуулах дургүй байх.	Толинд туссан дүрс рүүгээ харж инээх эсвэл ярина.	Нэг үет авиа хэлнэ	Толгойгоо эргүүлэн, дуу гарч буй зүг рүү харна.
0:07	Хэвлийгээрээ хэвтэж байхдаа баруун, зүүн тийш биеэ эргүүлнэ.	Жижиг зүйлийг нэг гараас нөгөө гарт шилжүүлж барина.	Аяганаас ууна/хооллоно.	Найрсаг болон ууртай нүүрний илэрхийллийг ялган танина	Тоглоом руугаа харан дуу авиа гаргана.	Эцэг эхийн дууны өнгөөр сэтгэл хөдлөлийг нь ойлгоно.

0:06	Биеэрээ эргэж чадна.	Эд зүйлсийг өөрийн хүслээр барьж авч чаддаг болно.	Жигнэмэг гэх мэт зүйлийг амандаа хүргэх, үмхэх гэж оролдоно.	Толинд туссан өөрийн дүрсэд хариу үйлдэл үзүүлнэ.	Танил дуу хоолойд хариу дуу авиа гаргана.	Хүн харахаараа инээмсэглэнэ.
0:05	Хажуугаараа хэвтэж байснаа доошоо харан эргэнэ.	Гарт нь бариулсан шажигнуур тоглоомыг сэгсэрнэ	Тоглоом хараад баярлаж, биеийн хөдөлгөөн болон дуу авиагаар сэтгэл хөдлөлөө илэрхийлнэ.	Хүний харилцаанд хариу болгон инээмсэглэнэ.	Дуу авиа гарган ярих гэж оролдоно.	Ээжийнхээ дуу хоолойг бусад хүмүүсийнхээс ялгаж танина.
0:04	Толгой, хүзүүгээ дааж сурна.	Шажигнадаг тоглоомыг гараараа чанга атгана.	Халбагаар хооллоно.	Гижигдэхэд инээх хариу үйлдэл хийнэ	Чанга инээнэ.	Толгойгоо хажуу тийш эргүүлж дуу чимээ хаанаас гарч байгааг олохыг хичээнэ.
0:03	Өргөх үед толгойгоо сайн даана.	Хацарт нь хүрсэн зүйлийг барьж авах гэж оролдоно.	Халбагаар хооллоно.	Чимээ гарсан зүг рүү толгойгоо эргүүлнэ.	Уйлахаас бусад төрлийн дуу авиа гаргана.	Дуу хоолой сонсоод чимээгүй болно (анхаарал хандуулна).
0:02	Эрүүгээ өргөнө.	Хуруугаа хөхөх үйлдэл илэрнэ.	Хооллосны (хөхүүлсний) дараа цадсан шинж тэмдэг үзүүлнэ ^{*7} .	Хүний нүүр царай руу харцаа тогтоож харна.	Эгшиг маягийн зөөлөн дуу авиа гаргана.	Дуу чимээ гарсан зүг рүү нүдээрээ хайж харна.
0:01	Хэвтэж байхдаа толгойгоо хоёр тийш нь эргүүлж чадна.	Гаранд нь хүрэхэд атгах гэж оролдоно.	Өлсөх үедээ хөх/угж руу толгойгоо чиглүүлэх, тэмүүлэх үйлдэл хийнэ	Тэврэх үед уйлахаа болино.	Чангаар уйлна.	Дуу чимээнд хариу үйлдэл үзүүлнэ.
Нас	Том булчингийн хөгжил	Жижиг булчингийн хөгжил	Нийгэмшихүйн чадамж	Харилцааны хөгжил	Үг ярианы хөгжил	Оюун ухааны хөгжил
Булчингийн хөгжил			Нийгэмшихүйн хөгжил		Хэл яриа, танин мэдэхүйн хөгжил	

*1 Хэрэв хүүхэд тухайн үйлдлийг хийхээс айж байвал "✓" тэмдэг тавина.

*2 "Хоёр хүүхэд савлуур дээр тоглож байна."

"Уулын дээгүүр том сар гарч ирлээ."

"Би өчигдөр ээжтэйгээ дэлгүүр явсан."

*3 "5-2-4-9", "6-8-3-5", "7-3-2-8"

*4 Асуулт 1: Хэрэв уншихыг хүсвэл юу хэрэгтэй вэ? (Хариулт: ном гэх мэт)

Асуулт 2: Хэрэв бичихийг хүсвэл юу хэрэгтэй вэ? (Хариулт: харандаа гэх мэт)

Асуулт 3: Цаг мэдэхийг хүсвэл юу хэрэгтэй вэ? (Хариулт: цаг гэх мэт)

Асуулт 4: Суухыг хүсвэл юу хэрэгтэй вэ? (Хариулт: сандал гэх мэт)

Асуулт 5: Харанхуй үед юу хэрэгтэй вэ? (Хариулт: гэрэл гэх мэт)

*5 "Цэцэг дэлгэрч байна." "Онгоц нисэж байна." "Би сайн дуулдаг."

*6 "5-8", "6-2", "3-9"

*7 Хөхөө (угжаа) түлхэн гаргах, нүүрээ буруулна.

Зохиогчийн эрх: Япон улс, Цукуба Их Сургууль, Хүчирхэгжих шинжлэх ухаан, Олон улсын хүний хөгжил судлалын тэнхим

Хавсралт 2: Нийгэмшихүйн ур чадварын үнэлгээ

№	Үзүүлэлт	Үргэлж (2 оноо)	Заримдаа (1 оноо)	Хэзээ ч үгүй (0 оноо)
1	Хүн өөртэй нь ярихад өөдөөс нь эгцлэн харж харилцдаг			
2	Хүн өөртэй нь ярихад өөдөөс нь мэдэгдэхүйц хариу үзүүлдэг			
3	Хэн нэгэн өөрт нь туслах эсвэл ямар нэгэн зүйл хийж өгөхөд баярласнаа илэрхийлдэг			
4	Өөрийн мэдрэмж, сэтгэл хөдлөлөө нүүрний хувирлаараа харуулдаг			
5	Бусадтай зөв, зохистой мэндчилдэг			
6	Бусадтай харилцахад санаачилгатай оролцож, яриа эхлүүлдэг			
7	Бусадтай ярьж байхдаа нүд рүү нь хардаг			
8	Бусадтай хамт тоглохыг урихад дуртайяа оролцдог			
9	Олон нийтийн газар уурлаж уцаарлах, зөрүүдлэх үйлдэл гаргадаггүй			
10	Хүлээх хэрэгтэйг хэлэхэд тэвчээртэй хүлээж чаддаг			
11	Бусадтай тоглоом эсвэл хоолоо хуваалцдаг			
12	Бусдын яриаг тасалдуулахгүй сонсдог			
13	Өөрийн ээлжийг хүлээдэг			
14	Бусдаас тоглоомыг нь гуйж / асууж авдаг			
15	Нөхцөл байдалд тохируулан биеэ зөв авч явдаг			
16	Хэлж ойлгуулах үед зөрүүдлэхээ больж, үгэнд ордог			
17	Найз нь өвдөж, гэмтсэн үед тусладаг			
18	Ганцаардсан, уйтгартай харагдаж байгаа найзыгаа хөгжөөж саатуулахыг хичээдэг			
19	Бүтэлгүйтсэн хүнийг тайвшруулж, урам зориг өгдөг			
20	Найзыгаа амжилт гаргахад хамт баярлаж чаддаг			
21	Найзынхаа амжилтыг магтдаг			
22	Ямар нэг зүйлийг сайн хийсэн найздаа баяр хүргэж алга ташдаг			
23	Найзын хүсэлтийн дагуу тусладаг			
24	Хэлүүлэлгүйгээр найздаа тусалдаг			

Нийгэмшихүйн ур чадварын 3 бүрэлдхүүн хэсэг:

Өөрийгөө илэрхийлэх чадвар: 1–8.

Өөрийгөө хянах чадвар: 9–16.

Хамтран ажиллах чадвар: 17–24

Хавсралт 3: Онцгой анхаарал шаардлагатай хүүхдийг ажиглаж үнэлэх хуудас

Ангилал	Агуулга	Үнэлгээний шалгуур	Тийм ○	Нөлөөлөх хүчин зүйл	
1. Дуу чимээнд хэвийн бус хариу үйлдэл үзүүлэх	① Дуу авианд сул эсвэл огт хариу үзүүлдэггүй	Чанга дуу гарахад тэр зүг рүү толгойгоо эргүүлэхгүй байх, цочихгүй, гайхахгүй, ямар нэг хариу үйлдэл үзүүлэхгүй байх. Сэрүүн байхдаа хүн ярихад ямар ч хариу үйлдэл үзүүлэхгүй, эсвэл эргэн тойрны хүмүүсийн дуу хоолойг огт сонирхохгүй байх.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	② Дуу авианд хэт мэдрэг	Орчны дуу авианд хэт мэдрэг хариу үзүүлж, сандарч, айж түгших.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	③ Бусад	(Дэлгэрэнгүй бичнэ үү)		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
2. Хэвийн бус уйлах зуршил	① Хэт уйламтгай	Хөхүүлсний (хооллосны) дараа оронд нь хэвтүүлмэгц шууд уйлж эхлэх.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
		Нойрны эмгэг илрэх.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
		Өдрийн турш хэт сэргэлэн, тайван бус байдал үргэлжлэх хандлагатай.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	② Байнга тэврүүлэхийг хүсдэг			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	③ Шөнө байнга уйлдаг			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	④ Бусад	(Дэлгэрэнгүй бичнэ үү)		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
3. Тэврүүлэх дургүй	① Тэврүүлэхийг хүсдэггүй	Тэврэх үед биеэ хойш нь гэдийлгэх.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
		Тэврэх үед биеэ хумиж, атирах.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
		Хамт тоглож, саатуулах үед царайны хувирал гаргахгүй байх.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
		Тэврүүлж байхдаа харц тулгарахгүй (нүд рүү харахгүй) байх.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	② Бие нь хөшингө, чанга байх	Нярай үедээ мөлхөх оролдлого хийхгүй байх.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
		Дасгал, хөдөлгөөний үед биед нь хүрэхэд дургүйцдэг.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	③ Бусад	(Дэлгэрэнгүй бичнэ үү)		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
4. Өсөлтийн хоцрогдол/Дутуу хөгжил	① Өсөлтийн хоцрогдол	Хүүхдийн биеийн өсөлтийн стандарт үзүүлэлт (Өсөлтийн муруй)-ын дагуу жин нь 3%-иас доош эсвэл 97%-иас дээш байх.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	② Өсөлтийн хоцрогдол илрэх хандлагатай	Хүүхдийн биеийн өсөлтийн стандарт (перцентил буюу өсөлтийн муруй)-ын дагуу жин нь 10%-иас доош эсвэл 90%-иас дээш байх.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	③ Бусад	(Дэлгэрэнгүй бичнэ үү)		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
5. Өдөр тутмын амьдралын хэмнэл алдагдал	① Хоолны (хөхөөр хооллох) хэмжээ тогтворгүй, зөрүүтэй байх			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	② Хооллох (хөхүүлэх) давтамж, хугацаа алдагдах			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	③ Унтах хугацаа тогтворгүй байх			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	④ Орондоо орох (унтахаар хэвтэх) цаг зөрөх			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	⑤ Сэрэх цаг нь тогтворгүй байх			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	⑥ Өдрийн нойр авах цаг зөрүүтэй байх, алдагдах			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	⑦ Өдрийн турш биеийн халуун нь хэвийн бусаар хэлбэлзэх			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	⑧ Өдөр, шөнийг ялгахгүй байх			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	⑨ Бусад	(Дэлгэрэнгүй бичнэ үү)		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин

Ангилал	Агуулга	Үнэлгээний шалгуур		Тийм ○	Нөлөөлөх хүчин зүйл	
6. Гэрлийн өдөөлтөнд харааны хэвийн бус хариу үйлдэл үзүүлэх	① Харж буй зүйлд үзүүлэх хэвийн бус хариу үйлдэл	Нярай үе:	Том хэмжээний биетийг харцаараа дагуулж харахгүй байх.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
			Урд байрлах зүйлийг барьж авч чаддаггүй.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
		Бага насны үе:	Харааны бэрхшээлтэй.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
			Нүдний хөдөлгөөн болон харах хэв маяг хэвийн бус.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
			Нүдээ онийлгон/хялар харах.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
			Ойрын хараа муудах.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
			Холын хараа муудах.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
			Өнгө ялгах чадвар сул (өнгөний харалган/сохрол).		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	② Гэрлийн нөхцөлөөс хамаарч хэт мэдрэг/сул	Нялх үе:	Гэрэлтэй орчинд хэт мэдрэг болох.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
			Гэрэлтэй орчинд хариу үйлдэл үзүүлэхгүй (мэдрэмжгүй) болох.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	③ Бусад	(Дэлгэрэнгүй бичнэ үү)			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
7. Таталт	① Эпилепси/ Уналт таталт	Биеийн халуун хэвийн үед	Эпилепсийн оноштой.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	② Хүчтэй сэтгэл хөдлөл, уурлаж, цухалдахаас үүдэлтэй таталт		Ихээр уйлж цухалдах үед таталт өгөх.		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	③ Халууралтаас үүдэлтэй таталт	Хэвийн бус халуунтай үед	Нэгээс олон удаа таталт өгч байсан		A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	④ Бусад	(Дэлгэрэнгүй бичнэ үү)			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
8. Харшил	① Хүнсний харшилтай байх	(Шалтгааныг нь тодорхой бичнэ үү)			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
		Харшил хөдөлгөхгүй хоол хүнс эсвэл орлуулах бүтээгдэхүүн шаардлагатай.			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	② Анафилаксийн шинж тэмдэг илэрдэг	(Шалтгааныг нь тодорхой бичнэ үү)			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	③ Атопик дерматит шинж тэмдэг, оноштой	Арьс нь байнга загатнадаг.			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
		(Хүндрэлийн зэргийг тайлбарлана уу)			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
	④ Тоос/ ургамлын харшилтай	Тодорхой улирал, хугацаанд хамраас нус гоожих, найтаах шинж тэмдэг илэрдэг.			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
9. Асран халамжлагчаа-саа холдож үлдсэн үедээ танихгүй хүнээс айж сандрах	① Танихгүй хүнээс хэт ихээр айх	6-8 сартайгаас хойш танихгүй хүнээс айх айдас илрэхгүй, Нэрийг нь дуудахад хэн байсан ч инээмсэглэн хариу үзүүлнэ.			A: Хүүхэд C: Харилцаа	B: Асран хамгаалагч D: Орчин
			Гэр бүлийн гишүүд хүүхэдтэйгээ хамт байхдаа юу мэдэрдэг, хэрхэн харилцдаг, хамт тоглодог цаг хугацаа болон давтамж, хамт хооллох боломж, унтах дадал, ном уншиж өгөх давтамж, хамт дэлгүүр хэсдэг эсэх болон бие биедээ хандаж буй сэтгэл хөдлөл зэргийг тэмдэглэсэн эсэх.		Хүүхэдтэй хамт тоглодог давтамж болон хугацааг тодруулах.
					Хамт хооллодог эсэхийг тодруулах
					Хүүхдийн унтах дадал хэвшлийг тодруулах.
					Хүүхдэд ном уншиж өгдөг эсэхийг тодруулах.
					Хүүхэдтэй хамт гадуур (жишээлбэл, дэлгүүр явах) боломж, давтамжийг тодруулах.
					Хүүхдийн талаарх асран хамгаалагчийн мэдрэмж, хандлагыг магадлан тогтоох.

Ангилал	Дэд ангилал	Шалгуур үзүүлэлт	Зааварчилгаа	Шалгаж тэмдэглэх	Дэлгэрэнгүй
3. Хүүхдийн эрх, хамгаалал	(1) Хүний үндсэн эрх	1) Гэр бүлийн хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалж чадаж байгаа эсэх.	Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж, хүчирхийллээс ангид байлгаж, хүүхдийн насны онцлогт тохирсон хөгжлийг хүндэтгэж, эрхийг нь хамгаалж, аливаа зүй бус харилцаанаас ангид байлгаж чадаж байгаа эсэх.		Хүүхэд бие махбодын хүчирхийлэлд өртөж байгаа эсэхийг тодруулах. Хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртөж байгаа эсэхийг магадлах. Хүүхэд сэтгэл зүйн хүчирхийлэлд өртөж байгаа эсэхийг магадлах. Хүүхэд үл хайхрах хэлбэрийн хүчирхийлэлд өртөж байгаа эсэхийг тодруулах. Хүүхдийн санал бодлыг сонсохын зэрэгцээ, насанд хүрэгчдийн гаргаж буй шийдвэр нь тухайн хүүхдийн насны онцлогт тохирч байгаа эсэх.
		2) Хүүхдэд энэрэнгүй хандаж, эрхийг нь хамгаалж чадаж байгаа эсэх.	Дараах үндсэн эрхүүдийг мэдэж, хүндэтгэн хамгаалж байгаа эсэх: (Мэдээлэл авах болон мэдээлэлд чөлөөтэй хандах эрх, Үзэл бодлоо илэрхийлэх, санал бодлоо чөлөөтэй хэлэх эрх, Өөрийн амьдралтай холбоотой шийдвэрийг бие даан гаргах эрх, Шаардлагатай үйлчилгээ, дэмжлэг авах эрх, Бүх төрлийн хүчирхийллээс ангид байх эрх, Хувийн нууц, мэдээллээ хамгаалуулах эрх, Хувь хүний нэр төр, онцлогийг хүндэтгүүлэх эрх, Өмч хөрөнгөө хамгаалуулах эрх, Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх)		Үндсэн хуулиар баталгаажсан хүний үндсэн эрх, бие даан шийдвэр гаргах, эрүүл амьдрах, боловсрол эзэмших, хөдөлмөрлөх болон хөдөлмөрийн суурь эрхүүдийг хангаж, хамгаалсан эсэхийг баталгаажуулах. Түүнчлэн ялгаварлан гадуурхалтаас ангид нийгэмд амьдрах, хувь хүнд тохирсон асаргаа үйлчилгээ болон өөрийн хэрэгцээнд нийцсэн чанартай үйлчилгээ авах, өөрийн сонголтыг хийх, ойлгомжтой мэдээллээр хангагдах, үзэл бодол, асуулт, гомдлоо илэрхийлэх, хувийн нууцаа хамгаалуулах эрхийг мөн адил харгалзан үзэж биелүүлэх. Хэдийгээр хүүхэд хамгаалалтад байгаа ч зарим тохиолдолд хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн эцэг эх, эсвэл гэр бүлийн хүчирхийлэлд холбогдсон этгээд (тухайлбал нөхөр) эх, хүүхдийг хамгаалах байрнаас буцаан гаргаж авахыг шаардах тохиолдол гарч болзошгүй. Ийм нөхцөлд хүүхдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд ханган, "мэдэх эрх"-ийн хэрэгжилтийн хязгаарыг үндэслэл болгон мэдээлэл өгөхийг хязгаарлаж, тухайн шаардлагыг хүлээн зөвшөөрөхгүй байх. Эхнэр, нөхрийн хоорондын зөрчил, маргаанаас үүдэн хүүхдийг хэн асран хамгаалахыг шийдвэрлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал олон гардаг. Ийм нөхцөлд тухайн байдлыг нягтлан үнэлж, хэн нь асран хамгаалах эрхтэйг магадлан тогтоох замаар хүүхдийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргах шаардлагатай. Хэрэв хамааралгүй гуравдагч этгээд энэ талаар мэдээлэл хүсвэл "Энэ мэдээлэл нь мэдээлэх хүрээнд хамаарахгүй" гэж хариулах бөгөөд аливаа мэдээлэл өгөхийг хориглоно.

III. Хүүхдэд ээлтэй орчин					
Ангилал	Дэд ангилал	Шалгуур үзүүлэлт	Зааварчилгаа	Шалгаж тэмдэглэх	Дэлгэрэнгүй
1. Хүүхэд асран хамгаалах орчин	(1) Материаллаг орчин	1) Хүүхэд асрахад тохиромжтой орон зай бүрдсэн эсэх.	① Хүүхдийн өдөр тутмын амьдрал, суралцах дадлыг харгалзан хүүхэд асрах өрөө, талбайг бүрдүүлэхэд анхаарч байгаа эсэх.		Хүүхэд асран хамгаалах орчныг шаардлагатай түвшинд хүргэхэд анхаарч ажиллах.
			② Хүүхэд асрах орон зай, тавилга хэрэгслийг өдөр тутмын асаргаанд нийцүүлэн тохижуулсан эсэх.		Хүүхдийн өндөрт тохируулан өөрчлөх боломжтой сандал, тэдний биед тохирсон ариун цэврийн тавилга хэрэгслийг хүүхэд чөлөөтэй ашиглах боломжтой байх.
			③ Өрөөний тохиромжтой температур, чийгшлийг хангаж байгаа эсэх.		Тохиромжтой температур болон агаар сэлгэлтийн (агааржуулалтын) нөхцөлийг бүрдүүлэх агааржуулагч төхөөрөмжөөр хангах.
			④ Зохих гэрэлтүүлэгтэй эсэх.		Хүүхдийн унтах болон амрах үед гэрлийн тохируулга хийх.
			⑤ Дуу чимээний зохицуулалтыг харгалзан үзэх.		Орчны дуу чимээ, чанга сулд анхаарал хандуулж, нөхцөл байдалд тохируулан нам гүм орчныг бүрдүүлэх.
		2) Хүүхдийн амьдралын хэв маяг, суралцах дадалд нийцсэн хүүхэд асрах орон зай хүрэлцээтэй байгаа эсэх.	① Аюулгүй, тав тухтай орон зай бүрдсэн эсэх.		Амрах, алжаал тайлах орон зай болон цаг хугацааг гаргаж өгөх.
			② Олон талт ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсөн орчин бүрдүүлсэн эсэх.		Сургалтын хэрэглэгдэхүүн, ном, материал нь хүйс, арьс өнгө, нас, хөгжлийн онцлог, соёлын олон янз байдлыг тусгасан эсэх.
			③ Хооллох хангалттай орон зай байгаа эсэх.		Хүүхэд бие даан хооллох боломжтой орчин бүрдсэн эсэх.
			④ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон тэдний асран хамгаалагчдад тохирсон хүртээмжтэй нөхцөлийг бүрдүүлсэн эсэх.		Тэргэнцэртэй иргэдэд зориулсан орц, гарц, ариун цэврийн өрөө байгаа эсэх.

Ангилал	Дэд ангилал	Шалгуур үзүүлэлт	Зааварчилгаа	Шалгаж тэмдэглэх	Дэлгэрэнгүй
1. Хүүхэд асран хамгаалах орчин	(1) Материаллаг орчин	3) Орон нутгийн нөхцөл байдлыг тодорхойлсон эсэх	Хөрш болон ойр орчмын иргэдийн амьдралын хэв маяг, оршин суугчдын насны бүлэг, шилжилт хөдөлгөөний түүх, орон нутгийн соёл, хүүхдийн тоглоомын талбайн хүртээмж, аюулгүй байдал болон тээврийн нөхцөл, мөн хүүхэд асрахтай холбоотой тухайн бүс нутгийн онцлог, холбогдох мэдээллийг тодруулсан эсэх.		Хүүхэд, гэр бүлийн амьдарч буй бүс нутгийн онцлогийг магадлан тогтооход анхаарч, үүний үр дүнд тухайн бүс нутагт хүүхэд асран хамгаалахад шаардлагатай хэрэгцээг тодорхойлох.
	(2) Аюулгүй байдал	1) Аюулгүй байдлыг харгалзан үзсэн эсэх	① Орчны аюулгүй байдал болон хүүхэд амандаа шууд хүргэж болох эд зүйлсийн ариун цэврийн байдлыг ханган ажиллах.		Тоглоом, хэрэглэгдэхүүний материалд анхаарч, тэдгээрийг тогтмол цэвэрлэж, халдваргүйжүүлэх.
			② Хүүхдийн тоглодог орчны (гудамж, зам, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт) аюулгүй байдлыг хангах.		Цэцэрлэгт хүрээлэн, явган хүний зам зэрэг байгууламжийн орчны онцлог, замын хөдөлгөөний нөхцөл байдлыг үнэлнэ. Мөн газруудад хүүхдийн аюулгүй байдал хангагдсан эсэхийг хянах, хүүхдүүд цэцэрлэгээс гадагш гарах үед холбогдох бүртгэл, баримт бичгийг хөтөлж байгаа эсэх.
		2) Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах яаралтай арга хэмжээний дүрэм, журам хэрэгжиж буй эсэх.	① Онцгой нөхцөл байдал үүсэхэд холбоо барих, мэдээлэх журам тогтоож, хэрэгжүүлж буй эсэх.		Цэцэрлэгт онцгой нөхцөл байдал үүсэх үед авах яаралтай арга хэмжээг үйлчлүүлэгчдэд тодорхой мэдээлж, шаардлагатай бол олон нийтийн хэсэгт санамж, мэдээллийг ил харагдахуйц байрлуулах.
			② Асран хамгаалагчийн хаягийг урьдчилан баталгаажуулах (зөвхөн ажлын хаяг төдийгүй төрөл төрөгсдийн хаяг, гар утаснаас гадна холбоо барих бусад мэдээллийг тэмдэглэж авах).		Зарим тохиолдолд асран хамгаалагчийн үндсэн хаягаар шууд холбогдож чадахгүй байх эрсдэлтэй тул нэмэлт холбоо барих мэдээллийг цуглуулна.
			③ Ирж буй хүмүүсийн урсгалыг хянах, шалгаж баталгаажуулах зорилгоор дотоод холбооны (домофон) системийг ашиглах боломжтой эсэх.		Хэн, хэзээ ирсэн, хэзээ буцсаныг хянах тогтолцоог бүрдүүлэх.
			④ Харуул хамгаалалтын төхөөрөмж болон дохиолол суурилуулсан эсэхийг шалгах. Хамгаалалтын компанитай хамтран ажиллах нь илүү үр дүнтэй.		Аюулгүй байдал, хамгаалалтын чиглэлээр ажилладаг байгууллагуудтай хамтран ажиллах ба орон нутгийн цагдаагийн байгууллагатай шууд холбогдсон дохиоллын системтэй байхыг зөвлөж байна.
			⑤ Гамшгийн үеийн яаралтай арга хэмжээг баталгаажуулж, хэрэгжүүлж байгаа эсэх.		Гамшгаас хамгаалах урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахдаа (① болон ⑦ дугаар заалтын дагуу) асран хамгаалагчид болон орон нутгийн эмнэлэг, холбогдох байгууллагуудтай хэрхэн шуурхай холбоо барьж, хамтран ажиллах хариу арга хэмжээний төлөвлөгөөг нарийвчлан тооцож боловсруулах.
			⑥ Гамшгаас хамгаалах сургуулилыг тогтмол зохион байгуулах.		Гамшгаас хамгаалах сургуулилт хийх үед цаашид юуг сайжруулах талаар хамт олноороо хэлэлцэж, үнэлгээ хийнэ. Ингэхдээ сургуулилт хийх дотоод журмыг мөрдлөг болгох бөгөөд оффисын ажилтнуудын оролцоог бүрэн хангаж, онцгой байдлын үеийн нэрсийн бүртгэл, ирц тулгах арга аргачлал нь бодит байдалд хэрэгжих боломжтой эсэхийг нягтах.
			⑦ Тухайн бүс нутгийн эмнэлгийн байгууллагуудын хаяг, байршлын зургийг ил харагдах газар байршуулсан эсэх.		Үйлчлүүлэгч болон мэргэжилтнүүдийн аль алинд нь ойлгомжтой байх нөхцөлийг хангах.
		3) Аюулгүй байдлын талаарх боловсрол олгох сургалт явуулдаг эсэх	Хүүхдүүдийг аюултай нөхцөл байдалд зөв зохистой хариу үйлдэл үзүүлэхийг (жишээлбэл, чанга дуугаар тусламж дуудах, аюулгүй эсвэл олон хүнтэй газар руу очих гэх мэт) зааж сургаж байгаа/ сургасан эсэх.		Сургалтын хөтөлбөрт аюулгүй байдлын боловсролыг тусгасан эсэх.

Ангилал	Дэд ангилал	Шалгуур үзүүлэлт	Зааварчилгаа	Шалгаж тэмдэглэх	Дэлгэрэнгүй
1. Хүүхэд асран хамгаалах орчин	(3) Хүүхэд асрах үйл ажиллагааны үндсэн агуулга	1) Хүүхэд асрах үйл ажиллагаа нь хүүхдийн нас, ялангуяа бага насны онцлогт нийцсэн эсэх	① Хүүхэд хамгаалал, боловсролын хөтөлбөрт суурилсан сургалтын төлөвлөгөө бодитой хэрэгжиж буй эсэх.		Хүүхэд хамгаалал, асаргаатай холбоотой баримт бичгүүд тухай бүр шинэчлэгдсэн эсэхийг шалгаж, баталгаажуулах.
			② Хүүхдийн онцлог хэрэгцээ, шаардлагад тулгуурлан өдөр тутмын үйл ажиллагааг (ялангуяа 0-3 насны хүүхдэд) зохион байгуулж буй эсэх.		Өдөр тутмын амьдралын тогтмол хэмнэл чухал хэдий ч хүүхдийн 24 цагийн амьдралын хэв маягийн төлөвлөлтийг (дэглэмийг) бүрдүүлэхэд анхаарах.
			③ Асран хамгаалагчидтай хамтран ажиллахын зэрэгцээ хүүхдийн өөрийнх нь хөгжлийн хурд, хэмнэлийг орхигдуулахгүй байх.		Хүүхдийн унтах дадал, хэв маягт тулгуурлан унтах (нойр авах) цагийг зохицуулах. Хүүхдийн амьдралын хэмнэлийг тэдний өөрсдийнх нь хүлээж буй амьдралын хэмнэл, дасал болсон хэв маягтай уялдуулан харгалзаж зохицуулах.
			④ Өдөр тутмын үйл ажиллагаанд хамтдаа тоглох цаг болон амрах цагийн тэнцвэрийг хадгалах.		Хүүхдүүд гадаа эсвэл дотор тоглохоо өөрсдөө сонгох боломжтой хувилбарт орчин бүрдсэн эсэх.
			⑤ Хүүхэд асрах орчин нь хүүхдийн хөгжил, сонирхолд нийцсэн эсэх.		Хүүхдүүд хөгжилтэй тоглох орчин (талбай) бүрдсэн эсэх, мөн хангалттай хэмжээний тоглоом, хэрэглэгдэхүүнтэй эсэх.
		2) Асаргаа хүмүүжлийн ажил нь улирал болон бүс нутгийн онцлогт нийцэж байгаа эсэх	① Оройн цагаар зохион байгуулах үйл ажиллагааг цаг улирал болон орон нутгийн онцлогт тохируулан төлөвлөдөг эсэх.		Үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулахдаа цаг, улирал болон орон нутгийн онцлогийг бодитойгоор тусгаж, харгалзан үзсэн эсэх.
			② Ганцаарчилсан уулзалт, арга хэмжээ болон спортын тэмцээнүүдийг асран хамгаалагчдад тохиромжтой цагт зохион байгуулж буй эсэх.		Асран хамгаалагчдыг ганцаарчилсан уулзалт, спорт, соёлын арга хэмжээнд идэвхтэй оролцох боломжоор хангасан эсэхийг нягтлах бөгөөд үүний тулд тэдний боломжит цагт нийцүүлэн уян хатан цагийн зохицуулалт хийсэн эсэх.
		3) Хоол хүнстэй холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээ	① Шим тэжээлийн тэнцвэрт байдал болон улирлын чанартай хүнсийг хэрэглэж буй эсэх.		Улирлын онцлогт нийцсэн хоол хүнс хэрэглэх боломжийг бүрдүүлж, хооллох үеийн харилцан яриагаар дамжуулан хүүхдийн улирлын талаарх ойлголт, мэдлэг, мэдрэмжийг хөгжүүлэх.
			② Хоол хүнсний харшилтай хүүхэдтэй ажиллахдаа асран хамгаалагчийн санал хүсэлтээс гадна эмчийн оношийг заавал харгалзан үзэх.		Хүнсний харшилтай хүүхэдтэй ажиллахдаа эмчийн оношийг дагаж мөрдөнө. Харшлын төрөл, шинж тэмдэг, хоол боловсруулах арга, улирлын онцлогт тулгуурлан зохих шийдлийг боловсруулж, энэ талаар тогтмол уулзалт зохион байгуулах.
			③ Хүүхдийн хооллох дадал хэвшил, ширээний соёлыг төлөвшүүлэх, мөн хоол шилж сонгож идэх хандлагатай хүүхдэд чиглэсэн зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа эсэх.		Хоол шилж сонгож идэх асуудлыг анги болон цэцэрлэгийн түвшинд хэлэлцэх (Хүүхдэд дургүй хоолыг нь албадан идүүлэхгүй, харин хоол үлдээх нь зохисгүй гэдгийг тайлбарлан ойлгуулах).
			④ Хүүхэд тайван, стрессгүй орчинд хооллож чадаж байгаа эсэх.		Хооллох үед тайван, эерэг уур амьсгал бүрдүүлж, чөлөөтэй ярилцах нөхцөлийг хангах.
			⑤ Аяга, халбага, хоолны хэрэгслийн аюулгүй байдлыг хангах.		Хүүхэд өөрийн биед тохирсон ширээ, сандал, аяга таваг зэрэг хоолны хэрэгслийг ашиглах боломжтой байх.
			⑥ Хүүхдийг хоол бэлтгэх болон хоол хүнстэй холбоотой үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулж, хоолны боловсролыг нь дэмжих замаар тэдний сонирхлыг нэмэгдүүлэх.		Хүүхдүүдэд бүх төрлийн хүнсний түүхий эдтэй танилцах, хоол хийж сурах боломжийг олгож, улмаар хоол хүнсэнд дуртай болох сонирхлыг нь хөгжүүлэх.
		4) Ерөнхий боловсролын сургуульд элсэх бэлтгэлийг хангасан эсэх	Ахлах бүлгийн хүүхдүүдийг ерөнхий боловсролын сургуульд элсэхэд нь зориулж амьдралын хэмнэлийг нь зохицуулах тал дээр асран хамгаалагчидтай хамтран ажиллах.		Ерөнхий боловсролын сургуулийн өдрийн дэглэмд дасгахын тулд хүүхдийн цэцэрлэгт байх үеийн амьдралын хэмнэлийг урьдчилан зохицуулах.
					Асран хамгаалагчдыг хүүхдийнхээ өдөр тутмын дэглэмийг боловсруулж, баримтлан ажиллахад нь дэмжих.

Ангилал	Дэд ангилал	Шалгуур үзүүлэлт	Зааварчилгаа	Шалгаж тэмдэглэх	Дэлгэрэнгүй
3. Хүүхэд асаргаа, хамгааллын хүний нөөцийн орчин	(1) Хүүхэд асаргаа хүмүүжүүлэх тогтолцоо	1) Ээлжээр ажиллах тогтолцооны найдвартай байдал бүрэн хангагдсан эсэх	① Ээлжээр ажиллах зохион байгуулалтын хүрээнд ажлыг дараагийн ээлжид тасралтгүй, найдвартай шилжүүлэх боломжтой эсэх.		Ээлж солигдох, ажил хүлээлгэн өгөх үед хүүхэд бүрийн нөхцөл байдал, онцлогийг бүрэн тэмдэглэн үлдээх шаардлагатай. Мэдээллийг орхигдуулахгүй байхыг анхаарахын зэрэгцээ, товч, ойлгомжтой байдлаар тэмдэглэх.
		2) Мэргэжилтнүүдэд зориулсан өөрийн үнэлгээний гарын авлага, журам байгаа эсэх	② Мэргэжилтнүүд өөрийн суурь чадамжтай холбоотой дараах үзүүлэлтүүдийг үнэлнэ. Үүнд: хөндлөнгийн ажиглалт хийх, анхаарал халамж тавих, мөн чанарыг ойлгох, шийдвэр гаргах, ажлын ач холбогдлыг тодорхойлох, уян хатан байдал, бүтээлч сэтгэлгээ, мэдлэг, ур чадвар, итгэлцэл бий болгох, бодит байдлыг шүүн тунгаах чадвар зэрэг багтана.		Дээрх чадамжуудыг хөгжүүлэх, эзэмшихэд чиглэсэн гарын авлага, удирдамж боловсруулж хэрэглэх.
		3) Хариуцсан ажилтнууд мэдээлэл солилцох, хуваалцах тогтолцоо бүрдсэн эсэх	③ Тодорхой нэг мэргэшсэн албан тушаалтны ажлын ачааллыг хөнгөвчлөхийн тулд нэг даалгаврыг зөвхөн нэг хүн биш, олон хүн гүйцэтгэх чадвартай (орлон ажиллах тогтолцоо) байгаа эсэхийг баталгаажуулах.		Нарийн мэргэжлийн албан тушаалтны ажлын ачааллыг бусад ажилтнуудын дэмжлэгтэйгээр хөнгөвчлөх тогтолцоог бүрдүүлж, үүнийг системтэй, зохион байгуулалттай хэрэгжүүлэхэд анхаарах.
		4) Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх нэмэлт сургалтад хамрагдах боломж байгаа эсэх	④ Нэмэлт сургалт зохион байгуулах, эсвэл сургалтад оролцох боломж бүрдсэн эсэх.		Ажилтнуудын мэргэжлийн чадамжийг дээшлүүлэх, мэдлэг, ур чадвар, ёс зүйг хөгжүүлэх зорилгоор ажлын байран дахь болон ажлын байрнаас гадуурх сургалт, түүнчлэн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх бусад сургалтыг зохион байгуулж, сургалтын тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэх
		5) Мэдээллийг зөв бүртгэх, хадгалах, ашиглах менежмент бүрдсэн эсэх	⑤ Тайлан, бүртгэл хөтлөх стандарт маягт байгаа эсэх, мөн тэдгээрийг зөв зохистой байдлаар хэрэглэх, хадгалах боломж байгаа эсэх.		Хурал, судалгааны ажлыг тайлагнах маягыг тогтоож, тогтмол хэрэглэх бөгөөд зөвлөгөө, санал солилцооны үед үр дүнтэй шийдлийг тодорхойлон баримтжуулах.
		6) Гомдол, санал хүсэлтийг хэрхэн шийдвэрлэдэг эсэх	⑥ Санал хүсэлт, хууль бус үйлдэл болон гомдол маргааныг хүлээн авах шийдвэрлэх боломжууд бүрдсэн эсэх.		Цэцэрлэгийн дотоод асуудлыг (гомдол, маргааныг) хөндлөнгийн хараат бус талын оролцоотойгоор шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж, гарсан шийдвэрийг асран хамгаалагчдад мэдээлэх.
		7) Хараат бус, баримт нотолгоонд тулгуурласан (объектив) үнэлгээ хийгдсэн эсэх	⑦ Хөндлөнгийн буюу гуравдагч этгээдийн хараат бус үнэлгээ хийгдсэн эсэх.		Хараат бус хөндлөнгийн үнэлгээг цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг сайжруулах боломж гэж үзэж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх. Мөн хөндлөнгийн үнэлгээтэй холбоотой гарын авлага, материалыг ашиглан өөрийн үнэлгээг хийх нөхцөлийг бүрдүүлэх.
	(2) Мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа	Бүх ажилтан, мэргэжилтнүүдийн хооронд харилцаа, мэдээлэл солилцох боломж бүрдсэн эсэх	Удирдлага, тогооч болон ажилтнуудын хооронд тогтмол харилцах, уулзах боломж, орчин бүрдсэн эсэх		Хурал, уулзалтын сэдэв, хэлбэр нь олон янз байж болно. Жишээлбэл: ахлах багш нарын болон анги удирдсан багш нарын хурал, мэргэжлийн зөвлөгөөн, хоол хангамжийн уулзалт, дотоод хурал, семинар зэрэг багтана.


IV. Байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх					
Ангилал	Дэд ангилал	Шалгуур үзүүлэлт	Зааварчилгаа	Шалгаж тэмдэглэх	Дэлгэрэнгүй
1. Сүлжээ бий болгох	(1) Байгууллагын хамтын ажиллагаа	1) Ажилтнууд мэргэжлийн ур чадварынхаа дагуу хариуцлагыг хуваалцаж буй эсэх.	① Бусад байгууллага, институцийн өнөөгийн нөхцөл байдал, онцлогийг харгалзан үзэж, хүндэтгэлтэйгээр хамтран ажиллаж байгаа эсэх.		Даатгал, эрүүл мэнд, нийгмийн халамжаас гадна боловсрол, хууль эрх зүй, хүүхэд асаргааны чиглэлийн дэмжлэг үйлчилгээний хүрээ, хэрэглээг сайтар ойлгох хэрэгтэй. Мөн үйлчилгээний цаг, хариуцах нэгж, шаардлагатай бичиг баримтын бүрдүүлэлтийн талаарх мэдээллийг цуглуулж ажиллах.
					Орон нутгийн холбогдох байгууллагуудын чиг үүрэг, холбоо барих болон үйлчилгээний цагийн мэдээллийг нэгтгэн жагсааж, харагдахуйц байдлаар байршуулан ажилтнуудад мэдээлэх.
					Гарч болзошгүй онцгой байдлын (гэнэтийн өвчлөл, осол, хэрэг зөрчил, гал түймэр, газар хөдлөлт г.м) жагсаалтыг гаргаж, хамтран ажиллах байгууллагуудын (ялангуяа эмнэлэг, гал унтраах анги, цагдаагийн хэлтэс) мэдээллийг ил харагдахуйц газар байршуулан, цэцэрлэгийн дотоод бэлэн байдлын тогтолцоог бүрдүүлэх.
					Аюулгүй байдлыг хангах үүднээс харуул хамгаалалтын байгууллага болон орон нутгийн цагдаагийн хэлтэс, тасгайтай хамтын ажиллагаа тогтоож, тогтмол эргүүл ажиллуулан, яаралтай үед хэрхэн дэмжлэг авах талаар тодорхой ойлголт, мэдлэгтэй байх.
					Хамтран ажиллагсдаа хүндэтгэн, ёс зүйн хэм хэмжээг баримтлан, харилцан ойлголцолд тулгуурлан ажиллах.
					Хамтран ажиллаж буй мэргэжилтнүүдэд хүүхэд асаргааны уртасгасан цагийн нөхцөл байдал (хүүхэд, асран хамгаалагч, ажилтан), үйлчилгээний агуулга (асаргааны цаг, хонуулах асаргаа, яаралтай асаргаа, түр асаргаа, өвчтэй болон эдгэрч буй хүүхдийн асаргаа), цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдүүдийн мэдээлэл (нас, хүүхдийн тоо г.м) болон хэрэглэгчийн (асран хамгаалагч) талаар тайлбарлан танилцуулах.
		② Мэргэжилтнүүдийн оролцоог хангасан хамтын ажиллагаанд анхаарал хандуулж байгаа эсэх.			Тогтмол уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулснаар мэргэжилтэн бүрийн чиг үүргийг илүү нарийвчлан таньж мэдэх боломжтой. Энэ нь бие биенийхээ боломж, хязгаарлагдмал байдлыг харгалзан үзэж, ажлын хуваарилалтыг тодорхой болгоход дэмжлэг болно.
					Онцгой нөхцөл байдлын үед цагдаа, гал унтраах анги, хамгаалалтын албатай хэрхэн холбогдох талаар мэдлэгтэй байх, мөн тогтсон хамтын ажиллагааны зохицуулалтыг бүх ажилтнууд тодорхой ойлгосон байх
					Орон нутгийн дэмжигчид (сайн дурынхан)-ийг хүлээн авч, хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлэх. Түүнчлэн цэцэрлэгийн үйл ажиллагаанд тэднийг оролцуулах замаар өдөр тутмын хүүхэд асаргааны талаар бусад хүмүүстэй санал солилцох боломжийг олгох.
					Сайн дурынхан болон ТББ-уудтай хамтран ажиллахдаа тэдний оролцоог идэвхжүүлж, үйл ажиллагаанд туслах хүрээг нь тэлэхэд анхаарна. Ялангуяа, уртасгасан цагийн хүүхэд асаргааны үйлчилгээг олон нийтэд зөв таниулж, хамтын ажиллагааны дэмжлэгийг өргөжүүлэх.

Ангилал	Дэд ангилал	Шалгуур үзүүлэлт	Зааварчилгаа	Шалгаж тэмдэглэх	Дэлгэрэнгүй
1. Сүлжээ бий болгох	(I) Байгууллагын хамтын ажиллагаа	2) Мэдээлэл харилцан солилцож байгаа эсэх	Хамтын ажиллагаанд шаардлагатай мэдээллийг эрдэм шинжилгээний хурал, уулзалтын үеэр мэргэжилтнүүдтэй бичгээр болон аман хэлбэрээр үр дүнтэй, солилцож байгаа эсэх.		Баримтжуулалт, тэмдэглэл хөтөлтийн хэлбэр нь ойлгомжтой, хялбар байхын зэрэгцээ үзүүлэх дэмжлэг, үйлчилгээний агуулга нь уян хатан байна. Мөн ашиглаж буй нэр томъёо, хэллэгийн талаар нэгдсэн нэг ойлголттой байх.
					Мэргэжилтнүүд тогтмол мэдээлэл солилцох боломжийг хангаж, уулзалтын байр, орчныг бүрдүүлсэн байх.
					Хамтын ажиллагааны хүрээнд уртасгасан цагийн үйлчилгээгээр ямар тусламж, асаргаа үзүүлэх боломжтойг тодорхой болгоно. Мөн уулзалтын байр талбайн ашиглалт, бүлгийн болон олон нийтийн үйл ажиллагаа, цахим хуудасны мэдээллийг холбогдох байгууллагуудтай харилцан солилцоно.
					Мэргэжилтнүүд уулзалт, хэлэлцүүлгийг аман болон бичгийн хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулах нөхцөл боломж, холбогдох техник, технологиор хангагдсан байх.
					Хамтын ажиллагаанд шаардлагатай мэдээллийг зөвхөн үзүүлэх тусламж, үйлчилгээний зорилгод нийцүүлэн хамгийн бага хэмжээнд бүрдүүлэх бөгөөд мэдээлэл цуглуулахад хэт төвлөрөхөөс зайлсхийх.
		3) Хэрэглэгчийн өөрөө шийдвэр гаргах чадварыг дэмжих	Хэрэглэгчдийн хүсэл, сонголтыг хүндэтгэж, хамтын ажиллагааны агуулга, хэлбэрийн талаар дэлгэрэнгүй тайлбар өгч байгаа эсэх.		Харилцан итгэлцэлд суурилсан эерэг харилцааг бүрдүүлж, хэрэглэгчидтэй нээлттэй харилцах, санал бодлоо илэрхийлэх боломжоор хангах.
					Мэдээлэл цуглуулах, солилцох талаар урьдчилан тайлбарлаж, зөвшөөрөл авах бөгөөд ингэхдээ агуулгыг хамгийн ойлгомжтой хэлбэрээр хүргэж, мэргэжлийн хүнд нэр томъёо хэрэглэхээс татгалзах.
		4) Хэрэглэгчийн өөрөө шийдвэр гаргах чадварыг дэмжих	① Хэрэглэгчдийн хүсэл, сонголтыг хүндэтгэж, хамтын ажиллагааны агуулга, хэлбэрийн талаар дэлгэрэнгүй тайлбар өгч байгаа эсэх.		Хэрэглэгчийн хүсэл, сонголтод нийцүүлэн хүссэн үед нь хэлэлцүүлэг хийх боломжийг бүрдүүлнэ. Тэдний яриаг анхааралтай сонсож, туршлага, хүсэл зорилго, үнэт зүйлсийг нь ойлгохыг эрмэлзэх.
					Уртасгасан цагийн үйлчилгээнд хамрагдаж буй эцэг эх, асран хамгаалагчдын ажлын хуваарийг харгалзан, уулзалт, ярилцлага хийх тохиромжтой цагийг товлох.
					Эцэг эх, асран хамгаалагчдын орон нутгийн болон амьдарч буй орчны онцлогт тохирсон дэмжлэг, үйлчилгээ үзүүлэхэд анхаарч, тэдний хэрэгцээ, боломжийг харгалзан үзэх.
			② Эцэг эх, асран хамгаалагч, хэрэглэгчдэд өөрсдийн хүсэл, сонголтод үндэслэн үйлчилгээ сонгох боломж олгож байгаа эсэх		Үйлчилгээг сонгох шийдвэр нь зөвхөн хэрэглэгчийн өөрийнх нь эрх гэдгийг санаж, тэд өөрсдийн хүслээр сонголтоо хийхэд шаардлагатай мэдээллээр хангах.
					Өдөр тутмын амьдралд тохиолдож буй гэр бүлийн асуудлын талаар нээлттэй харилцах нь чухал болохыг эцэг эх, асран хамгаалагчдад ойлгуулахад анхаарна. Улмаар тухайн асуудлыг шийдвэрлэх гол оролцогчийг (шийдвэр гаргах хүнийг) тодорхойлж, тэдний оролцоотойгоор оновчтой шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх.
					Ижил асуудалтай бусад эцэг эх, асран хамгаалагчид хоорондоо холбогдох боломжийг бүрдүүлэх. Улмаар тэд бие биедээ урам зориг өгөх, дэмжлэг үзүүлэх, туршлага, мэдээлэл хуваалцах замаар асуудлаа хамтран шийдвэрлэхэд нь чиглүүлэх.
		5) Уян хатан хамтын ажиллагаа явуулж байгаа эсэх	Чин сэтгэлээсээ хамтран ажиллах зарчмыг баримталж, хамтын ажиллагааг нэг удаагийн уулзалтаар хязгаарлахгүй, тасралтгүй үргэлжлүүлэх.		Орон нутгийн хэлэлцүүлэг болон оршин суугчдын өдөр тутмын хамтын үйл ажиллагаанд оролцох замаар иргэд, гэр бүл хоорондын холбоо харилцааг бэхжүүлэх.
					Ажилчдын асаргаа үйлчилгээнд гарах ээлж, цагийн хуваарь болон хөтөлбөрийн агуулга зэрэг өдөр тутмын ерөнхий мэдээллийг урьдчилан бэлтгэх.
					Шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах нөхцөлүүдийг хэлэлцэж, байгууллага болон мэргэжилтэн бүрийн үүргийг тодорхойлон, цаашид үзүүлэх тусламжийн чиглэлийг баталгаажуулах.
					Тогтмол уулзалтаас гадна гар утас, факс, интернет зэрэг өдөр тутмын харилцааны бусад сувгийг ашиглах боломжийг бүрдүүлэх.
					Лавлагаа, хүсэлтийг хариуцах хариуцлагатай ажилтныг томилж, тухайн ажилтан бусад байгууллагуудтай тогтмол харилцах, тогтвортой ажиллах нөхцөлийг хангах. Хариуцсан ажилтан байхгүй тохиолдолд орлон ажиллах зохицуулалтыг хийх.

Ангилал	Дэд ангилал	Шалгуур үзүүлэлт	Зааварчилгаа	Шалгаж тэмдэглэх	Дэлгэрэнгүй
1. Сүлжээ бий болгох	(2) Үйл ажиллагааг үнэлэх	1) Хүүхэд болон гэр бүлд гарсан өөрчлөл-түүдийг мэдэж байгаа эсэх.	Үйлчилгээнд хамрагдсанаар хүүхэд болон гэр бүлд ямар өөрчлөлт гарсныг бүрэн ойлгож, энэ нь цаашдын оновчтой тусламж үйлчилгээнд нөлөөлж чадаж байгаа эсэх.		Үйлчлүүлэгчдийн бие махбод болон сэтгэцийн эрүүл мэндийн нөхцөл байдлыг тодруулж, холбогдох тэмдэглэлийг хөтлөх.
					Хүүхэд болон асран хамгаалагчийн нөхцөл байдалд гарч буй аливаа өөрчлөлтийг орхигдуулахгүйгээр тэмдэглэж, дэмжлэгийн үйлчилгээг хүүхдийн хэрэгцээнд тулгуурлан үзүүлэх.
					Үйлчлүүлэгчийн мэдээлэл болон дэмжлэгийн үйл явцыг тухай бүрт нь бүртгэн, хариуцсан ажилтантай хамтран баталгаажуулах.
					Уулзалтын үеэр 1-3 дугаар заалтын дагуу гарсан өөрчлөлтүүдийг (хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдал болон хувийн онцлогт гарсан хувирал) өмнө нь тохиролцсон холбогдох байгууллагуудад тайлагнаж, үзүүлж буй тусламж үйлчилгээг дахин үнэлэх замаар шаардлагатай зохицуулалт, тохируулгыг хийх.
		2) Хувь хүний онцлог, ялгаатай байдлыг харгалзан үзэж байгаа эсэх	Хүүхэд болон гэр бүлийн онцлог, ялгаатай байдлыг харгалзан үзэх замаар үзүүлж буй тусламж үйлчилгээгээ үнэлж байгаа эсэх.		Хүүхэд, гэр бүл бүр давтагдашгүй бөгөөд өөрийн онцлогтой тул үйлчилгээ авагчдыг анхааралтай сонсож, тэдний хүсэл сонирхол, зорилго тэмүүлэл, үнэт зүйлс, итгэл үнэмшил, соёлын онцлогийг ойлгон хүндэтгэж харилцах.
					Уртасгасан цагийн үйлчилгээний явцад хүүхдийн нөхцөл байдал болон асран хамгаалагчийн хөдөлмөр эрхлэлт, амьдралын хэв маягийн харилцан адилгүй байдлыг харгалзан үзэж, уян хатан хандах.
		3) Хувь хүний онцлог, ялгаатай байдлыг харгалзан үзэж байгаа эсэх	Дэмжлэгийн үйл ажиллагааг үнэлэхдээ хүүхэд болон гэр бүлийн ялгаатай хэрэгцээ, онцлогийг харгалзан үзэж байгаа эсэх.		Хүүхэд болон асран хамгаалагч бүрийн кейс (нөхцөл байдал), хүсэл, хэрэгцээг урьдчилан тогтоосон маягтын дагуу бүртгэх.
					Өөрчлөлт гарсан тохиолдолд тайланг тухай бүр шинэчилж, өөрчлөлтийн явцыг ойлгомжтойгоор баримтжуулах.
					Хүүхэд болон гэр бүлийн онцлогтой холбоотой мэдээллийг мэргэжилтнүүд хоорондоо хуваалцаж, үйл ажиллагаандаа ашиглах.
		4) Санал хүсэлтийг хүлээн авч, хэрэгжүүлэн, эргэх холбоотой ажиллаж байгаа эсэх	Үйлчлүүлэгчийн нөхцөл байдал, үр дүнг үнэлж баталгаажуулсны дараа, шаардлагатай тохиолдолд дэмжлэгийн төлөвлөгөө боловсруулж байгаа эсэх. Мөн нөхцөл байдалд нь тохируулан тусламж үйлчилгээний арга барилаа сайжруулж ажиллах.		Үйлчилгээ авагчдын нөхцөл байдлыг тогтмол болон тухай бүрд нь хянаж, шаардлагатай тохиолдолд дэмжлэг тусалцааг уян хатан байдлаар зохицуулж ажиллах.
2. Хүүхдийн эрх, хамгаалал	(1) Хамтын ажиллагааны хүрээнд хүүхдийн эрх ашгийг хамгаалах	1) Үйлчлүүлэгчдийн эрх ашиг, ашиг сонирхлыг харгалзан үзэж, холбогдох хариу арга хэмжээг авч байгаа эсэх	Байгууллагын мэргэжилтэн бүр хүүхэд болон гэр бүлийн эрх ашгийг хамгаалахын тулд хүчин чармайлт гарган ажиллаж байгаа эсэх		Хамтын ажиллагааны явцад хүүхэд болон гэр бүлд хамаарах эрхийн талаар ойлгомжтой, дэлгэрэнгүй мэдээлэл өгөх.
					Хүүхэд, гэр бүлийн аюулгүй байдал эрсдэлд орсон тохиолдолд цагдаа, эмнэлэг, халамж, хүүхэд хамгааллын байгууллагуудтай шуурхай холбогдож ажиллах.
					Хүүхэд хүчирхийлэл, дарамтад өртсөн эсэх нь тодорхойгүй буюу эргэлзээтэй тохиолдолд хувийн таамаглал дэвшүүлэхгүйгээр цагдаа, шүүх болон хүүхэд хамгааллын байгууллагуудтай нэн даруй хамтран ажиллах. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь хүүхэд, эцэг эхийн эрх, ашиг сонирхлыг ямагт хүндэтгэж, тэдний аюулгүй байдлыг хангах, дэмжлэг үзүүлэхэд үргэлж бэлэн байх хэрэгтэй.
					Холбогдох байгууллага, орон нутгийн засаг захиргааны мэргэжилтнүүд нь үйлчилгээ авагчдын хэрэгцээг тогтмол тодорхойлж, тэднийг шаардлагатай тусламж, үйлчилгээгээр хангах үүрэгтэй.

Ангилал	Дэд ангилал	Шалгуур үзүүлэлт	Зааварчилгаа	Шалгаж тэмдэглэх	Дэлгэрэнгүй
2. Хүүхдийн эрх, хамгаалал	(1) Хамтын ажиллагааны хүрээнд хүүхдийн эрх ашгийг хамгаалах	2) Мэргэжилтнүүдийн хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байгаа эсэх	Хүүхэд болон гэр бүлийн эрхийг хамгаалах чиглэлээр сургалт, семинар зохион байгуулж, хүний эрхийн ойлголтыг түгээн дэлгэрүүлэхэд анхааран ажиллаж байгаа эсэх		Эрх хамгааллын чиглэлээр зохион байгуулагддаг байгууллагаас гадуурх сургалтад хамрагдах боломж бүрдүүлэх. Сургалтад оролцох явцад ажил үүргийг оновчтой хуваарилж, орлон гүйцэтгэх зохицуулалтыг хийж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах.
					Гаднын сургалтаас олж авсан мэдлэг, мэдээллээ дотоод сургалт, семинараар дамжуулан ажилчидтайгаа хуваалцах. Сургалтын тайлан, хураангуй мэдээллийг нээлттэй хадгалж, танилцах боломжоор хангах.
					Өдөр тутмын хүүхэд асаргаа, сургалтын үйл ажиллагаандаа үйлчилгээ авагчдын эрхийг дээдэлж, хүндэтгэх зарчмыг баримтлах.
					Бүхий л үйл ажиллагаагаа хүүхдийн эрхийг хамгаалах, дээдлэх үзэл баримтлал, зарчимд нийцүүлэн явуулах.
		3) Хувийн нууцыг хангалттай түвшинд хамгаалж байгаа эсэх	① Нууцлалын зарчмыг мөрдөн хэрэгжүүлж буй эсэх		Үйлчилгээ үзүүлэх хугацаанд олж авсан хэрэглэгчийн мэдээллийг бусдад задруулахгүй байх.
					Хувийн мэдээллийг хуваалцах шаардлага гарвал энэ тухай дэлгэрэнгүй тайлбарлаж, үйлчилгээ авагчаас урьдчилан зөвшөөрөл авах.
					Хамтын ажиллагааны явцад зөвхөн үйл ажиллагааны зорилгод нийцсэн шаардлагатай мэдээллийг бусадтай хуваалцах.
			② Хувийн мэдээллийг бүрэн хамгаалахын тулд мэдээллийн менежментийн тогтолцоог зохих ёсоор мөрдөж буй эсэх.		Онцгой анхаарал шаардсан мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг чухалчлан хамгаалах.
					Үйлчилгээ авагчийн мэдээллийг тогтоосон газарт хадгалж, хариуцсан ажилтныг томилно. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс хадгалах байршлыг зөвхөн эрх бүхий ажилтнуудад хязгаарлан мэдэгдэж, хаалга түгжих зэрэг хамгаалалтын горимыг чанд мөрдөнө. Мэдээллийг байгууллагын гадна авч гарахыг хатуу хориглоно.
					Хурал, уулзалт хийх үед хүүхэд, эцэг эхийн хувийн мэдээллийг бусдад задруулахгүй байх дүрмийг чанд мөрдөх.

1. Anme T., McCall M. Culture, Care and Community Empowerment: International Applications of Theory and Methods, Kawashima Press, 2008
2. Anme T. Intergenerational Activities and Aging Well: Plasticity as a Fundamental Strength of Lifespan Development, Systems Sciences for Health-Social Services, 21(2), 2015
3. Anme T., The Science of Empowerment Standing by the Brilliance of Life: New ways to live together where everyone is a hero, Kitaojishobo, 2014
4. Anme T., New Empowerment Models on Practical Strategies for Wellbeing, Nova Science Publications, 2016
5. Anme T., Tanaka E., et al., Parent-child Interactions and Child Social Competence: Longitudinal Evidence Using the Interaction Rating Scale (IRS), Nova Science Publications, 2016
6. Yusuke Takahashi, Kensuke Okada, Takahiro Hoshino, Tokie Anme, Developmental Trajectories of Social Skills during Early Childhood and Links to Parenting Practices in a Japanese Sample, PLOS ONE, 2015
7. Taeko Watanabe, Emiko Tanaka, Etsuko Tomisaki, Tokie Anme, A web-based application for improving childcare quality: A longitudinal study, WECC2015, 2015
8. Anme T., Tanaka E., et al., Validating the Effects of Inclusive Childcare with the Interaction Rating Scale, Education, 4(2), 2014
9. Sugisawa Y., Matsumoto M., Anme T., et al., Strengths and Difficulties of 30-month-olds and Features of the Caregiver-Child Interaction, Journal of Health Science, 3(2), 2013
10. Anme T., et al., Validity and Reliability of the Social Skill Scale (SSS) as an Index of Social Competence for Preschool Children, Journal of Health Science, 3(1), 2013
11. Anme T., Tanaka E., et al., Validity and Reliability of the Index of Child Care Environment (ICCE), Public Health Frontier, 2(6), 2013
12. Tanaka E., Anme T., et al., Factors related to Social Competence Development of thirty-month-olds: Longitudinal Perspective, Japanese Journal of Human Science of Health-Social Services, 19(1), 2012
13. Anme T., et al., Validity and Reliability of the Interaction Rating Scale between Children (IRSC) by Using Motion Capture Analysis of Head Movement, Public Health Research, 2(6), 2012
14. Anme T., Tomisaki E., et al., Health of school-aged children in 11+ hours of center-based care, Creative Education, 3(2), 2012 Anme T., et al., Does night care affect development? A five-year follow-up, Education, 2(5), 2012
15. Tong L., Anme T., et al., Early development of empathy in toddlers: Effects of daily parent-child interaction and home rearing environment, Journal of Applied Social Psychology, 42, 2457–2478, 2012
16. Shinohara R., Anme T., et al., Factors related to social competence development of eighteen-month toddlers: longitudinal perspective focused on “praise” of parenting in four and nine-month infants, Journal of Japanese Human Sciences in Health and Social Services, 16(1), 31–42, 2010

- 
17. Shinohara R., Anme T., et al., Trajectories of children's social competence and the caregiver's attitude of "praise": longitudinal perspective, *Journal of Epidemiology*, 20, 143–149, 2010
 18. Sugisawa Y., Anme T., et al., Validity and reliability of Interaction Rating Scale as an index of social competence, *Journal of Japanese Human Sciences in Health and Social Services*, 16(1), 43–56, 2010
 19. Sugisawa Y., Anme T., et al., Parenting and social competence of toddlers: longitudinal perspective, *Journal of Epidemiology*, 20, 459–465, 2010
 20. Tong L., Anme T., et al., Relations of children's individual factors of intelligence development to the emotional and behavioral problems of first grader, *Journal of Epidemiology*, 20, 466–471, 2010
 21. Tanaka E., Anme T., et al., Implication of social competence development among thirty-month toddlers: focused on theory of mind, *Journal of Epidemiology*, 20, 447–451, 2010
 22. Tomisaki E., Anme T., et al., Social competence development and sleep habits: longitudinal perspective, *Journal of Epidemiology*, 20, 435–440, 2010
 23. Anme T., et al., Child development and childcare in Japan, *Journal of Early Childhood Research*, 8(2), 193–210, 2010
 24. Anme T., et al., Trajectories of social competence by using Interaction Rating Scale (IRS) as an evidence-based practical index of children's social skills and parenting, *Journal of Epidemiology*, 20, 419–426, 2010
 25. Anme T., et al., Effectiveness of Japan's extended/night childcare: A five-year follow up, *Procedia Social and Behavioural Sciences*, 2, 5573–5580, 2010

Evidence based Child Care: Empower Skills for Child Care Professionals:

<http://childnet.me/eindex.html>

Community Empowerment for Well-being and Healthy Longevity:

<http://plaza.umin.ac.jp/~empower/cec/en/>

Empowerment for Child Development and Child Care:

<http://plaza.umin.ac.jp/~empower/ecd/en/>

НОМ ЗҮЙ (IV Бүлгийн нэмэлт)

1. Ahnert, L., Lamb, M. E., & Seltenheim, S., Child care and non-maternal care: The role of family environment, *Journal of Child Psychology and Psychiatry*, 47(11), 1145–1152, 2006.
2. Anme, T., et al., Effectiveness of Japan's extended/night childcare: A five-year follow up, *Procedia Social and Behavioural Sciences*, 2, 5573–5580, 2010.
3. Bandura, A., *Self-efficacy: The exercise of control*, W. H. Freeman, New York, 1997.
4. Bradley, R. H., & Corwyn, R. F., Socioeconomic status and child development, *Annual Review of Psychology*, 53(1), 371–399, 2002.
5. Bronfenbrenner, U., *The Ecology of Human Development: Experiments by Nature and Design*, Harvard University Press, 1979.
6. Г.Амарсанаа, Токи Анмэ., Хүүхэд өсгөн хүмүүжүүлэх орчны индексийг ашиглах боломж ба хүчин төгөлдөр байдал, *Судалгааны тайлан*, Улаанбаатар, 2020.
7. Wallerstein, N. B., What is the evidence on effectiveness of empowerment to improve health? *World Health Organization (WHO)*, Copenhagen, 2006.
8. Zimmerman, M. A., Empowerment theory: Psychological, organizational and community levels of analysis, *Handbook of Community Psychology*, 43–63, 2000.

ЗОХИОГЧ

Профессор Токи Анмэ, PhD

Япон улсын Цүкүба Их Сургуулийн Анагаах ухааны факультетийн Хүчирхэгжих ухаан, Олон улсын хүний хөгжил судлалын тэнхимийн профессор,

Эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний систем судлалын олон улсын нийгэмлэгийн ерөнхийлөгч,

Японы эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ, хүн судлалын шинжлэх ухааны нийгэмлэгийн тэргүүн.

СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД

Хэрэгжилтийн багийн гишүүд

Хироши Танака, Хацүэ Сакай, Кацунобу Миязаки, Каору Амахиса, Шиничиро Эдамото, Гишу Сакай, Юко Кидо, Акио Кобаяши.

Японы Шөнийн Хүүхэд Асран Хамгаалах Мэргэжилтнүүдийн Холбоо

Хүүхэд асаргаа судлалын нийгэмлэг

Судлаачид

Таэко Ватанабэ, Ph.D., Эмико Танака, Ph.D., Эцүко Томисаки, Ph.D., Рёожи Шинохара, Ph.D., Юка Сүгисава, Ph.D., Юко Савада, Ph.D., Лиан Тонг, Ph.D., Юкико Мочизүки, Ph.D., Байлян Ву, Ph.D., Ган-Ядамын Амарсанаа, Ph.D., Маки Хирано, Ph.D., Кэнтаро Морита, Ph.D., Ёко Онда, Юри Яүчи, Маюми Нанда, Мисака Мацүмото, Чихиро Сүгита, Шиори Ариока, Куми Ватанабэ, Күнъен Ким, Сүн Юньсинь, Жу Жу, Чэн Вэнькань, Кейко Като, Ханаэ Ито, Аяка Камата, Мики Саката, Мейрянда Хилда, Юри Нурдиантами, Оуян Линлин, Ян Яшу, Чихиро Сано, Жян Жүньюй, Жао Хэ, Юй Хүйжуань, Сүн Жиньин, Томоми Тошино, Ая Цүбота, Вэй Чэнь, Лю Хайхан, Чэнь Панпан.

IV БҮЛГИЙН ЗОХИОГЧ

Ган-Ядамын Амарсанаа, PhD

Судлаач, Био-Анагаахын Шинжлэх Ухааны Доктор

Хүүхэд Хөгшдийг Ивээх Төвийн Тэргүүн

